



Монгол Улсын Их Сургууль  
ҮНДСЭН ХУУЛИЙН  
ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН

**ML** | MAHONEY  
LIOTTA

# ШАШИН ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨ (ЭМХЭТГЭЛ)

2022

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх  
зүйн хүрээлэн

Махони Лиотта  
ХХН

# **Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө (эмхэтгэл)**

2022



## **Профессор Элизабет А.Кларк**

Хатагтай Элизабет А.Кларк нь "Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага"-ын Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх зөвлөх хэсгийн гишүүн (2022-2025) юм. Профессор Кларк нь Зүүн Европын шашны эрх чөлөө, харьцуулсан эрх зүй, шашны чиглэлээр мэргэшсэн судлаач бөгөөд 40 гаруй өгүүлэл, нийтлэл бичиж, Орос-Украины мөргөлдөөний үеийн шашин, пост-коммунист Европ дахь хууль ба шашин зэрэг хэд хэдэн номыг хамтран бичиж, хянан засварласан байна.

Профессор Кларк АНУ-д болон олон улсын радио, олон нийтийн телевизийн шоу нэвтрүүлэг, *The National Review*, *SCOTUSBlog* зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч байсан. Тус төвтэй хамтран ажиллах үеэрээ тэрбээр НҮБ болон ЕАБХАБ-ын форумд оролцож, дэлхийн хэмжээнд 100 гаруй эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл тавьжээ.

Тэрээр мөн шашин шүтэх эрх чөлөөний асуудлаар АНУ-ын Конгресс болон АНУ-ын Олон улсын шашны эрх чөлөөний комисст тус тус мэдүүлэг өгч, 10 гаруй орны шашин шүтлэгийн эрх чөлөөг хөндсөн хууль тогтоомжид дүн шинжилгээ хийх ажилд оролцож, АНУ-ын Дээд шүүхэд шашин шүтлэгийн эрх чөлөөний асуудлаар мэдээлэл (*amicus briefs*) өгч байв.

Профессор Кларк БЮУ-ын Хууль, шашин судлалын олон улсын төвд ажиллахын зэрэгцээ Бригам Яонгийн их сургуулийн Хууль зүйн сургуульд Мэргэжлийн хариуцлагын хичээлийг заахаас гадна Харьцуулсан эрх зүй, Харьцуулсан үндсэн хуулийн эрх зүй, Олон улсын хүний эрх, Европын Холбооны эрх зүй зэрэг хичээлүүдийг хамтран зааж байжээ. Профессор Кларк орос, чех хэлээр чөлөөтэй ярьдаг бөгөөд франц, герман хэлний мэдлэгтэй.

Профессор Кларк Хуулийн сургуульд багшлахаасаа өмнө Вашингтон ДС-д давж заалдах болон хяналтын шатны журмаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулж байсан. Профессор Кларк мөн АНУ-ын есдүгээр тойргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ж.Клиффорд Уоллесын туслахаар */clerk/* ажиллаж байжээ. Тэрээр *BYU*-ийн хуулийн сургуулийг онц */summa cum laude/* төгссөн бөгөөд тэндээ "*BYU Law Review*" сэтгүүлийн ерөнхий редактораар ажиллаж байжээ.

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн  
& Махони Лиотта ХХН

*Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө (эмхэтгэл)*

Редакторлаж эмхэтгэсэн: О.Мөнхсайхан, Э.Дөлгөөн  
Тусалсан: С.Бат-Орших, Т.Эмүжин, Т.Лхагважаргал

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан болно. Бүтээлийг бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, нийтлэх, микрофильм хийх, электрон системд оруулах, бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулахыг хориглоно.

# Агуулга

## **Элизабет А. Кларк: Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) болон Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төсөл (2018)-д хийсэн дүн шинжилгээ** ..... 1

I. Товч хураангуй	1
Дүн шинжилгээний судлагдахуун	1
Хэрэглэгдэх стандартууд	1
1993 оны Хууль дахь анхаарах гол асуудлууд	2
Хуулийн төслийн эерэг талууд ба цаашид анхаарах асуудлууд	3
II. Хуульд тулгарч буй асуудлуудын дүн шинжилгээ	5
A. Шашин эсхүл итгэл үнэмшилтэй байх буюу болох эрх	5
а. Бүртгүүлэхэд зайлшгүй бус шаардлага тавьсан нь	5
1. 1993 оны Хууль	6
2. 2018 оны Хуулийн төсөл	9
B. Шашны илэрхийлэл	14
а. Шашны итгэл үнэмшлээ хуваалцахад тавьсан хязгаарлалт	14
1. 1993 оны Хууль	14
2. 2018 оны Хуулийн төсөл	17
б. Шашны ном зохиолд тавьсан хязгаарлалт	24
1. 1993 оны хууль	24
2. Хуулийн төсөл	26
B. Өөрийгөө засаглах эрх	28
1. 1993 оны хууль	28
2. Хуулийн төсөл	30
Г. Хэт хяналт ба бүрхэг байдал	35
1. 1993 оны хууль	35
2. Хуулийн төсөл	37

<b>О.Мөнхсайхан: Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө</b> .....	43
<b>Хавсралт</b> .....	55
Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948).....	55
Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) .....	56
Монгол Улсын Үндсэн хууль (1992) .....	58
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт (1994.01.12, №02).....	59
Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хууль (1993).....	65
Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал (2018).....	71
“Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төслийн тухай танилцуулга (2018) .....	81
Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай Монгол Улсын хуулийн төсөл (шинэчилсэн найруулга, 2018).....	86

# **Элизабет А. Кларк: Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) болон Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төсөл (2018)-д хийсэн дүн шинжилгээ<sup>1</sup>**

## **I. Товч хураангуй**

### **Дүн шинжилгээний судлагдахуун**

Энэхүү дүгнэлтээр Монгол Улсын “Төр, сүм хийдийн харилцааны тухай” 1993 оны хууль (цаашид “1993 оны хууль” гэх)-д дүн шинжилгээ хийж, түүнд “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн 2018 оны төсөл (цаашид “Хуулийн төсөл” гэх) хэрхэн нөлөө үзүүлэх талаар үнэлгээ өгөв. Дүгнэлтийг Хуулийн төслийн англи хувилбарт тулгуурлан бэлтгэсэн тул, зарим нэгэн асуудлыг Монгол Улсын эрх зүйн тогтолцоо дахь бусад салбарт зохицуулах боломжтой, эсхүл тэдгээр нь орчуулгын асуудлаас үлбаатай үл ойлголцол байж болохыг зохиогч тэмдэглэж байна. Хэрэв тухайн хүндрэл монгол хэл дээрх эх хувилбарт гарахгүй бол энэ нь ердөө орчуулгын алдаа байсан нь тодорхой болно гэж итгэж байна.

### **Хэрэглэгдэх стандартууд**

Би Монгол улсын дээрх хуулиудыг, нарийвчилсан дүн шинжилгээнээс тодорхой харуулсанчлан, Хүний эрхийн түгээмэл тунхаглал (цаашид “ХЭТТ” гэх), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (цаашид “ИУТЭТОУП” гэх) болон Шашин, итгэл үнэмшлээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай 1981 оны НҮБ-ын тунхаглалд тусгалаа олсон буюу нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартуудын дагуу үнэлж дүгнэх болно. Монгол Улс бол ИУТЭТОУП-ыг соёрхон баталсан, мөн Европын Аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага/Ардчилсан институт хүний эрхийн алба (цаашид “ЕАБХАБ/АИХЭА” гэх)-ын гишүүн улс юм. 1993 оны Хуулийн 3 дугаар зүйл нь хувь хүний аливаа шашныг шүтэх, эс шүтэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх болон

---

<sup>1</sup> Бригхам Янгийн Их сургуулийн Эрх зүй, шашин судлалын олон улсын төвийн Дэд захирал Элизабет А. Кларк 2021 оны 11 дүгээр сард бэлтгэв. Махони Лиотта ХХН нь энэхүү өгүүллийг Англи хэлнээс Монгол хэл рүү орчуулсан болно.



итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, шашин шүтлэгийг албадахыг хориглосон байдаг. Ухуулан дагуулах хүчин чадлын хувьд өндөр учир, энэхүү дүн шинжилгээнд НҮБ-ын Хүний эрхийн хорооны мэдэгдэл, Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгчийн мэдэгдэл болон Европын Зөвлөлөөс гаргасан олон улсын стандартуудын тайлбар (тодруулбал, Европын Хүний эрхийн шүүхийн болон Венецийн комиссын шийдвэр)-уудыг ч мөн харгалзан үзлээ.

## **1993 оны Хууль дахь анхаарах гол асуудлууд**

Улсын бүртгэлтэй холбоотой заалтууд 1993 оны Хууль дахь анхаарал хандуулах гол асуудал юм. Тус хуулиар шашны байгууллагын бүртгэл нь заавал хийгдэх шинжтэй байх ба хялбархан, ил тодорхой байх шаардлагыг хангахгүй байна. Өөр өөр орон нутагт шашин шүтэх эрхээ бүлгээрээ хэрэгжүүлэхийн тулд, орон нутаг бүрд олон удаа бүртгүүлэхийг шаардаж байна. Хууль нь бүртгэл хийх эрх бүхий байгууллагын талаар тодорхой зохицуулаагүй, жил бүр ирүүлдэг хүсэлтийг хүлээн аваагүй тохиолдолд ямар үр дагавар үүсэх талаар заагаагүй, мөн бүртгэлийг түдгэлзүүлэх, цуцлахаас илүү хөнгөн шийтгэлийг тусгаагүй байна. Шашны эсхүл шашны харьяалалтай хүмүүнлэгийн байгууллагын бүртгэлд зориулсан заалт хуульд байхгүй байна.

1993 оны Хууль шашныг ухуулан дэлгэрүүлэх (proselyting<sup>2</sup>)-д хязгаарлалт тавьснаар хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхэд ихээхэн хэмжээний, зайлшгүй бус дарамтыг бий болгосон. Гаднын шашныг зохион байгуулалттайгаар нэвтрүүлэхэд тавьсан ерөнхий хориглолт, албадаж эсхүл залилж шашныг ухуулан дэлгэрүүлэхээс сэргийлэх оролдлого бүхий маш өргөн заалтууд нь дур зоргын шинжтэй хууль хэрэгжилт болон үг хэлэх, үйлдэл хийх эрхийг зөрчих явдалд боломж бололцоог олгож байна.

1993 оны Хуулиар шашны ном зохиолд бүхэлд нь хязгаарлалт тавиагүй бөгөөд 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр “шашны ном судар бүтээх” эрхийг сүм хийдүүдэд олгосон. Хэдийгээр энэ заалтад шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний чухал элементийг хуульчилсан хэдий ч, үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний онцгой шинж болох шашны ном судрыг үйлдвэрлэх, түгээх гэсэн холбогдох эрхийг тусгаагүй байна. Эдгээр эрхийг тусгаагүй байдал нь 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд

---

<sup>2</sup> “Proselyting” гэдэг нь бусдыг шашинд оруулах эсхүл оруулахыг оролдох гэсэн утгатай. Энэхүү дүн шинжилгээнд “шашныг ухуулан дэлгэрүүлэх” гэсэн хэллэгийг үг нэр томъёогоор илэрхийлсэн байна (Орчуулагч).

хохирол учирч болох” нөхцөлд “сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах... шаардлагатай бол зогсоох” гэсэн заалттай хосолсноор асуудлыг хурцатгаж байна. Учир нь энэ заалт шашны ном судрыг түгээхийг оролдсон үйлдлийг шийтгэж болох хууль зүйн бүрхэг буюу тодорхой бус үндэслэлийг бий болгож байна.

1993 оны Хуулиар шашны байгууллагын дотооддоо өөрийгөө засаглах эрхэд хэд хэдэн зайлшгүй бус хязгаарлалтыг тусгасан. Жишээлбэл, “лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршил”-ыг төрөөс хянан зохицуулахыг энэ хууль зөвшөөрсөн. Төр юуг уламжлалт гэж үзэх вэ гэдэгтээ тулгуурлан дотоод мөргөлийн зан үйл, журамд хуулиар хязгаарлалт тавьсан. Энэхүү хязгаарлалтад шашны байгууллагаас “тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах”-ыг шаардсан, “Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулах”-ыг хориглосон зэрэг заалт багтдаг.

Эцэст нь, 1993 оны Хуулиар Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэсэн маш бүрхэг үндэслэлээр шашны үйл ажиллагааг түдгэлзүүлэхийг зөвшөөрсөн. Хэдийгээр улсууд нийгмийн (нийтийн) хэв журамд шүүд заналхийлж буй гарцаагүй аюулыг зохицуулах нь хууль ёсны боловч үндэсний аюулгүй байдлын бүрхэг үндэслэлээр шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрч болохгүй.

### **Хуулийн төслийн зэрэг талууд ба цаашид анхаарах асуудлууд**

Хуулийн төсөлд шашны байгууллагын улсын бүртгэлтэй холбоотой зарим зохицуулалтыг тодорхой болгосон ба иргэний шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх нь хуулийн этгээдийн статустай эсхүл төрийн зөвшөөрөлтэй эсэхээс үл хамаарч хэрэгжихийг тодотгосон. Хуулийн төсөлд бүртгэлгүй шашны бүлэг гэдэг ойлголтыг шинээр танилцуулсан боловч тухайн бүлэг нь хэдийд бий болж, мэдэгдэл өгөх ёстой талаарх удирдамжийг тусгаагүй. Энэ талаарх шилдэг туршлага нь бүртгэлгүй хувь хүний болон бүлгийн үйл ажиллагаанд мэдэгдэл заавал өгөхөөс татгалзах явдал юм. Мөн, Хуулийн төсөлд шашны байгууллага орон нутагт үйл ажиллагаа явуулахын тулд орон нутаг тус бүрд бүртгүүлэхийг шаардсан дарамт учруулсан практикийг хэвээр үргэлжлүүлэхээр заасан байна. Төвлөрсөн шашны байгууллагыг бий болгохын тулд 10-аас доошгүй орон нутгийн шашны байгууллага байх шаардлага тавьж байгаа нь зайлшгүй бус, дарамт учруулсан зохицуулалт юм. Бүртгэлтэй холбоотой бусад хязгаарлалт (гишүүдийн нэрийг хавсаргах, гишүүдээс гадуурх санхүүжилт авахыг хориглох гэх мэт) болон дахин бүртгүүлэх гэсэн зайлшгүй бус шаардлагыг Хуулийн төсөлд оруулсан. Хуулийн төсөлд бүртгэлийн шаардлага (хаягийн мэдээлэл зэрэг)-ыг тодруулж, захиргааны шаардлагыг

биелүүлээгүй тохиолдолд бүртгэл хийхээс шууд татгалзахаас илүү хөнгөн шийтгэл оноох талаар тусгах хэрэгтэй. Хуулийн төсөл нь шашны байгууллагуудын холбоо болон хүмүүнлэгийн байгууллагын бүртгэлтэй холбоотой 1993 оны Хуулийн хязгаарлалтын талаар дурдаагүй байна.

2018 оны Хуулийн төсөл нь шашны итгэл үнэмшлийг ухуулан дэлгэрүүлэх, бусадтай хуваалцахтай холбоотой 1993 оны Хуулийн хязгаарлалтыг илүү өргөжүүлжээ. Энэхүү төслөөр “гаднын” шашны номлолыг заахыг хориглосон хатуу хориглолтыг байхгүй болгосон боловч бүртгэлгүй шашны бүлгийн итгэл үнэмшлээ түгээн дэлгэрүүлэхийг хориглож, шашны зан үйл, итгэл үнэмшлээ түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд олон тооны хязгаарлалт тавьж, шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй сүм хийдээс албан ёсны зөвшөөрөл шаардаж, шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах байршлыг хязгаарлах зэрэг хүндрэлийг шинээр үүсгэжээ. Эдгээр заалтын ихэнх нь хэт ерөнхий, бүрхэг байгаа нь тэдгээрийг дур зоргоор хэрэгжүүлэн шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлах боломжийг нээж өгнө.

Хуулийн төсөлд мөн шашны материал үйлдвэрлэх, түгээхэд тавих хязгаарлалтыг чангатгасан. Олон нийтэд хэрэглүүлэх зорилгоор шашны ном, материал хэвлэх, үйлдвэрлэх, экспортлох, импортлохыг, мөн хэвлэл мэдээллийн байгууллага үүсгэн байгуулахыг зөвхөн төвлөрсөн шашны байгууллагад зөвшөөрсөн. Эдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг зайлшгүй бус болон тохиромжтой бус хэлбэрээр хязгаарлаж байгаа хэрэг мөн.

Хуулийн төсөл нь шашны байгууллагын дотооддоо өөрийгөө засаглах эрх буюу төрийн хөндлөнгийн оролцоогүйгээр шашны итгэл үнэмшлээ тодорхойлох, шашны гол чиг үүргээ хэрэгжүүлэх чадамжид халдахаар байна. Жишээлбэл, Хуулийн төсөлд хяналтын байгууллага, гүйцэтгэх байгууллага бий болгохыг шаардах зэргээр өргөн хүрээний албан бүтцийг шашны байгууллагад тулгасан байна. Шашны байгууллагын бүтэц нь өөрөө ихэвчлэн шашны итгэл үнэмшлийн нэг бүрэлдэхүүн хэсэг байдаг бөгөөд түүнийг өргөн хүрээгээр зохицуулах нь зохисгүй. Шашны байгууллага ямар нэр сонгох, санхүүжилтээ хэзээ зарцуулах, санхүүгийн ямар нууц мэдээллийг олон нийтэд ил болгох, харилцан хамааралтай байгууллагуудын барилга байгууламжийг санхүүжүүлэхэд хэрхэх вэ гэдэгт тавьсан хязгаарлалт нь дотооддоо өөрийгөө засаглах эрхэд халдсан хязгаарлалтын бусад жишээ юм.

Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах нөхцөлд шашны үйл ажиллагааг хязгаарлах тухай 1993 оны Хуулийн бүрхэг заалтыг Хуулийн төсөлд хэвээр үлдээж, ямар байгууллага бүртгүүлж болох, шашны байгууллагад иргэдийг хэрхэн оруулж болохыг хязгаарласан бүрхэг нөхцөлүүдийг ч нэмэн оруулжээ. Төрийн байгууллага хоорондын үүрэг хариуцлагын тодорхойгүй хуваарилалтын асуудлыг шийдвэрлээгүй бөгөөд бүлгүүдийг шашин, итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхахыг төрд илүү тодорхой хориглож хуульчлах хэрэгтэй. Хуулийн зөрчлийн

алинд эрүүгийн ял, алинд захиргааны шийтгэл ногдуулах вэ, хуулийг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгийг Хуулийн төсөлд тодруулбал зохино.

## **II. Хуульд тулгарч буй асуудлуудын дүн шинжилгээ**

### **A. Шашин эсхүл итгэл үнэмшилтэй байх буюу болох эрх**

Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй холбоотой үндсэн эрхүүдийн нэг нь “өөрийн сонгосон шашин эсхүл итгэл үнэмшилтэй байх буюу болох” хувь хүний эрх юм.<sup>3</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 18 дугаар зүйлд “Хүн бүр чөлөөтэй бодох, ухамсарлах, шүтэх эрхтэй; энэхүү эрхэд шашин буюу итгэл үнэмшлээ өөрчлөх эрх чөлөө, шашин эсхүл итгэл үнэмшлээ ганцаарчлан буюу бусадтай хамтран нийтийн өмнө эсхүл хувиараа сургах, хэрэгжүүлэх, шүтэх, дагах замаар илчлэх эрх чөлөө багтана.”<sup>4</sup> Шашныг илчлэх буюу гадагш чиглэсэн шашны үйл ажиллагааг явуулах эрхэд “зөвхөн нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, эсхүл бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй бөгөөд хуулиар тогтоосон хязгаарлалт”<sup>5</sup>-ыг тавьж болдог бол итгэл үнэмшлийг төрөөс зохицуулж болохгүй.

НҮБ-ын Хүний эрхийн хорооны мэдэгдсэнээр ИУТЭТОУП-ын 18 дугаар зүйл нь “бодох, ухамсарлах эрх чөлөөнд, мөн өөрийн сонгосон шашин буюу итгэл үнэмшилтэй байх буюу болох эрх чөлөөнд ямар ч хязгаарлалт хийхийг зөвшөөрөхгүй. Эдгээр эрх чөлөө нь нөхцөлгүйгээр хамгаалагдсан...”<sup>6</sup>

Хуулиар тогтоогоогүй, дурдагдсан хууль ёсны үндэслэлд тулгуурлаагүй, эсхүл эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд шашнаа илчлэх үйл ажиллагааг ч төрөөс хязгаарлаж болохгүй. Хуулийн төсөл болон 1993 оны Хууль нь хувь хүн, бүлгийг шашны үйл ажиллагаа эрхлэхээс өмнө заавал бүртгүүлэх үүрэг хүлээлгэх, мөн бүртгэлтэй холбоотой дарамт бүхий, зайлшгүй бус заалтуудыг оруулах замаар шашны итгэл үнэмшилтэй байх буюу болох эрхийн цөмийг хязгаарласан байна.

### **a. Бүртгүүлэхэд зайлшгүй бус шаардлага тавьсан нь**

---

<sup>3</sup> ИУТЭТОУП-ын 18-р зүйл.

<sup>4</sup> ИУТЭТОУП-ын 18-р зүйл.

<sup>5</sup> ИУТЭТОУП-ын 18.3-р зүйл (“Шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөөг зөвхөн хуулиар тогтоосон болон зөвхөн нийгмийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй бөгөөд хуулиар тогтоосон хязгаарлалтыг шашин буюу итгэл үнэмшлээ илчлэх эрх чөлөөнд зайлшгүй шаардлагын үүднээс хязгаарлаж болно”).

<sup>6</sup> Ерөнхий тайлбар №22 (48), 3 дахь догол.

## 1. 1993 оны Хууль

Шашин эсхүл итгэл үнэмшилтэй байх буюу болох эрхийн үндсэн хэсэг болох шашны байгууллагыг хуулийн этгээдийн статустай болгох боломжийг 1993 оны Хуулийн 6, 9 дүгээр зүйлээр тус тус бүрдүүлсэн. Харамсалтай нь, 1993 оны Хуулийн бүртгэлтэй холбоотой заалтууд нарийвчлал, тодорхой байдлын хувьд хангалтгүй, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг хэрэгжүүлэхэд практикт төөрөгдөл, бэрхшээлийг үүсгэсэн. Бүртгэлийн журамд төрийн ямар байгууллага шашны байгууллагыг бүртгэхийг тодорхой зааж өгөх, шашны байгууллага төр хоорондын харилцааг төрийн аль байгууллага хариуцан ажиллахтай холбоотой төөрөгдлийг багасгах хэрэгтэй. Төр ба шашны байгууллага хоорондын харилцаатай холбоотой төрөл бүрийн үүргийг хуульчилсан 1993 оны Хуулийн 5 дугаар зүйл дээрхтэй ижил тодорхой бус (түүний англи хэл дээрх орчуулгыг харвал) байна.

Олон улсын шилдэг туршлагаас харвал бүртгэлийн процесс нь энгийн, ил тод байх хэрэгтэй. Бүртгэлийн байгууллага нь Хууль зүйн яам эсхүл Шашны хэрэг хариуцсан хороо байдаг. Бүртгэл нь дарамтгүй, олон шатны төрийн байгууллагуудаас төрөл бүрийн зөвшөөрөл шаарддаггүй байх нь зүйтэй. Бүртгэлийг үндэсний хэмжээнд нэгдсэн нэг байгууллага эсхүл орон нутаг бүрд тухайн орон нутгийн аль нэг байгууллага гүйцэтгэдэг байх нь дээр юм. Орон нутгийн байгууллага бүртгэлийг хийсэн тохиолдолд тухайн бүртгэл нь бусад орон нутагт хүчин төгөлдөр үйлчлэх хэрэгтэй. Нэг улсад хэд хэдэн орон нутагт тус тусад нь бүртгэх замаар газар зүйн байрлалаар нь шашны үйл ажиллагааг эрхлэх боломжийг хязгаарлах нь ардчилсан нийгмийн хувьд зайлшгүй бус, хэт дарамттай зохицуулалт юм.<sup>7</sup>

Шашны үйл ажиллагаа эрхлэхийг бүртгүүлэх, тусгай зөвшөөрөл авах эдгээр шаардлага нь шашин шүтэх эрх чөлөөг зөрчиж байна. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч хэлэхдээ:

Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө нь угаас заяасан нэр төр (эрхэм чанар)-тэйнхээ хувьд хүн бүрийн эдэлдэг эрх юм. ИУТЭТОУП-ын 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар энэхүү эрхэд “шашин буюу итгэл үнэмшлээ өөрчлөх эрх чөлөө, шашин эсхүл итгэл үнэмшлээ ганцаарчлан буюу бусадтай хамтран нийтийн өмнө эсхүл хувиараа сургах, хэрэгжүүлэх, шүтэх, дагах замаар илчлэх” эрх чөлөө багтана. Бусадтай хамтран өөр өөр төрлийн үйл ажиллагаа явуулах боломж нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний хүрээнд хамрагдах нь тодорхой. Тиймээс бүртгэл заавал хийгдэх шаардлагагүй; өөрөөр хэлбэл, бүртгэл нь хүний шашин шүтэх эрхийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл

---

<sup>7</sup> Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч Хайнер Билефельдтийн тайлан, A/HRC/19/60 (2011 оны 12-р сарын 22-ны өдөр), 44-р доголыг харна уу.

байх ёсгүй, харин зөвхөн хуулийн этгээдийн статусыг олж авах зорилготой байх ёстой.<sup>8</sup>

Европын Хүний эрхийн шүүх Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц (цаашид “Европын конвенц” гэх)<sup>9</sup>-ийн 9 дүгээр зүйл (ИУТЭТОУП-ын 18 дугаар зүйлтэй адил)-ийг тайлбарлахдаа төрөөс бүх шашны үйл ажиллагааг заавал бүртгүүлэх шаардлага тавьснаар “төрд албан ёсоор бүртгүүлээгүй цөөнхийн шашны итгэл үнэмшлийг үгүйсгэж, улмаар хүн юунд итгэж үнэмших ёстойг төрөөс зааж өгөх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ. Шүүх ийм аргачлалтай санал нийлэхгүй бөгөөд шашин чөлөөтэй шүтэх эрх [энд яригдаж буй]-ийн энэ хязгаарлалт нь нийгмийн түлгамдсан хэрэгцээтэй уялдаагүй, улмаар ардчилсан нийгэмд зайлшгүй бус хөндлөнгийн оролцоог бүрдүүлсэн.”<sup>10</sup>

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /Ардчилсан институт, хүний эрхийн алба (цаашид “ЕАБХАБ/АИХЭА” гэх)-ны Шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлаг (community)-ийн эрх зүйн этгээд байх талаарх удирдамжид заавал бүргүүлэх асуудалтай холбоотой оновчтой зөвлөмж оруулсан байна: “Төрийн зөвшөөрөл нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хэрэгжүүлэх нөхцөл байж болохгүй. Хүн болон хамтлаг нь албан зөвшөөрлөөс хамаарахгүйгээр шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхтэй учир шашин, итгэл үнэмшлээ нийтийн өмнө эсхүл хувиараа, ганцаар эсхүл бусадтай хамтран харуулсан эсэхээс үл хамааран үүл эрх чөлөөгөө эдлэхэд урьдчилан бүртгүүлэх эсхүл өөр адил журмыг хангахаар зохицуулж болохгүй. Түүнчлэн энэ нь... бүртгэлгүй үйл ажиллагааг хуулиар хориглох, шийтгэх нь олон улсын стандартад нийцэхгүй гэсэн үг.”<sup>11</sup>

Баруун Европ, Хойд эсхүл Өмнөд Америкт Кубаас бусад ямар ч улсад заавал бүртгүүлэх шаардлага тавьдаг улс байдгийг мэдэхгүй. Тэр ч байтугай, Оросын хууль (түүний хэд хэдэн заалтыг ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх болон Европын Хүний эрхийн шүүхээс хүчингүй болгосон) нь уг эрх чөлөөг хэт хязгаарласанд тооцогддог

---

<sup>8</sup> Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтэгч Хайнер Билефельдтийн 2011 оны тайлан. 41-р догол.

<sup>9</sup> 1950 оны 11-р сарын 4-ний өдөр Европын зөвлөлөөр батлуулж, 1953 оны 9-р сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц (цаашид “Европын конвенц” гэх).

<sup>10</sup> Масаев ба Молдавын хэрэг № 6303/05 E.Ct.H.R. (2009 оны 5-р сарын 12-ны өдөр), 26-р догол.

<sup>11</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Шашин, шүтлэгийн эрх чөлөөний асуудлаарх шинжээчдийн зөвлөлийн Венецийн комисстой хэлэлцэн боловсруулж, Венецийн комиссоор батлуулан (Венеци хотод 2004 оны 6-р сарын 18-19-ний өдрүүдэд) Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын Ассамблейн хурлаар (Эдинбург хотод 2004 оны 7-р сарын 5-9-ний өдрүүдэд) хүлээн зөвшөөрүүлсэн Шашин шүтлэгтэй холбоотой хууль тогтоомжид дүгнэлт хийх удирдамж (“2004 оны ЕАБХАБ-ын удирдамж” гэх). 12-р хэсгийг харна уу. (“ЕАБХАБ олон жилийн түрш хуулийн этгээдийн статусыг олж авах, хадгалахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн. Зарим шашны бүлэг зөвшөөрөл авахтай холбоотойгоор төрөөс тавьдаг шаардлагыг зарчмын хувьд эсэргүүцдэг тул бүртгүүлэхгүй байх хүсэлтэй шашны бүлэгт төрөөс хориг, хязгаарлалт тавихгүй байх нь зүйтэй”).

ч шашны бүлгийг бүртгүүлэхийг шаарддаггүй.<sup>12</sup> Бусад улс ч энэ арга замаас татгалзсан: 2000 онд Европын зөвлөлөөс сөрөг үнэлгээ авсны дараа Болгар өөрийн хууль тогтоомжоос заавал бүртгэлийг халсан. ЕАБХАБ/АИХЭА болон Европын зөвлөлийн Венецийн Комиссоос нийтэлсэн, олон улсын стандарт, шилдэг туршлагыг нэгтгэн харуулсан Шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагийн эрх зүйн этгээд байх талаарх удирдамжид нь энэ санааг тодорхой баталж байна.<sup>13</sup>

1993 оны Хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт шашны байгууллагын хаягийг дүрэмдээ тусгах тухай заасан. Хэдийгээр шашны байгууллагын зохион байгуулагчтай холбоо барих арга замыг шаардах нь үндэслэлтэй ч шашны байгууллагын түрээсэлж эсхүл өмчилж байгаа газрын байршлын хаягийг шаардахгүй гэдгийг хуульд заах хэрэгтэй. Түрээсийн эсхүл өмчлөлийн барилгын байршлын хаягийг шаардсанаар жижиг, шинээр үүсгэн байгуулагдаж буй бүлгүүдийг төдийгүй уламжлалт шашин, барилгад залбирал үйлддэггүй бусад этгээдийг ялгаварлан гадуурхана. Жишээлбэл, ЕАБХАБ-ын Удирдамжид заахдаа “шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагуудад хуулийн этгээдийн статустай болох боломж олгодог аливаа журам нь дарамт учруулах шаардлага тавьж болохгүй. Олон улсын эрх зүйн дагуу зөвтгөгдөх боломжгүй, дарамт учруулах шаардлагын жишээ (үүгээр хязгаарлагдахгүй)-нд дараах зүйл багтдаг. Үүнд: ...шашны байгууллага нь хууль зүйн хувьд баталгаажсан байршлын хаягтай байна.”<sup>14</sup>

10 дугаар зүйлд хууль зөрчсөн тохиолдолд шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоохоор заасан. Гэсэн хэдий ч уг заалт нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хамтаараа хэрэгжүүлэхэд хэт их дарамт учруулж байна. Энэ заалтаар хуулийн ямар ч зөрчил гаргасан тохиолдолд шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоохыг зөвшөөрсөн, харин мэдэгдэл өгөх, зөрчлийг залруулах хугацаа олгох зэрэг завсрын арга хэмжээ авах талаар тусгаагүй байна. ЕАБХАБ-ын Удирдамжид:

Шашны эсхүл итгэл үнэмшлийн байгууллагын хуулийн этгээдийн статусыг цуцлах нь түүний статус, санхүүжилт, үйл ажиллагаанд онцгой бөгөөд томоохон үр дагаврыг дагуулдгийг харгалзан тийнхүү цуцлах шийдвэр нь хамгийн сүүлд авах арга хэмжээ гэж үзэх хэрэгтэй. Нийтийн хэв журамд аюул учруулах ноцтой, давтан зөрчил гаргасан бөгөөд

---

<sup>12</sup> Ухамсар, шашны нэгдлийн эрхийн тухай Холбооны хууль № 125-ФЗ (1997 он) (ОХУ); Кимля ба ОХУ нарын хэрэг, № 76836/01, 32782/03, Европын хүний эрхийн шүүх (2009 оны 10-р сарын 1-ний өдөр); "Ухамсар, шашны нэгдлийн эрхийн тухай Холбооны хуулийн 8.3, 8.4, 8.5, 9, 13, 27.3, 27.4 дэх хэсэг нь үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг зөрчсөн гэх зөрчлийг хэлэлцэж, гаргасан Үндсэн хуулийн цэцийн 2000 оны 4-р сарын 13-ны өдрийн шийдвэр №46-О (ОХУ), Шашин, эрх зүйн хүрээлэн, “Шашны холбоо: Ухамсар, шашны эрх чөлөө; Норматив актууд ба шүүхийн шийдвэрүүд, Москва, Хууль й, 2001 он, 247-р тал.

<sup>13</sup> Ардчилсан институт, хүний эрхийн алба, Европын Зөвлөлийн Венецийн комисс, Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014 он), 10 ба 16-р догол.

<sup>14</sup> Ардчилсан институт, хүний эрхийн алба, Европын зөвлөлийн Венецийн комисс, Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014 он), 25-р догол.

гагцхүү бусад шийтгэлийг оновчтойгоор хэрэглэх боломжгүй, I хэсэгт заасан бүх нөхцөл хангагдсан тохиолдолд л эдгээр арга хэмжээг авах нь тохиромжтой. Эс бөгөөс, пропорциональ (тохирсон байдал) болон субсидиар зарчмууд зөрчигдөнө. Эдгээр зарчимд нийцүүлэхийн тулд эрх зүйн статусыг цуцлах арга хэмжээг авч хэлэлцэхээс өмнө тухайн зөрчлийн ноцтой байдлаас хамааран сануулах, торгох, татварын хөнгөлөлтийг цуцлах зэрэг олон төрлийн хөнгөн шийтгэлийг хууль тогтоомжид тусгах хэрэгтэй.<sup>15</sup>

1993 оны хуульд Хуулийн этгээдийн статусыг цуцлахаас илүү хөнгөн шийтгэлийг тусгах нь зүйтэй. Үүнд тухайн байгууллагын үйл ажиллагааг нэн даруй цуцлахгүйгээр сануулах, зөрчлийг залруулах хугацаа олгох зэрэг арга хэмжээ багтана.

Мөн 1993 оны Хуульд байгууллагын үйл ажиллагаа хэвийн үргэлжлэн явж байгаа тухай тогтмол мэдэгдэл өгөх шаардлагыг тусгаагүй байна. Хэрэв тийм мэдэгдэл шаардлагатай бол мэдэгдэл ирүүлээгүй нь шашны байгууллагын бүртгэлээс шууд хасагдах шалтгаан болох учиргүй юм. Дээр дурдсан ЕАБХАБ-ын Удирдамжид өгүүлсэнчлэн, хуулийн этгээдийн статусыг цуцлах нь үйл ажиллагаа хэвийн үргэлжлэн явж байгаа тухай мэдэгдлийг ирүүлээгүй тохиолдолд ногдуулах ердийн шийтгэл биш, харин эцсийн арга хэмжээ байх нь зүйтэй. Мэдэгдэл ирүүлээгүй алдааг залруулахад хугацаа өгөхөд л болно.

Шашны харьяалалтай хүмүүнлэгийн байгууллагыг шашны байгууллагын салбар байгууллага эсвэл ашгийн бус байгууллагаар бүртгэхийг зөвшөөрч хуульчлах хэрэгтэй байна. Мөн шашны байгууллагуудаас бүрдсэн холбоог бүртгүүлэхийг хуулиар зөвшөөрөх нь зүйтэй.

## **2. 2018 оны Хуулийн төсөл**

Хуулийн төслийн 7 дугаар зүйлд бүртгэлгүй шашны бүлгийн тухай ойлголтыг шинээр тусгасан. Энэ нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдийн статус эсхүл төрийн зөвшөөрөл шаардлагагүй гэдгийг дахин нотолсон эерэг алхам юм. Гэвч, олон улсын шилдэг түршлагаар бүртгэлгүй бүлгүүд нь төрийн байгууллагад мэдэгдэл заавал өгөхийг шаарддаггүй. Мөн, Хуулийн төсөлд шашны бүлэг хэдэн гишүүнтэй байх ёстойг заагаагүй байна. Хоёр иргэн шашны талаар хэлэлцэж уулзвал эсхүл шашны үйл ажиллагаа эрхэлбэл бүлэг байгуулагдсанд тооцох уу? Энэ нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, үг хэлэх эрх чөлөөнд зайлшгүй бус дарамтыг бий болгохоор харагдаж байх бөгөөд хуулийн тодорхойгүй байдал нь хуулийг дур зоргоор хэрэгжүүлэх эсхүл ялгаварлан гадуурхах замыг нээдэг.

---

<sup>15</sup> Ардчилсан институт, хүний эрхийн алба, Европын зөвлөлийн Венецийн комисс, Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014 он), 33-р догол.



Өш хонзон, дарамт шахалтад өртөх вий гэсэн айдас төрүүлэх учраас ямар ч тохиолдолд бүлэгтэй холбоотой мэдэгдэлд бүх гишүүдийн нэр, хаягийг оруулахыг шаардахгүй байх нь зүйтэй. НҮБ-ын Тусгай илтгэгч “Бүртгэлийн хүсэлтэд шашны байгууллагын бүх гишүүд гарын үсэг зурж, овог нэр, төрсөн огноо, оршин суух хаягийн мэдээлнэ гэсэн шаардлага” нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөнд саад учруулж буй хэлбэр гэж тодорхойлсон.<sup>16</sup> Уг тайланд “Зарим гишүүн өөрийн шашин харьяаллыг нууцлахыг хууль ёсоор хүсэж болох бөгөөд бүртгэлийн хүсэлтэд багтаагүй хүмүүс дараа нь итгэл үнэмшил нэгтгүүдийнхээ шашны үйл ажиллагаанд оролцоход бэрхшээлтэй тулгарч магадгүй” гэж тайлбарлажээ.<sup>17</sup>

Мөн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгээр өөрийн гишүүдээс бусад эх сурвалжаас хандив, дэмжлэг, тусламж авахыг шашны бүлэгт хориглосон байна. Олон шашны бүлэг нь олон улсын хэмжээнд хамаарал бүхий байгууллагатай холбоотой байдаг. Ийм шашны байгууллагын өөрийн хууль ёсны үйл ажиллагаандаа дэмжлэг болгон гадаадаас санхүүгийн дэмжлэг авах, үзүүлэх боломжийг хязгаарлах нь Монгол Улсын байгууллагуудыг зайлшгүй бусаар сүлрүүлж, цаашид Монгол Улсын өнцөг булан бүрд нөлөөлөх, иргэдэд үр ашгаа өгөх орлогыг бүхэлд нь зогсооно. Гагцхүү нийтийн аюулгүй байдал эсхүл нийтийн хэв журамд заналхийлсэн терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх гэх мэт “нийгмийн тулгамдсан хэрэгцээ” үүссэн тохиолдолд шашнаа илчлэх энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулахыг зөвшөөрдөг. Гэхдээ энэхүү асуудал үүссэн тохиолдолд илүү нарийвчлан боловсруулсан хууль тогтоомж гаргах боломжтой. Ерөнхийдөө “хамгийн зохимжтой арга зам нь чухал бодлогыг зөрчөөгүй бол санхүүжилт босгохыг холбоодод зөвшөөрөх явдал юм.”<sup>18</sup> Жишээлбэл, Израил эсхүл Израил улсад байгаа еврейчүүдээс, олон улсын санхүүгийн шилжүүлэг хийх хуульд нийцүүлэн, Монгол Улсад жүүдийн шашны мөргөлийн сүмийг сэргээн засварлах ажилд санхүүжүүлэлт хийхийг хориглох нь яагаад “ардчилсан нийгэмд зайлшгүй” шаардлагатай болохыг ойлгоход хэцүү юм. ЕАБХАБ-ын хэм хэмжээгээр шашны байгууллагууд нь олон улсын шашин нэгтгүүдэд харьяалагдаж, харилцаа холбоотой байх болон

---

<sup>16</sup> Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч Хайнер Билефельдтийн илтгэл, A/HRC/19/60 (2011 оны 12-р сарын 22-ны өдөр), 44-р догол.

<sup>17</sup> Ижил эх үүсвэр.

<sup>18</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд оролцогч орнуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын баримт бичиг (1989 он)-ий 16.4 дэх зарчим (гишүүн орнууд шашны нийгэмлэгүүдийн “сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах” эрхийг хүндэтгэнэ)-ыг харна үү; НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 36/55 (1981 оны 11-р сарын 25-ны өдөр) тогтоолоор батлагдсан Шашин, шүтлэгээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тунхаглалын 6(f) хэсэг (шашин шүтэх эрх чөлөөнд “хувь хүн болон байгууллагаас сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах эрх багтана.”).

байгууллагын хандив хүсэх, хүлээн авах эрхийг хадгалах нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг.<sup>19</sup>

Түүнчлэн, ЕАБХАБ-ын хэм хэмжээгээр үндэсний цөөнхийн “сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх боломжтой өөрийн боловсрол, соёл, шашны институт, байгууллага, холбоог байгуулж, үйл ажиллагаа явуулах” эрх болон “бусад улс дахь угсаатны эсхүл үндэсний гарал үүсэл, соёлын өв, шашны итгэл үнэмшил нэг иргэдтэй хил дамнан саад бэрхшээлгүй харилцаа холбоо тогтоох, үргэлжлүүлэх” эрхийг баталгаажуулсан. Шашны бүлгүүдэд зориулан олон улсын санхүүгийн шилжүүлэг хийхийг хориглох нь шашны цөөнхийн байгууллага байгуулах болон гадаад улсын ижил итгэл үнэмшилтэй этгээдүүдтэй харилцаа холбоотой байх боломжид ихээхэн саад учруулна. Шашны бүлгийг бусад бүлэгтэй ижил үндэслэлээр эх орон руугаа санхүүжилт авахыг зөвшөөрөх нь ардчилсан орнуудад өргөнөөр зөвшөөрөгдсөн практик юм. Зөвхөн шашны бүлэгт зориулсан санхүүгийн шилжүүлгийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд зайлшгүй бус бөгөөд ялгаварлан гадуурхсан шинжтэй.

7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт буяны үйл ажиллагаа явуулахдаа шашин түгээн дэлгэрүүлэх, шашны зан үйл, ёслол үйлдэхийг шашны бүлэгт хориглосон нь хэт дарамт үүсгэж байна. Хэдийгээр шашны байгууллагад хамааралтай буяны байгууллагын хувьд шашны ятгалга үйлдэхгүй байх нь шилдэг туршлага боловч олон шашны бүлгийн хувьд, ялангуяа маш цөөн гишүүдтэй бүртгэлгүй бүлгийн хувьд буяны үйл ажиллагааг тэднийг идэвхжүүлдэг шашны үйл ажиллагаанаас бүрэн салгах нь бодит байдал дээр хүндрэлтэй байж болно. Энэ заалтаар бүлгийг буяны үйл ажиллагаа явуулахдаа залбирах, итгэл үнэмшлээ дэмжиж дурдахыг хориглож байгаа нь шашнаа илчлэхэд тавьсан тохиромжгүй хориг юм.

7 дугаар зүйлийн 7.9, 7.3 дахь хэсэгт хэт туйлшрагч байгууллагын санхүүжилт, залилан, албадлагын асуудлыг шийдвэрлэхийг оролдож байгаа гэж ойлгогдож байна. Гэхдээ, олон улсын терроризмд оролцогч байгууллагад тавьсан хязгаарлалт, залилан, албадлагын талаар төвийг сахисан хуулийн зохицуулалтаар эдгээр асуудлыг шууд шийдвэрлэдэг олон улсын шилдэг туршлага бий.<sup>20</sup>

<sup>19</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд оролцогч улсуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын баримт бичиг (1989 он)-ийн 32-р догол; Европ дахь аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын анхны акт (1975 он, Хельсинк хот), 1(d) бүлэг; Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд оролцогч орнуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын баримт бичиг (1989 он)-ийн 16.4 дэх зарчим (гишүүн орнууд шашны нийгэмлэгийн “сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах” эрхийг хүндэтгэнэ); НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 36/55 (1981 оны 11-р сарын 25-ны өдөр) тогтоолоор батлагдсан Шашин, шүтлэгээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тунхаглалын 6(f) хэсэг (шашин шүтэх эрх чөлөөнд “хувь хүн болон байгууллагаас сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах эрх багтана.”).

<sup>20</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн албаны Шашин, шүтлэгийн эрх чөлөөний асуудлаарх шинжээчдийн зөвлөлийн Венецийн комисстой хэлэлцэн боловсруулж, Венецийн комиссоор батлуулан (Венеци хотод 2004 оны 6-р сарын 18-19-ний өдрүүдэд) Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Парламентын

Шашны байгууллагын бүртгэлтэй холбоотой 8 дугаар зүйл нь бүртгэлийн процессыг илүү тодорхой болгоход тустай байна. Харин 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэгт (11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн хамт) орон нутгийн шашны байгууллага зөвхөн бүртгүүлсэн нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулах шаардлага бүхий 1993 оны хуулийнхтай ижил хүндрэлтэй асуудлыг хэвээр үлдээсэн. Дээр дурдсанчлан энэ шаардлагын дагуу шашны үйл ажиллагаа явуулахын өмнө заавал бүртгүүлэх бөгөөд энэ нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хамгаалсан олон улсын гол хэм хэмжээг зөрчдөг.

8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт орон нутгийн шашны 10 байгууллага нэгдэж, төвлөрсөн шашны байгууллага байгуулах болзлыг заасан нь зайлшгүй бус, дарамт учруулах хязгаарлалт юм. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч “Зарим улсууд практикт зөвхөн үндэсний хэмжээнд бүртгүүлэхээс гадна шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагийн орон нутгийн салбарыг тусад нь бүртгэхийг шаарддаг. Энэ нь тухайн орон нутгийн удирдлага бүртгэлийн хүсэлтийг өөрийн үзэмжээр батлах, татгалзах өргөн эрх мэдлийг олгож байна.”<sup>21</sup> гэж шүүмжилсэн. Өмнө нь 1993 оны Хуулийн талаарх хэлэлцүүлэгт дурдсанчлан, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэлийн заалттай байх, эсхүл бүлгүүдийг нэг аймагт бүртгээд улсын хэмжээнд шашны үйл ажиллагаа явуулахыг нь зөвшөөрөх нь шилдэг туршлага юм.

Хуулийн төсөлд мөн заавал дахин бүртгүүлэхийг шаардсан нь дарамт учруулахаар байна. 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт “Шашны байгууллага энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд багтаан энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу зөвшөөрөл авч, улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ” гэж заасан. Бүртгэлтэй шашны байгууллагыг дахин бүртгэх нь зайлшгүй бус бөгөөд тохиромжгүй дарамт үүсгэнэ. ЕАБХАБ-ын Удирдамжид “Буцаж үйлчилж байгаа эсхүл хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахгүй (жишээлбэл, шашны байгууллагыг шинэ шалгуураар дахин бүртгүүлэх гэх мэт) байгаа заалтыг дахин нягтлах нь зүйтэй” гэж тайлбарласан.”<sup>22</sup>

---

Ассамблейн хурлаар (Эдинбург хотод 2004 оны 7-р сарын 5-9-ний өдрүүдэд) хүлээн зөвшөөрүүлсэн Шашин шүтлэгтэй холбоотой хууль тогтоомжид дүгнэлт хийх удирдамжийн 20-р талыг харна уу. Мөн Коккинакис ба Грек нарын 3/1992/348/421 тоот хэрэг, Европын хүний эрхийн шүүх (1993 оны 4-р сарын 19-ний өдөр), 17-р доголыг харна уу.

<sup>21</sup> Шашин шүтлэгийн эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч Хайнер Билефельдтийн илтгэл, А/НРС/19/60 (2011 оны 12-р сарын 22-ны өдөр), 44-р догол

<sup>22</sup> ЕАБХАБ/АИХУЭА-ны Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014 он), 17-р тал.

## **Бүртгэлд тавигдах шаардлага – 2018 оны Хуулийн төсөлтэй холбоотой зөвлөмж**

- Бүртгэлгүй шашны үйл ажиллагааг зөвшөөрсөн гэдгийг тодруулах.
- Бүлэг шашны үйл ажиллагаа эрхлэхээс өмнө мэдэгдэл ирүүлэх тухай 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хасах, эсхүл хамгийн багадаа:
  - Мэдэгдэл өгөхөд хэдэн гишүүнтэй байх шаардлагатайг тодруулах.
  - Хэрэв мэдэгдэл өгөхийг шаардвал бүх гишүүний жагсаалт, хаягийн мэдээллийг гаргаж өгөх шаардлагыг хасах.
  - 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасан бүлэг гишүүдээс гадуур хандив, дэмжлэг, тусламж авахыг хориглосон зохицуулалтыг хасах.
  - 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт заасан бүлгүүд буяны үйл ажиллагаа явуулахдаа шашин түгээн дэлгэрүүлэх, шашны зан үйл үйлдэхийг хориглосныг хасах.
- Бүртгэлийн журмыг илүү хялбарчилж, тодруулах. Төвлөрсөн шашны байгууллагыг орон нутгийн шашны байгууллагаар урьдчилан бүртгүүлэх хэрэгтэй гэсэн шаардлагыг арилгах нь шилдэг туршлага юм. Ядаж орон нутгийн шашны байгууллагад урьдчилан хийлгэх бүртгэлийн тоог хоёр болгон бууруулах хэрэгтэй.
- Шашны үйл ажиллагаа нь бүртгэлд заасан хаягаар хязгаарлагдахгүй, мөн бүртгүүлэхийн тулд түрээс, өмчлөлийн газрын бодит байршлын мэдээлэл шаарддаггүй гэдгийг тодруулах.
- Шашны байгууллагын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа тухай мэдэгдэл шаардлагатай эсэхийг тодруулах. Тогтмол хугацаанд дахин бүртгүүлэх шаардлагагүй гэдгийг тодруулах ёстой. Мэдэгдэл нь энгийн байх бөгөөд мэдэгдэл ирүүлээгүй алдаа нь хуулийн этгээдийн статусыг шүүд цуцлах эсхүл үйл ажиллагааг нь түдгэлзүүлэхэд хүргэхгүй гэдгийг хуульд заах хэрэгтэй.
- Эрүүгийн бус зөрчилд хуулийн этгээдийн статусыг цуцлахаас илүү хөнгөн шийтгэлийг нэмж, захиргааны зөрчлөө залруулах хугацааг байгууллагад олгох.
- 44 дүгээр зүйлд заасан дахин бүртгэлийн шаардлагыг хасах.
- Шашны харьяалалтай хүмүүнлэгийн болон буяны байгууллагыг шашны байгууллагын салбараар эсхүл ашгийн бус байгууллагаар бүртгэх заалт оруулах хэрэгтэй.
- Мөн шашны байгууллагуудаас бүрдсэн холбоо бүртгүүлэхийг хуулиар зөвшөөрөх нь зүйтэй.

## **Б. Шашны илэрхийлэл**

### **а. Шашны итгэл үнэмшлээ хуваалцахад тавьсан хязгаарлалт**

#### **1. 1993 оны Хууль**

1993 оны Хуулиар шашин шүтлэгийг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн хязгаарлалт тавьсан. 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт “Монгол Улсад шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсэгт “Аливаа шашны байгууллага, лам санваартан өөрийн шашныг эс шүтэгчдэд үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэхийг хориглоно” гэж заасан. Хэдийгээр албадах, залилан мэхлэх замаар шашныг ухуулан дэлгэрүүлэхийг олон улсын эрх зүйн дагуу хориглож болох ч эдгээр заалтын хамрах хүрээ хэт өргөн, бүрхэг байгаа нь хуулийг дүр зоргоороо хэрэгжүүлэх, зохих ёсоор хамгаалагдсан үг хэлэх, үйлдэл хийх эрхэнд халдах боломж олгож байна.

Шашныг ятгах, дэмжих, эсхүл ухуулан дэлгэрүүлэх нь эмзэг асуудал бөгөөд хязгаарлагдмал нөхцөлд эдгээр агуулга илэрхийлсэн үйл ажиллагаа нь бусдын эрх, эрх чөлөөнд харшилж болзошгүйг хүлээн зөвшөөрнө. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгчийн хэлснээр ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа (proselytization)-д дөрвөн дэд эрх хамаардаг. Үүнд: “(а) шашин эсхүл итгэл үнэмшлээ өөрчлөх эрх; (b) шашин эсхүл итгэл үнэмшлийг албадан өөрчлөхөөс ангид байх эрх; (c) албадахгүйгээр ятгах замаар бусдын шашин эсхүл итгэл үнэмшлийг өөрчлөхийг оролдох эрх; (d) үүнтэй холбоотой хүүхэд, түүний эцэг эхийн эрх” багтана.<sup>23</sup> Жишээлбэл, Европын Хүний эрхийн шүүх Европын конвенцын 9 дүгээр зүйлд зааснаар шашин шүтэх эрх чөлөөнд “‘сургах’ замаар өөрийн хөршийг ятгах зэргээр шашнаа илчлэх эрх багтах” боловч шашин шүтэх эрх чөлөө нь “шашин эсхүл итгэл үнэмшлээр шалтагласан эсхүл өдөөгдсөн үйлдэл тус бүрийг хамгаалахгүй.”<sup>24</sup>

Европын шүүхийн зарим шийдвэрт бичсэнээр шашин шүтэх эрх чөлөө нь “сүмд шинээр гишүүн болгох зорилгоор эд материалын эсхүл нийгмийн давуу тал санал болгох, зохисгүй байдлаар шахалт үзүүлэх”<sup>25</sup> гэх мэтээр ухуулан дэлгэрүүлэх (прозелитизм) зарим хэлбэрийг хамгаалахгүй байж болохыг илтгэдэг. Гэвч, “зэвсэгт хүчин дэх дээд болон доод тушаалтан хоорондын харилцааны онцгой шинж

<sup>23</sup> Шашин шүтлэгийн эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгчийн дунд үеийн тайлан, A/67/303 (2012 оны 8-р сарын 13-ны өдөр), Хураангуй.

<sup>24</sup> Лариссис, бусад этгээдүүд ба Грекийн хэрэг, №140/1996/759/958-960, ЕХЭШ (1998 оны 2-р сарын 24), 45-р догол (Коккинакис ба Грекийн хэрэг, №3/1992/348/421, ЕХЭШ (1993 оны 4-р сарын 19), 31-р догол).

<sup>25</sup> Ижил эх үүсвэр.

чанарыг харгалзан үзэж” доод албан тушаалтандаа шашин эсхүл итгэл үнэмшилтэй холбоотой асуудлаар удаа дараа санал тавьж ярилцсан зэвсэгт хүчний ажилтныг шийтгэсэн явдлыг дэмжсэн нь Европын шүүхээс бодитоор баримталсан прозелитизмтэй холбоотой цорын ганц хязгаарлалт гэдгийг анхаарах нь чухал.<sup>26</sup>

ЕАБХАБ/АИХЭА-аас гаргасан Шашин эсхүл итгэл үнэмшилтэй холбоотой хууль тогтоомжийг хянан үзэх тухай удирдамж нь адилхан бодит албадлага дээр төвлөрдөг: “Хэрэв хууль тогтоомжоор шашин дэлгэрүүлэх ажлыг хязгаарласан бол тухайн хязгаарлалт нь шашны итгэл үнэмшил оролцсон эсэхээс үл хамааран албадлага эсхүл залилахтай ижил төстэй үйлдэл гаргасан нөхцөлд л зөвтгөгдөнө.”<sup>27</sup> Албадлага, хүчирхийлэл эсхүл залилантай холбоотой асуудалд одоогийн хүчин төгөлдөр хуулиар ял шийтгэл оногдуулдаг учир шашны албадлага, шашны хүчирхийлэл эсхүл шашны залиланг тусгайлан хуулиар зохицуулах шаардлагагүй юм. Шашны албадлага, хүчирхийлэл болон залилангаар тусдаа зөрчлийн төрөл үүсгэхийн оронд тэдгээрийг одоогийн мөрдөгдөж буй эрүүгийн хуулиар зохицуулах нь дийлэнх ардчилсан улсын сонгосон арга бөгөөд түгээмэл бус эсхүл цөөнхийн шүтдэг шашныг бай болгохоос зайлсхийхэд тусалдаг.

1993 оны Хуулиар “хууран мэхэлж, эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулсан, мөн тухайн шашинд үл итгэгчдийн сэтгэл санааг үймүүлэх”-ийг шашинд хориглосон нь бодох, ухамсарлах, шүтэх эрх чөлөөг зүй бусаар хязгаарлахыг зөвшөөрч байна. Эдгээр өргөн агуулгатай хэллэг нь бусад шашны итгэл үнэмшлийг эсэргүүцсэн үг хэлсний төлөө зүй бусаар шийтгэж хэрэглэгдэхээр байгааг онцолж байна. “Сэтгэл санааг үймүүлэх” болон “хууран мэхлэх” нь харьцангуй шинэ эсхүл жижиг бүлгүүдэд, мөн уламжлалт итгэл үнэмшлийг шүүмжилдэг хүмүүст хэрэглэгдэх боломжтой субъектив ангилал юм. “Шашин шүтэгч нь бусад итгэл үнэмшлээс илүү сайн эсхүл илүү үнэн зүйл санал болгоно гэдэгтээ итгэдэг гэсэн далд утга шашны ухуулгын мөн чанарт агуулагддаг.”<sup>28</sup> Итгэл үнэмшлүүдийг хооронд нь харьцуулах, бусад итгэл үнэмшлийг шүүмжлэх нь өөрийн сонгосон итгэл үнэмшилтэй байх эсхүл ийм итгэл үнэмшилтэй болох нөхцөлгүй эрх (unconditional right)-ийн жам ёсны хүрээнд багтдаг. Хожим Европын шүүхээр шийдвэрлэгдсэн *Коккинакис* хэргийг шийдвэрлэхдээ Грекийн шүүх шашныг ухуулан дэлгэрүүлэх асуудлыг хэлэлцэж, “шашны сургалт нь чөлөөтэй, саадгүйгээр гүйцэтгэх мөргөлийн зан үйлийн шинжтэй тул уг сургалтаар бусад шашнууд дахь

---

<sup>26</sup> 49-р догол.

<sup>27</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх шинжээчдийн зөвлөхийн багаас Ардчилал тогтоох Европын хороо (Венецийн комисс)-той зөвлөлдөн гаргаж, Венецийн комиссоор батлуулан (2004 оны 6-р сарын 18-19, Венец) АИХЭА-ны парламентын чуулганаар (2004 оны 7-р сарын 5-9, Эдинбург) танилцуулсан Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг хэлэлцэх тухай удирдамж, 20-р догол.

<sup>28</sup> Matthew K. Richards et al., “Voluntary Codes of Conduct for Religious Persuasion: Effective Tools for Balancing Human Rights and Resolving Conflicts?” *Religion and Human Rights* 6 (2011), 162.

алдааг онцлон тодотгосон байлаа ч энэ нь бусдад шашин ухуулан дэлгэрүүлсэнд тооцогдохгүй” гэж хүлээн зөвшөөрсөн.<sup>29</sup> Худал шалтаг хэлэн гэрт нь нэвтэрч, эмэгтэйг “хууран мэхлэх”-ийн тулд шашны судрын талаар “гарамгай” дүн шинжилгээ хийж, “шашны талаарх дутмаг мэдлэг”-ийг нь ашигласан<sup>30</sup> эсхүл эмэгтэйг “гэрлэлтийнхээ үлмаас сэтгэлийн хямралтай байхад” нь холбоо тогтоосон<sup>31</sup> үед шашныг ухуулан дэлгэрүүлэх ажиллагааг шийтгэснийг нь шашин шүтэх эрх чөлөөг зөрчсөн гэж Европын шүүхээс тогтоожээ. Шашин шүтэгчид болон байгууллагууд нь хэлсэн зүйл нь хууран мэхэлсэн эсхүл сэтгэл санааг нь үймүүлсэнд тооцогдох вий гэсэн айдасгүйгээр бусад итгэл үнэмшлийн үнэн эсхүл худал эсэх талаарх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

Шашныг ухуулан дэлгэрүүлэх эсхүл түгээх ажлыг хориглох нь үг хэлэх болон шашнаа илчлэх эрх чөлөөний талаарх олон улсын хэм хэмжээг зөрчдөг. Тухайлбал, Хүний эрхийн хорооноос шашны үгийг ИУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлээр хамгаалагдсан үгийн төрөл гэж онцлон тэмдэглэсэн байна: “2 дугаар хэсэгт заасны дагуу оролцогч улсыг хил хязгаараас үл хамааран бүхий л төрлийн мэдээлэл болон санаануудыг эрж хайх, хүлээн авах, дамжуулах эрх зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө эдлэх эрхээ баталгаажуулахыг шаардана. 19 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон 20 дугаар зүйлүүдэд зааснаар уг эрхэд бусдад дамжуулах боломжтой бүхий л төрлийн санаа болон үзэл бодлоо илэрхийлэх, харилцах эрхийг багтаан ойлгоно. Үүнд ... шашныг хэлэлцэх болон сургах багтдаг.”<sup>32</sup>

Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч “үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний адилаар” “шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө нь шашны эсхүл итгэл үнэмшлийн бүлэг дотроо бусадтай харилцах, үзэл бодлоо бусадтай хуваалцах, ялгаатай үзэл бодолтой хүмүүстэй харилцах замаар мэдлэгийн хүрээгээ тэлэх, улс орны хил дамжин харилцаа холбоогоо сайжруулах, хөгжүүлэх, шашны эсхүл итгэл үнэмшлийн асуудалтай холбоотой мэдээлэл хүлээн авах, түгээх, мөн албадлагын бус аргаар бусдыг ятгахыг оролдох эрх чөлөөг багтаасан маш хүчтэй харилцааны хэмжигдэхүүнтэй” гэж тайлбарласан.<sup>33</sup>

Итгэл үнэмшлээ албадлагын бус аргаар хуваалцах эсхүл сургах зэргээр бусадтай хамтарч шашин буюу итгэл үнэмшлээ илчлэх эрх чөлөө нь гагцхүү ИУТЭТОУП-ын 18 дугаар зүйлд тусгасан хязгаарлалтад орж болно. Өөрөөр хэлбэл, “тэдгээр

---

<sup>29</sup> *Kokkinakis v. Greece*, No. 3/1992/348/421, Eur. Ct. HR (19 April 1993), Para. 17.

<sup>30</sup> Мөн тэн, 46-р догол.

<sup>31</sup> *Larissis and others v. Greece*, no. 140/1996/759/958-960, Eur. Ct. HR (24 February 1998), 59-р догол.

<sup>32</sup> Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №34, НҮБ-ын Б.6 ССРР/С/С/34, (2011 оны 7-р сарын 11-29), 11-р догол.

<sup>33</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх тусгай илтгэгчийн гаргасан Дунд хугацааны тайлан, А/67/303 (2012 оны 8-р сарын 13), 27-р догол.

хязгаарлалт нь нарийн, тодорхой тодорхойлогдох хэрэгтэй; тэдгээр нь тохиромжтой байх хэрэгтэй; тэдгээр нь ялгаварлан гадуурхах замаар хэрэгжиж болохгүй. Шашныг ухуулан дэлгэрүүлэх нь сөрөг утга илтгэдэг ч ихэнхдээ тодорхойлолтгүй эсхүл бүрхгээр дүрслэгдсэн нэр томьёо бөгөөд түүний эсрэг ерөнхий заалтууд нь 18 (З)-р зүйлд заасан шалгуурыг хангадаггүй.”<sup>34</sup>

Шашин эсхүл итгэл үнэмшлээ өөрчлөхийг албадахаас ангид байх бусдын эрх нь шашныг ухуулан дэлгэрүүлэх эсхүл түгээх ажил явуулах эрхийг хязгаарлах үндэслэлийн нэг болдог. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ийн тусгай илтгэгч энэ талаар дараах тайлбарыг өгсөн:

Хувь хүн эсхүл байгууллага хүнийг албан хүчээр эсхүл эмзэг нөхцөлийг нь шууд урвуулан ашиглах аргаар бусад хүний шашныг өөрчлөх оролдлого хийсэн тохиолдолд ийм оролдлогоос хамгаалах арга хэмжээг төр авах нь зайлшгүй байж болно. Энэ нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний гадаад хэмжигдэхүүний чухал хэсэг болох “бусдыг ятгахыг оролдох эрх”-ийг хязгаарлахад хүрэх магадлалтай. ...Гэвч, энэхүү хязгаарлалт нь зөвхөн ИУТЭТОУП-ын 18(З)-р зүйлд заасан бүх шалгуурт чанд нийцсэн тохиолдолд л зөвтгөгдөх боломжтой.<sup>35</sup>

1993 оны Хууль нь шашныг ухуулан дэлгэрүүлэхэд албадлага хэрэглэхийг хориглосон зохицуулалтыг тусгаад зогсохгүй (7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийг харна уу), харин шашныг “гаднаас” нэвтрүүлэх, өөрийн шашныг эс шүтэгчийг “хууран мэхлэх” эсхүл “санаа сэтгэлийг үймүүлэх”-ийг хориглосон нь бараг юуг ч багтааж хориглох боломжтой байна. Эдгээр нь хүний үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхэд тавьсан бүрхэг, зүй бус хязгаарлалт юм.

## **2. 2018 оны Хуулийн төсөл**

2018 оны Хуулийн төсөл нь шашны итгэл үнэмшлээ хуваалцах болон ухуулан дэлгэрүүлэхэд тавьсан 1993 оны Хуулийн хязгаарлалтыг тэлжээ. “Гаднын” шашны талаар сургахыг эрс хориглохын оронд уг хуулиар бүртгэлгүй шашны бүлгийг итгэл үнэмшлээ хуваалцахыг хориглон, шашны зан үйл үйлдэх болон итгэл үнэмшлээ хуваалцах дээр агуулгын шинжтэй олон хориглолт тавьж, бусдад шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй байгууллага албан зөвшөөрөл авахыг шаарддаг болж, бусдад шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах байршлыг хязгаарлаж байна. Эдгээр заалтын олонх хэт өргөн бөгөөд бүрхэг байгаа нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөнд зүй бус дарамт учруулж хязгаарлах, дур зоргоор хэрэгжүүлэх замыг нээж байна.

<sup>34</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх тусгай илтгэгчийн гаргасан Дунд хугацааны тайлан, А/67/303 (2012 оны 8-р сарын 13), 27-р догол.

<sup>35</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх тусгай илтгэгчийн гаргасан Дунд хугацааны тайлан, А/67/303 (2012 оны 8-р сарын 13), 24-р хэсэг.



4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт “иргэнийг шашин шүтэх, эс шүтэх, шашны зан үйл, ёслол үйлдэх, сургалт, шашны байгууллагын үйл ажиллагаанд оролцох, эс оролцох болон шашны үйл ажиллагаанд хандив өгөх, эд материалын дэмжлэг үзүүлэхийг аливаа хэлбэрээр албадах, дарамт үзүүлэх, заналхийлэхийг хориглоно” гэж заасан нь шашин эсхүл итгэл үнэмшлийг албадаж өөрчлөхөөс ангид байх эрхийг хамгаалсан. Албадах үйл ажиллагаанаас сэргийлэх нь олон улсын эрх зүйд нийцэж байгаа ч дээр дурдсанчлан төвийг сахисан хуулийн заалтуудаар залилан, албадлагын асуудлыг ерөнхийд нь зохицуулах нь шилдэг түршлага юм.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй.<sup>36</sup> Мөн 2016 оны 2-р сарын 5-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг баталгаажуулсан. Иймд “хориглол” тавьсан заалт тусгах нь зайлшгүй бус гэж үндэслэж болно.<sup>37</sup> 2015 оны 12-р сарын 3-ны өдрийн Монгол Улсын Эрүүгийн хууль (Эрүүгийн хууль гэх)-д албадлага, сүрдүүлэг, залилан, авлига, хээл хажууль болон хүчирхийллийн талаар нэгэнт тусгасан бөгөөд энэхүү хууль нь шашны байгууллагад Монгол Улс дахь аливаа бусад хуулийн этгээдийн нэгэн адил үйлчилнэ.<sup>38</sup>

<sup>36</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16.15-р зүйл.

<sup>37</sup> Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.1.4-р зүйл.

<sup>38</sup> Эрүүгийн хуулийн 4.4-р зүйлд **албадлагыг** дараах байдлаар тодорхойлсон байдаг:

1. Өөрт нь, гэр бүлийн гишүүн, бусад хүнд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол, хор үршиг учруулахаар заналхийлсний улмаас бусдын эрхшээлд гарцаагүй автаж хийсэн энэ хуульд заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй.
2. Бусдыг бие махбод, сэтгэл санааны албадлага, эрхшээлд оруулж гэмт хэрэг үйлдүүлсэн хүнийг тухайн гэмт хэргийг үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.
3. Бусдын заналхийлсэн аюулаас илтэд хэтрүүлж гэмт хэрэг үйлдсэн бол албадлага, эрхшээлд автсан гэж үзэхгүй. [Өөрөөр хэлбэл үйлдсэн гэмт хэрэг нь бусдыг заналхийлсэн аюулаас хэтэрсэн тохиолдолд тухайн этгээд өөрийгөө хамгаалж, бусдын албадлагад автаж (тухайлбал хэн нэгний хяналт эсхүл заналхийлэл дор) гэмт хэрэг хэрэг үйлдсэн гэж маргаж болохгүй]

Эрүүгийн хуулийн 13.5.1-р зүйлд **заналхийлэх** гэмт хэргийг тодорхойлсноор бусдыг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг шаардаж өөрт нь, түүний ойр дотнын хүнд хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь хохирол учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн бол 450,000-2,700,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд түстэй ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг бүлэглэж; зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн бол 1,350,000-10,000,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (Эрүүгийн хуулийн 13.5.2-р зүйл). Энэ гэмт хэргийг албан тушаалтан бүрэн эрхээ урвуулан ашиглаж; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (Эрүүгийн хуулийн 13.5.3-р зүйл).

Эрүүгийн хуулийн 17.3.1-р хэсэгт **залилах** гэмт хэргийг тодорхойлж, ял шийтгэлийг заасан байдаг. 17.3-р зүйлд зааснаар хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, **сүсэг бишрэлийг далимдуулах**, бодит байдлыг нуух

Бүртгэлтэй шашны байгууллагад харьяалагдаагүй хувь хүмүүс болон бүртгэлгүй шашны бүлгүүдийг гишүүн бус хүмүүст шашны сургалт явуулахыг хатуу хориглож байгаа нь шашны итгэл үнэмшлээ хуваалцахад тавьсан ноцтой хязгаарлалт байна. 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт “Шашны бүлэг нь шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны болон шашны ёс зүйн талаар сургалтыг зөвхөн бүлгийн гишүүдийг оролцуулан зохион байгуулах эрхтэй” гэж заасан. Бүлгүүд уг эрхийг эдэлж чадахгүй байхад Хуулийн төслийн 8 дугаар зүйлд шашны байгууллага “Шашны аль нэг чиглэлийн сургаал, номлолд үндэслэн шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны болон шашны ёс зүйн сургалт, боловсрол олгох, ном судар бүтээх зэргээр *шашныг ухуулан дэлгэрүүлэх*, олон нийт, сүсэгтэн болон дагагч нартаа мөргөл, тахилга, залбирлын чиглэлээр нээлттэй үйлчлэх зорилготой хуулийн этгээд” хэмээн тодорхойлсноор бүртгэлтэй шашны байгууллагууд дээрх эрхийг эдэлж байна.

---

замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол 450,000-14,000,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж; бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 10,000,000-40,000,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (*Эрүүгийн хуулийн 17.3.2-р зүйл*). Энэ гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж; бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол 10,000,000-40,000,000 төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (*Эрүүгийн хуулийн 17.3.3-р зүйл*). Ижил төрлийн гэмт хэргийг “байнга үйлдэж амьдралын эр үүсвэр болгосон; олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” (*Эрүүгийн хуулийн 22-р бүлэг. 22.2-р зүйлийг хүчингүй болсонд тооцсон болохыг анхаарна үү*).

Эрүүгийн хуулиар доор дурдсан нийт 11 төрлийн авлигын эсхүл хээл хахуулийн гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулдаг:

- 22.1-р зүйл: албан тушаал [албан тушаалын] эрх мэдэл болон албан тушаалын байдлаа урвуулан ашиглах;
- 22.3-р зүйл: гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах;
- 22.4-р зүйл: хахууль авах;
- 22.5-р зүйл: хахууль өгөх;
- 22.6-р зүйл: гадаад улсын төрийн байгууллага эсхүл олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах;
- 22.7-р зүйл: улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх;
- 22.8-р зүйл: төсвийн хөрөнгийг (зориулалтын бусаар) зарцуулах;
- 22.9-р зүйл: төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах;
- 22.10-р зүйл: үндэслэлгүйгээр хөрөнгөжих;
- 22.11-р зүйл: дураараа аашлах; мөн
- 22.12-р зүйл: хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах.

“**Урвуулан ашиглах**” гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно. “Албан тушаалын байдал” гэдэг нэр томъёонд албан тушаалтай холбоотой эрх нөлөө хамаарна.

30 дугаар зүйлийн 30.6 болон 30.7 дахь хэсгүүдэд бүртгэлтэй шашны байгууллагыг төлөөлөх эрх олгосон баримт бичигтэй иргэн шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг хүмүүст явуулахаар хязгаарлажээ.

Дээрх хэсгүүдэд тайлбарласны дагуу шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний үндсэн үзүүлэлтүүдийг хориглож, зөвхөн бүртгэлтэй шашны байгууллагын эрх бүхий төлөөлөгчидтэй харилцах, мэдээлэл авахаар хувь хүний боломжийг хязгаарласан нь олон улсын хэм хэмжээний гол заалтууд, нэн ялангуяа хүн өөрийн сонгосон шашин эсхүл итгэл үнэмшилтэй байх буюу болох эрхийг зөрчиж байна. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгчийн тайлбарласнаар “бүртгэл нь заавал хийгддэг байх хэрэггүй; өөрөөр хэлбэл, бүртгэл нь хүний шашин шүтэх эрхийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл байх ёсгүй, харин зөвхөн хуулийн этгээдийн статусыг олж авах зорилготой байна.”<sup>39</sup>

Европын Хүний эрхийн шүүх төрөөс бүх шашны үйл ажиллагааг заавал бүртгүүлэх шаардлага тавьснаар “төрд албан ёсоор бүртгүүлээгүй цөөнхийн шашны итгэл үнэмшлийг үгүйсгэж, улмаар хүн юунд итгэж үнэмших ёстойг төрөөс зааж өгөх боломжтой гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ. Шүүх ийм аргачлалтай санал нийлэхгүй бөгөөд шашин чөлөөтэй шүтэх эрхийн энэ хязгаарлалт нь нийгмийн тулгамдсан хэрэгцээтэй уялдаагүй, улмаар ардчилсан нийгэмд зайлшгүй бус хөндлөнгийн оролцоог бүрдүүлсэн.”<sup>40</sup>

“Төрийн зөвшөөрөл нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хэрэгжүүлэх нөхцөл байж болохгүй. Хүн болон хамтлаг нь албан зөвшөөрлөөс хамаарахгүйгээр шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхтэй учир шашин, итгэл үнэмшлээ нийтийн өмнө эсхүл хувиараа, ганцаар эсхүл бусадтай хамтран илчлэх эсэхээс үл хамааран уул эрх чөлөөгөө эдлэхэд урьдчилан бүртгүүлэх эсхүл өөр адил журмыг хангахаар зохицуулж болохгүй. Түүнчлэн энэ нь... бүртгэлгүй үйл ажиллагааг хуулиар хориглох, шийтгэх нь олон улсын стандартад нийцэхгүй гэсэн үг.” гэж ЕАБХАБ/АИХЭА-ын Шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагийн эрх зүйн этгээд байх талаарх удирдамжид тайлбарлажээ.<sup>41</sup> Шашны итгэл үнэмшлээ

<sup>39</sup> Шашин шүтэх, итгэл үнэмшлийн эрх чөлөөний асуудлаарх тусгай илтгэгч Хэйнэр Биелефелдтийн гаргасан тайлан, 2011 он, 41-р хэсэг.

<sup>40</sup> Масаев ба Молдавын хэрэг № 6303/05 E.Ct.H.R. (2009 оны 5-р сарын 12-ны өдөр), 26-р догол.

<sup>41</sup> ЕАБХАБ/АИХЭА-аас гаргасан Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014 он) 13-р хэсэг, Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх шинжээчдийн зөвлөхийн багаас Ардчилал тогтоох Европын хороо (Венецийн комисс)-той зөвлөлдөн гаргаж, Венецийн комиссоор батлуулан (2004 оны 6-р сарын 18-19, Венец) АИХЭА-ны парламентийн чуулганаар (2004 оны 7-р сарын 5-9, Эдинбург) танилцуулсан Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг хэлэлцэх тухай удирдамж (цаашид “2004 оны АИХЭА-ны зөвлөмж гэх) харна үү. (“ЕАБХАБ хуулийн этгээдийн статустай болох, үг статусыг хадгалж үлдэх эрхтэй байхын ач холбогдлыг мэдсээр ирсэн. Учир нь зарим шашны бүлгүүд ...төрөөс тавьсан шаардлагуудыг биелүүлэхээс татгалздаг бөгөөд төрөөс бүртгэл хийлгэх сонголтыг хийгээгүй шашны бүлгүүдэд Төрийн зүгээс аливаа хориг эсхүл хязгаарлалт тавьж болохгүй”).

бүртгэлтэй шашин болон түүний эрх бүхий төлөөлөгчидтэй хуваалцахаар хязгаарлах нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний талаарх олон улсын гол хэм хэмжээтэй зөрчилдөнө.

Уг хуулийн төслөөр бүртгэлтэй шашны байгууллагын үйл ажиллагаа болон зан үйлд маш олон ерөнхий, агуулгын шинжтэй хязгаарлалтыг тавьжээ. Тухайлбал 11 дүгээр зүйлийн 11.4.5-д зааснаар “харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг түгээн дэлгэрүүлэхээр бол” шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгохоос татгалздаг. Үүний адилаар 27 дугаар зүйлийн 27.2.14 дэх хэсэгт шашны байгууллага “харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хууль бус бусад аргаар явуулах”-ыг хориглодог. Харгис бөгөөд хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулах нь илтэд асуудалтай бөгөөд одоогийн мөрдөж буй хуулиар хориглогддог ч энэхүү заалтын хамрах хүрээ өргөн, тодорхойлогдоогүй нь түүнийг дур зоргоор хэрэгжүүлэх боломжийг нээнэ. Зарим хүмүүс хөвч таслах, амьтан нядлах болон бусад шашны зан үйлийг харгис бөгөөд хүмүүнлэг бус гэж үздэг.

Шашны байгууллагаас шашныг бусдад ятгах үйл ажиллагааг хязгаарласан урт, тодорхойгүй жагсаалтыг 27 дугаар зүйлд тусгасан. 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх хэсэгт “шашны байгууллагад элсүүлэх, эсхүл гишүүнчлэлээс гарахгүй байх зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, иргэний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр хүндэд нь хохирол учруулахаар сүрдүүлэх, хууль бус бусад үйл ажиллагаа явуулах замаар саад болох”-ыг шашны байгууллагад хориглоно гэж заасан. Түүнчлэн 27 дугаар зүйлийн 27.2.6 дахь хэсэгт заасны дагуу хандив, тусламж, өргөл барьц барихыг шаардах, албадахыг, хориглох ба 27.2.7 дахь хэсэгт “сүсэг бишрэл болон эмзэг байдлыг нь ашиглан үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх”-ыг хориглосон. 27 дугаар зүйлийн 27.2.10 дахь хэсэгт зааснаар “шашны номлол, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах” болон “давуу байдал тогтоох” оролдлого хийхийг хориглоно. Мөн “шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, хэт даврах болон салан тусгаарлахыг ухуулах, уриалах зэргээр үндэсний эв нэгдлийг бусниулах үйл ажиллагаа” явуулахыг 27.2.13 хэсэгт мөн хориглосон.

27 дугаар зүйлийн 27.2.11 дэх хэсэгт зааснаар байгууллагуудыг “энэ хуулийн 8.10.2 болон 8.10.3 дахь хэсэгт заасан хүнийг шашны байгууллагын гишүүнээр элсүүлэх, шашны байгууллагаас зохион байгуулах шашин үхуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцуулах”-ыг хориглоно гэж заасан. Гэвч, Хуулийн төслийн 8.10 дахь хэсэг гэж байхгүй байх тул энд заасан хүнийг дурдсан хэсэг нь хуулийн төслийн өөр хэсэг шилжсэн гэж харагдаж байна.

Гишүүд болон бусад этгээдийг албадах, аюул учруулахаас урьдчилан сэргийлэх гэсэн эдгээр заалтын зорилго нь төрийн хэрэгжүүлэх хууль ёсны зорилт мөн боловч

эдгээр заалтууд бүрхэг байгаа нь тэдгээрийг хэт явцууруулж эсхүл дур зоргоор тайлбарлахад хүргэнэ. АИХЭА-ны удирдамжид энэ балансыг тайлбарласан:

“үзэл бодол, итгэл, үнэмшлээ илэрхийлэх эрх нь хүний туршлагын хамгийн чухал хэм хэмжүүр бөгөөд энэ эрх нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөнд болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд багтаж хэрэгждэг гэдгийг санаж явах нь чухал. Гэвч зарим тохиолдолд шашныг ятгах эрх “шугам”-аас хэтэрч албадлагын шинж чанартай болдог. Уг шугамаас хэтэрсэн эсэхийг үнэлэхдээ шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхэнд өргөн хүрээний хамгаалалт өгөх хэрэгтэй...”<sup>42</sup>

Эдгээр заалт хэт өргөн хүрээтэй бичигдэж, шашин руу тусгайлан чиглэж буй нь зарим шашны уламжлалын энгийн зан үйлийг хязгаарлах боломжтой. Хандив өгөхийг хүсэж буйг хандив өгөхийг шаардаж байна гэж зарим хүн ойлгодог (иргэнийг “шашны үйл ажиллагаанд хандив өргөх эсхүл эд материалын дэмжлэг үзүүлэхийг аливаа хэлбэрээр албадах, дарамт үзүүлэх, заналхийлэх”-ийг хориглосон 4.7-р зүйлийн зөрчил). Гишүүдэд хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх нь хүмүүсийг мөнгөн амлалт өгч шашинд элсэхийг шахаж буй мэтээр ойлгогдох магадлалтай. Зарим улсад цөөнхийн итгэл үнэмшил нь хүчирхийлэл, албадлага хэрэглэхтэй холбоогүй байсан ч шашны “эктремист” үзлийг хориглосон заалтаар шийтгэгдэж байсан. Дээр дурдсанчлан, шашин, итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхахыг эсхүл “давуу байдал үүсгэх”-ийг бүлгүүдэд хориглох нь шашны асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй солилцох явцад шашнуудыг хооронд нь энгийнээр харьцуулж ярихыг ч хориглоход хүрч мэднэ.

Албадах, шахахыг ерөнхийд нь хориглосон, төвийг сахисан хуулийн заалтуудад тулгуурлах нь эдгээр тохиолдолд хэрэглэх шилдэг туршлага юм. АИХЭА-ны Удирдамжид заахдаа: “Хэрэв хууль тогтоомжоор шашин түгээх ажил (missionary work)-ыг хязгаарласан тохиолдолд тухайн хязгаарлалт нь шашны итгэл үнэмшил оролцсон эсэхээс үл хамааран албадлага эсхүл залилахтай ижил төстэй үйлдэл гаргасан нөхцөлд л зөвтгөгдөнө.”<sup>43</sup>

Зарим зүйлүүдэд албадлагын бус аргаар бусдын шашныг өөрчлөхийг оролдох эрхийг хязгаарласан. Хуулийн төсөлд бусдад шашныг ухуулан дэлгэрүүлэхийг зайлшгүй бусаар хязгаарласан хэд хэдэн заалтыг оруулсан байна. Тухайлбал, 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “шашин ухуулан дэлгэрүүлэх зорилго”-оор хэвлэл

---

<sup>42</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх шинжээчдийн зөвлөхийн багаас Ардчилал тогтоох Европын хороо (Венецийн комисс)-той зөвлөлдөн гаргаж, Венецийн комиссоор батлуулан (2004 оны 6-р сарын 18-19, Венец) АИХЭА-ны парламентын чуулганаар (2004 оны 7-р сарын 5-9, Эдинбург) танилцуулсан Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг хэлэлцэх талаар зөвлөмж, 20.

<sup>43</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх шинжээчдийн зөвлөхийн багаас Ардчилал тогтоох Европын хороо (Венецийн комисс)-той зөвлөлдөн гаргаж, Венецийн комиссоор батлуулан (2004 оны 6-р сарын 18-19, Венец) АИХЭА-ны парламентийн чуулганаар (2004 оны 7-р сарын 5-9, Эдинбург) танилцуулсан Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг хэлэлцэх талаар зөвлөмж, 20.

мэдээллийн байгууллага байгуулахыг зөвхөн төвлөрсөн шашны байгууллагаар хязгаарласан. Мөн, 30.6 болон 30.7-д зөвхөн албан баримт бичгийн дагуу “шашны байгууллагын нэрийн өмнөөс шашны байгууллагуудын удирдлага, гишүүн эсхүл тусгайлан томилсон шашны байгууллагын номлол түгээгч”-д шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг. Дээр дурдсан шашны итгэл үнэмшлээ хуваалцахыг бүртгэлтэй байгууллагаар хязгаарласан шиг эдгээр хязгаарлалт нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх үндсэн эрх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавьсан зайлшгүй бус, тохиромжгүй хязгаарлалт юм.

30 дугаар зүйлийн 30.4, 30.5 болон 30.8 дахь хэсэгт шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг тодорхой газарт явуулахаар хязгаарласан байна. Шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг шашин буюу итгэл үнэмшлээ “ганцаарчлан буюу бусадтай хамтран нийтийн өмнө эсхүл хувиараа” “шүтэх, дагах, хэрэгжүүлэх, сургах” замаар илчилж болно.<sup>44</sup> Уг эрх чөлөөг зөвхөн “нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй тохиолдолд” л хязгаарлаж болно.<sup>45</sup> Оршин суугчид шашныг ухуулан дэлгэрүүлэхийг оролдож буй хүмүүсээс зай барих эрхтэй тул амралтын цагаар хувь хүн эсхүл оршин суугчдад хандахад үндэслэл бүхий, төвийг сахисан хязгаарлалт тавих нь тохиромжтой байж болох хэдий ч орон сууцны байршилд шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг бүрэн хориглох нь зайлшгүй бус юм. Шашин эсхүл итгэл үнэмшлээ илчлэх нь бусдыг хохироогоогүй, өмчлөх эрхэд халдаагүй эсхүл нийтийн аюулгүй байдлыг алдагдуулаагүй бол шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг нийтэд нь хориглох нь зохисгүй юм.

### **Санал – Шашны итгэл үнэмшлээ бусадтай хуваалцахад тавьсан хязгаарлалтын талаар**

- Гишүүн бус хүмүүсийг оролцуулах агуулгыг 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт нэмж оруулах.
- 27 дугаар зүйл дэх өргөн хүрээг хамарсан хязгаарлалт болон одоогийн хуулийн заалтуудыг давтсан зүйлсийг хасах эсхүл тодруулах.
- 27 дугаар зүйлийн 27.2.13 дахь хэсэг дэх “шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, хэт даврах болон салан тусгаарлахыг ухуулах, уриалах зэргээр үндэсний эв нэгдлийг бүснүүлэх үйл ажиллагаа явуулах” гэдэг нь ямар утга агуулгатай болохыг тодруулах. Энэ нь шашны ялгаатай үзэл бүхий хүмүүсийн хоорондох маргаан бүхий хэлэлцүүлгийг бүхэлд нь хориглох учиргүй.
- 27 дугаар зүйлийн 27.2.11 дэх хэсэг одоогийн Хуулийн төсөлд хамаарахгүй байх учир хасах.

---

<sup>44</sup> ИУТЭТОУП-ын 18.1-р зүйл.

<sup>45</sup> ИУТЭТОУП-ын 18.3-р зүйл.

- Хэвлэл мэдээллийн байгууллагыг хязгаарласан 30 дугаар зүйлийн 30.1 болон 30.2 дэх хэсгүүдэд хувь хүн, бүртгэлгүй шашин, орон нутгийн шашны байгууллага болон бүлгийг багтаах. 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийг хасах.
- Бусдад шашин үхуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийг хязгаарласан 30 дугаар зүйлийн 30.6 болон 30.7 дахь хэсгийг хасах.
- Бусдад шашныг үхуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах байршлыг хязгаарласан 30 дугаар зүйлийн 30.4, 30.5, 30.8 дахь хэсгийг хасах.

## **6. Шашны ном зохиолд тавьсан хязгаарлалт**

### **1. 1993 оны хууль**

1993 оны Хууль шашны ном зохиолыг шууд хориглосон зохицуулалтгүй бөгөөд 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “шашны ном судар бүтээх” шашны байгууллагын эрхийн талаар дурдсан байна. Энэхүү заалтад шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний нэн чухал ойлголтын талаар тусгасан боловч үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний онцгой шинж болсон шашны ном зохиол үйлдвэрлэх, түгээх эрхүүдийг тусгаагүй. Эдгээр эрхийг тусгаагүй байдал нь 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох” нөхцөлд “сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах... шаардлагатай бол зогсоох” гэсэн заалттай хосолсноор асуудал үүсгэж байна. Үүнтэй адилаар, “хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэх” талаарх өмнө дурдсан хориглолт нь шашны ном зохиолыг түгээхийг оролдсон үйлдлийг шийтгэхэд хүргэх үндэслэл болж магадгүй. “Санаа сэтгэлийг үймүүлэх” болон “ хууран мэхлэх” гэдэг нь ихэнх тохиолдолд шинэ эсхүл жижиг бүлгүүдэд эсхүл уламжлалт итгэл үнэмшлийг шүүмжлэгч хүмүүст хамааруулан хэрэглэх магадлалтай субъектив ойлголт юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зааснаар “Хүн бүр үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах, мөн үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан хэвлэл мэдээллийн аливаа хэрэгслээр эрж хайх, хүлээж авах, түгээх эрх чөлөө багтана” гэжээ.<sup>46</sup> ИУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд “(а) бусдын эрх, нэр хүндийг хүндэтгэх; (б) үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл

<sup>46</sup> ХЭТТ-ын 19-р зүйл, ИУТЭТОУП-ын 19-р зүйлийг мөн харна уу (“1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. 2. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана.”)

мэнд, ёс суртахууныг хамгаалах”<sup>47</sup> зорилгоор үг хэлэх эрх чөлөөг зарим талаар хязгаарлахыг зөвшөөрдөг боловч үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөлд гэж заасан 1993 оны Хуулийн зохицуулалт хэт өргөн хүрээг хамарч байна. Үүнээс үл хамааран, шашнаа илчлэх эрх (үг хэлэх эрхээс ялгаатай)-ийг үндэсний аюулгүй байдлаас шалтгаалан хязгаарлаж болохгүй.

ИУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлээр хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд шашны талаарх хэлэлцүүлгийг багтаан үзэхийг НҮБ-ын Хүний эрхийн хорооноос онцлон тэмдэглэсэн.<sup>48</sup> Энэ эрхийг хязгаарлахын тулд улсууд “түхэйн аюул заналын тодорхой шинж чанарыг болон авсан арга хэмжээний зайлшгүй, тохирсон байдлыг нарийн дэлгэрэнгүй харуулж, нэн ялангуяа үзэл бодлын илэрхийлэл болон аюул заналын хоорондох шууд, ойрын хамаарлыг гаргах ёстой.”<sup>49</sup> Экстремизмд тулгуурласан хүчирхийллийн үлмаас үндэсний аюулгүй байдалд санаа зовох нь хэтэрхий өргөн хүрээтэй бөгөөд 1993 оны Хуульд заасан нээлттэй хориглолт нь тохиромжгүй байна. Ямар ч тохиолдолд шашнаа илчлэх эрх (үг хэлэх эрхээс ялгаатай нь)-ийг үндэсний аюулгүй байдлаас шалтгаалан хязгаарлаж болохгүй; “Үндэсний аюулгүй байдал зэрэг нь Пактаар хамгаалагдсан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болдог байсан ч гэсэн эдгээр нь (18-р зүйл)-д тусгайлан дурдагдаагүй бол түхэйн үндэслэлээр хязгаарлалт хийхийг зөвшөөрөхгүй” гэсэн тайлбарыг НҮБ-ын Хүний эрхийг хорооноос өгсөн.<sup>50</sup>

Монгол Улсад одоо мөрдөгдөж буй “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-аар Монгол Улсын иргэн, улс төрийн нам болон төрийн бус байгууллагаас нийтийн гудамж, талбайд зохион байгуулж буй жагсаал<sup>51</sup> болон цуглааныг<sup>52</sup>

---

<sup>47</sup> ИУТЭТОУП-ын 19-р зүйл.

<sup>48</sup> Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №34, НҮБ-ын Б.6 ССР/С/С/34, ¶ 11 (2011 оны 7-р сарын 11–29).

<sup>49</sup> Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №34, НҮБ-ын Б.6 ССР/С/С/34, ¶ 11 (2011 оны 7-р сарын 11–29), 35-р догол.

<sup>50</sup> Ерөнхий тайлбар №22, 8-р догол (“18-р зүйлийн 3-р хэсгийг нарийн тайлбарласан болохыг Хорооны зүгээс тэмдэглэв: Дээрх зүйл дурдагдсан үндэслэлээр хязгаарлалт тавихыг зөвшөөрөхгүй боловч Пактаар хамгаалагдсан бусад эрхүүд (үндэсний аюулгүй зэрэг)-д хязгаарлалт тавьж болно.) ИУТЭТОУП-ын 19-р зүйлд зааснаар үг хэлэх эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлахыг зөвшөөрдөг боловч зөрчил гаргаж буй улс орнууд эдгээр хязгаарлалтыг хараахан хэрэгжүүлээгүй байгаа ба шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний нэг хэсэг болох шашны холбогдолтой үг хэлэх, номлохыг хязгаарласан заалтууд нь цөөн байна. Түхэйлбал, үг хэлэх эрх эдлэх нь “онцгой үүрэг, хариуцлага дагуулдаг. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: (а) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх; (б) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.” ИУТЭТОУП-ын 19-р зүйл, 18-р зүйл (шашин шүтэх эрхтэй холбогдуулан тавих зөвшөөрөгдсөн хязгаарлалтын жагсаалтад үндэсний аюулгүй байдлыг оролцуулаагүй).

<sup>51</sup> Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал шаардлагаа илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг “цуглаан” гэнэ (Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 3.1-р зүйл).

<sup>52</sup> Иргэд хот суурины гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, улс төр, нийгэм, эдийн засаг болон хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг “жагсаал” гэнэ (Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 3.2-р зүйл).



зохицуулдаг.<sup>53</sup> Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т зааснаар үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглодог.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсэгт экстремист үйл ажиллагаа явуулсан тохиолдолд авах хориг арга хэмжээний талаар заасан. Үндсэн хуульт тогтолцоо, төрийн байгууламжийг хууль бусаар, хүч хэрэглэн өөрчлөх, устгах зорилгоор улс төр, шашны үйл ажиллагаа явуулсан, энэхүү үйл ажиллагаа явуулахаар тодорхой бүлэг байгуулсан, бусдыг элсүүлсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ<sup>54</sup> гэж заасан.

## 2. Хуулийн төсөл

Хуулийн төслийн хэд хэдэн зүйлээр шашны холбогдолтой материал үйлдвэрлэх, импортлохыг хориглосон. 29 дүгээр зүйлийн 29.4 болон 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгүүдэд олон нийтийн хэрэгцээнд шашны ном зохиол болон материалыг нийтлэх, үйлдвэрлэх, экспортлох, импортлохыг хязгаарлаж, мөн хэвлэл мэдээллийн байгууллага байгуулахыг төвлөрсөн шашны байгууллагаас бусад хуулийн этгээдээр явцууруулсан.

29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт шашны байгууллага өөрийн дотоод хэрэгцээ, залбирал, шүтлэгт зориулсан зүйлсийг хэвлэхийг зөвшөөрсөн боловч 29 дүгээр зүйлийн 29.3, 29.4 дэх хэсэгт зөвхөн төвлөрсөн шашны байгууллагаас “олон нийтэд зориулж шашны ном, зохиол хэвлэх хэвлэх”-ээр хязгаарлаж, “төвлөрсөн шашны байгууллагаас бусад хуулийн этгээд шашны ном, зохиол, шашны зориулалттай эд зүйлсийг олон нийтэд худалдах, түгээх зорилгоор хэвлэх, үйлдвэрлэх, экспортлох, импортлох”-ыг хориглосон.

Тусгай илтгэгч “Шашны ном зохиолыг импортлох, хэвлэх, түгээх эсхүл зүгээр л эзэмшихэд хүртэл зөвшөөрөл авахыг шаардах нь шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний талаарх олон улсын стандартад нийцэхгүй байна. Хүний эрхийг хязгаарлах нь онцгой тохиолдол байх бөгөөд нийтлэг зарчим болж болохгүй. Уг хязгаарлалт тогтоосон заалтууд нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөрчиж байна” гэж тэмдэглэжээ.<sup>55</sup>

Эдгээр заалтууд үг хэлэх, шашин шүтэх эрх чөлөөний талаарх олон улсын хэмжээг илэрхий зөрчиж байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Хүн бүр үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэд үзэл бодлоо

<sup>53</sup> Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 4.1-р зүйл.

<sup>54</sup> Эрүүгийн хуулийн 19.8.1-р зүйл.

<sup>55</sup> Тусгай илтгэгч 2018 онд Узбекистан улсад албан томилолтоор явах үедээ шашин, шүтлэгтэй байх эрх чөлөөний талаар гаргасан тайлан, 82-р догол

ямар ч хорио саадгүй баримтлах, мөн үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан хэвлэл мэдээллийн аливаа хэрэгслээр эрж хайх, хүлээж авах, түгээх эрх чөлөө багтана” гэж заасан.<sup>56</sup> ИУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлд зааснаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг эдлэх нь

онцгой үүрэг, хариуцлагатай хамт оноогдоно. Тийм учраас түүнд тодорхой хязгаарлалт тавьж болох боловч тэр нь зөвхөн хуулиар тогтоосон бөгөөд дараах зорилгод хүрэхэд зайлшгүй байна: (а) бусдын эрх, эрх чөлөө, нэр хүндийг хүндэтгэх; (b) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.”<sup>57</sup>

ИУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлээр хамгаалагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд шашны хэлэлцүүлгийг багтаадаг болохыг НҮБ-ын Хүний эрхийн хороо тусгайлан тэмдэглэжээ.<sup>58</sup> Уг эрхийг хязгаарлахын тулд улсууд “тухайн аюул заналын тодорхой шинж чанарыг болон авсан арга хэмжээний зайлшгүй, тохирсон байдлыг нарийн дэлгэрэнгүй харуулж, нэн ялангуяа үзэл бодлын илэрхийлэл болон аюул заналын хоорондох шууд, ойрын хамаарлыг гаргах ёстой.”<sup>59</sup> Шашны материал үйлдвэрлэхийг бүртгэлгүй бүлэг болон хувь хүнд хавтгайруулж хориглосон нь Монгол Улсын эрх зүйд байгаа хязгаарлалтаас хэт өргөн, бас тохиромжгүй байна.

Монгол Улсын иргэдийн шашны итгэл үнэмшил болон холбогдох материалыг тараах боломжийг хязгаарласан нь Монгол Улсын ЕАБХАБ-д өгсөн амлалтуудыг зөрчиж байна. 2012 онд Монгол Улс ЕАБХАБ-ын гишүүн болсноор “шашны бүлэг, институт болон байгууллагыг шашны холбогдолтой зохиол бүтээл, материалыг үйлдвэрлэх, импортлох, түгээхийг зөвшөөрөх,”<sup>60</sup> “итгэгч хувь хүн болон хамтлагуудын ариун судар, шашны зохиол бүтээл болон шашны үйл ажиллагаатай холбоотой бусад хэвлэл, материалыг өөрийн сонгосон хэлээр олж авах, эзэмших, ашиглах эрхийг хүндэтгэх” амлалтыг өгсөн.<sup>61</sup> Үүний адилаар Монгол Улс “хувь хүнд мэдээллийн эх сурвалжаа чөлөөтэй сонгох баталгаа олгож, зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн эрхүүдийг дээдлэхийн зэрэгцээ хувь хүн, институт болон

---

<sup>56</sup> ХЭТТ-ын 19-р зүйл; мөн ИУТЭТОУП-ын 19-р зүйлийг харна уу (“1. Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. 2. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”).

<sup>57</sup> ИУТЭТОУП-ын 19-р зүйл.

<sup>58</sup> Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №34, НҮБ-ын Б.6 ССР/C/GC/34, ¶ 11 (2011 оны 7-р сарын 11–29).

<sup>59</sup> Хүний эрхийн хороо, Ерөнхий тайлбар №34, НҮБ-ын Б.6 ССР/C/GC/34, ¶ 11 (2011 оны 7-р сарын 11–29), 35-р догол.

<sup>60</sup> 1989 оны 1-р сарын 17-ны өдөр болсон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны чуулганд оролцогч орнуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын Дүгнэлт баримт бичиг, Европ дахь аюулгүй байдлын талаарх асуулт, 16(с) дэх зарчим (1989 оны 1-р сарын 19) (цаашид “Венийн дүгнэлт баримт бичиг” гэх). 16.10-р догол мөр.

<sup>61</sup> Венийн дүгнэлт баримт бичиг, 16.9-р догол мөр.

байгууллагыг бүх төрлийн мэдээлэл олж авах, эзэмших, дахин үйлдвэрлэх, түгээх боломжоор хангах” амлалтыг өгсөн.<sup>62</sup>

### **Шашны холбогдолтой материалыг хязгаарлах нь**

- 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг дэх шашны бүлгүүдийн шашны холбогдолтой материал үйлдвэрлэх, хэвлэх эрхийг хязгаарласан заалтыг хасах.
- 29 дүгээр зүйлийн 29.3 болон 29.4 дэх хэсгүүд дэх олон нийтэд зориулж шашны холбогдолтой материал хэвлэх, үйлдвэрлэх, экспортлох, импортлох эрхийг зөвхөн төвлөрсөн шашны байгууллагад олгож хязгаарлалт бий болгосон заалтыг хасах.
- 1993 оны Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт “Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөлд” “... сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах, шаардлагатай бол зогсоох эрхтэй” гэж заасныг хасах эсхүл нарийвчлан тусгах.

## **В. Өөрийгөө засаглах эрх**

### **1. 1993 оны хууль**

1993 оны Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт Монгол Улс дахь шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхийн шалгуурыг тогтоосон. Үүнд “Төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглоно...” гэж зааснаар шашны өөрийгөө засаглах эрхийн ач холбогдлыг гаргаж ирсэн. Гэхдээ уг зүйлийн хоёрдугаар хагас хэсэгт “хууль тогтоомжид зааснаас” бусад тохиолдлыг бий болгосноор төрийн албан тушаалтныг сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс

---

<sup>62</sup> *Венийн дүгнэлт баримт бичиг*, 34-р догол мөр. Улс орнууд “Хүн бүр бусадтай харилцах зэрэг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрхэд төрийн эрх бүхий байгууллагын хорио саадгүйгээр, улсын хилийн заагаар үл хязгаарлагдан өөрийн үзэл бодолтой байх, үзэл санаа, мэдээллийг хүлээж авах, дамжуулах эрх чөлөөг хамруулан ойлгоно. Энэ эрхийг зөвхөн хуульд заасан бөгөөд олон улсын стандартад нийцсэн зүйл, заалтаар хязгаарлаж болно. Тухайлбал зохиогчийн эрх зэрэг оюуны өмчтэй холбоотой эрхүүдийг дээдлэхийн зэрэгцээ аливаа төрлийн баримт бичгүүдийг олж авах, ашиглах, дахин боловсруулахад ямар ч хязгаарлалт тавихгүй” гэдгийг дахин баталсан. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны чуулган, 1990 оны 6-р сарын 5-29, ЕАБХАЗ-ийн Хүний үйл ажиллагааны талаарх чуулганы Москва дахь уулзалтын баримт бичиг, 9.1-р зүйл (1990). Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны чуулган, 1994 оны 12-р сарын 5-6, Хамтын нөхөрлөлийн төлөөх шинэ зуун, Бүдапешт дахь чуулга уулзалт, 36-р догол мөр (1994) (“Оролцогч орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний суурь эрх бөгөөд ардчилсан нийгмийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болохыг дахин баталсан.”); Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Европын аюулгүй байдлын талаарх тунхаг бичиг (1999 оны 11-р сарын 19), 26-р догол мөр (“Бид мэдээллийн чөлөөт урсгал болон бүх нийтийн мэдээлэл хүлээн авах боломжийн талаарх ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байна. Бид ... олон улс хоорондын мэдээллийн чөлөөт урсгалыг бий болгоход шаардлагатай бүх арга хэмжээг авахаа амлаж байна.”).

оролцохыг зөвшөөрсөн хууль тогтоомжийг үзэмжээрээ нэмж батлах боломжийг төрд олгож байна. Дээр дурдсаны дагуу Хуулийн төслөөр эдгээр асуудлуудыг хөндсөн.

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт “Лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна” гэж заажээ. Төрийн зүгээс газрын ашиглалттай холбоотой асуудлыг зохицуулах, бүртгэлтэй шашны байгууллага бүртгэлтэй холбогдсон хуулийн наад захын шаардлагыг хангасан эсэхийг хянах туйлын сонирхолтой байдаг. Төрөөс лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлын талаар сонирхох эсхүл түүнд хяналт тавих зайлшгүй шаардлага байхгүй бөгөөд шашны байгууллага нь газар ашиглах нийтлэг шалгуурыг хангасан байхад хангалттай.

Шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхийг шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх олон улсын эрхийн үндсэн элемент гэж үздэг. НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайлбарласнаар “шашин буюу шүтлэгээ хэрэгжүүлэх, сургах гэдэгт өөрсдийн удирдагч, номлогч болон багшаа сонгох эрхээ эдлэх зэрэг шашны бүлгийн үндсэн асуудалд хамаарах үйл ажиллагааг багтаан ойлгоно...”<sup>63</sup> ЕАБХАБ/АИХЭА-аас өгсөн Удирдамжид “улсууд тухайн үндэстний хууль тогтоомжоор шашин, шүтлэгийн хамтлагт өөрийн удирдлага ... [болон] хамтлагийн бүтэц, лам санваартныг томилох арга зэргээ сонгон шийдвэрлэх боломжийг олгох үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх хэрэгтэй...” гэдгийг дурдсан.<sup>64</sup> ЕАБХАБ-ын амлалтад шашны хамтлагуудын “залбирах эсхүл цуглах боломжтой газрыг байгуулах, ажиллуулах” эрхийг хүлээн зөвшөөрсөн.<sup>65</sup>

7 дугаар зүйлийн 7.3 болон 7.5 дахь хэсэгт төрийн зүгээс юуг уламжлалт гэж үзэж байгаа вэ гэдэгт тулгуурлан сүсэг бишрэлтэй холбоотой дотоод зан үйл, дүрэм журамд хязгаарлалт тогтоосон нь өөрийгөө засаглах эрхийн асуудлыг үүсгэж байна. 7.3 дахь хэсэгт шашны зан үйлийг “тухайн шашны уламжлалт ёс журмын дагуу ... чөлөөтэй үйлдэж болно” гэж, 7.5 дахь хэсэгт “сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно” хэмээн тус тус заажээ. Шашны итгэл үнэмшил, зан үйлийг тодорхойлох нь шашны байгууллагын дотоод өөрийгөө засаглах эрхийн үндсэн хэсэг юм. ЕАБХАБ/АИХЭА-ны удирдамжид “Төрийн зүгээс эрх зүйн этгээд болох асуудлыг зохицуулахдаа шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлаг өөрийн удирдлага, дотоод журам, итгэл үнэмшлийн агуулга, хамтлагийн бүтэц, лам

---

<sup>63</sup> Ерөнхий тайлбар №22(48), 4-р догол.

<sup>64</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014), 31-р догол.

<sup>65</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны чуулганд оролцогч орнуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын Дүгнэлт баримт бичиг (1989) 16.4-р догол.

санваартнаа томилох арга хэлбэр болон нэр, бусад бэлэг тэмдгийг бие даан сонгон шийдвэрлэх боломжийг хуулиар баталгаажуулах үүрэг хариуцлагаа биелүүлэх хэрэгтэй” гэжээ.<sup>66</sup>

Европын Хүний эрхийн шүүх болон бусад эрх зүйн тогтолцоо нь шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхийг маш өргөн хүрээнд дэмждэг. <sup>67</sup> Түүхээс үзвэл энэ нь Магна Хартагийн үеэс эхлэлтэй шашны эрх чөлөөний талаарх хамгийн эртний бөгөөд амин чухал аспектиудын нэг юм. “Нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун болон бусдын суурь эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй тохиолдолд” шашнаа илчлэх эрхийг зөвхөн хуулиар зохицуулахыг зөвшөөрдөг.<sup>68</sup> Шашны өөрийгөө засаглах эрхийн хувьд түүнийг хязгаарлах “зайлшгүй” шаардлага нь аль болох нарийвчилсан хууль зүйн хязгаарлалт боловсруулах явдал юм.

## 2. Хуулийн төсөл

Хуулийн төслийн хэд хэдэн заалт нь төрийн аливаа оролцоогүйгээр шашны итгэл үнэмшлээ тодорхойлох болон шашны чиг үүргээ хэрэгжүүлэх боломжид, мөн шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхэд илтэд халдаж байна.

Шашны байгууллагын дотоод зохион байгуулалт болон өөрийгөө засаглах эрхэд халдахуйц хэд хэдэн заалт бий. 16-22 дугаар зүйлд хяналтын байгууллага болон гүйцэтгэх байгууллага байгуулахыг шаардах зэргээр шашны байгууллагын албан бүтцийг өргөн хүрээнд тогтоосон.

Эдгээр нарийн асуудлыг байгууллага өөрөө тодорхойлж байгууллагын дүрэмдээ тусгадаг. Төрөөс тухайн улсын хил дотор үйл ажиллагаа явуулж буй байгууллагын удирдах зөвлөлд тодорхой стандарт тавьж болох ч дээр дурдсан Хуулийн төслийн зүйлүүд нь шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхийг зайлшгүй биш байхад хязгаарлаж байна. Ихэнх шашны холбоодын зохион байгуулалтын бүтэц нь шашны удирдлага болон бүрэн эрхийн талаарх суурь итгэл үнэмшлийг тусгасан байдаг.

ЕАБХАБ/АИХЭА-ны Удирдамжид дараах тайлбарыг өгсөн:

Төрөөс шашны байгууллагыг хуулийн этгээдийн статус олж авах боломжоор хангах үүргээ биелүүлэхдээ тэрхүү шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагийн өөрийгөө засаглах эрхийг хүндэтгэх ёстой. Төрийн зүгээс эрх зүйн этгээд болох асуудлыг зохицуулахдаа шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлаг өөрийн удирдлага, дотоод журам, итгэл үнэмшлийн агуулга, хамтлагийн бүтэц, лам санваартнаа томилох арга

<sup>66</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014), 31-р догол.

<sup>67</sup> Бессараба ба Молдавын хэрэг, ЕХЭШ №45701/99 (2001 оны 12-р сарын 13)-ийг харна уу; Сериф ба Грекийн хэрэг, ЕХЭШ №38178/97, (1997 оны 12-р сарын 14); Хасан болон Чауш ба Болгарын хэрэг, ЕХЭШ №30985/96, (2000 он); Герард Робберс, Сүмийн өөрийгөө засаглах эрх (2001 он).

<sup>68</sup> ИУТЭТОУП-ын 18.3-р зүйл.

хэлбэрээ ...бие даан сонгон шийдвэрлэх боломжийг хуулиар баталгаажуулах үүрэг хариуцлагаа биелүүлэх шаардлагатай. Шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагуудын авч хэрэгжүүлж болох зохион байгуулалтын хэлбэр олон янз байдгийг харгалзан үзэж энэ салбарын үндэсний хууль тогтоомжид нэн уян хатан хандвал зохино.<sup>69</sup>

Хуулийн төслийн заалтууд нь шашны байгууллага өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлан дотоод бүтцээ тодорхойлох үндсэн эрхийг хязгаарлах замаар түүний өөрийгөө засаглах эрхийг зайлшгүй бусаар хязгаарлаж байна. Төрөөс холбооны зохион байгуулагч болон хариуцлага хүлээх этгээдийг тогтоох үндэслэл бүхий хэрэгцээ байдаг хэдий ч Хуулийн төслөөр дамжуулан хяналтын болон гүйцэтгэх байгууллагуудын ажил үүргийг заах зэргээр зохион байгуулалтын бүтцийн талаарх дэлгэрэнгүй зааварчилгаа өгөх нь өөр хэлбэрийн дотоод бүтэц бүхий байгууллагын шашны итгэл үнэмшилд халдаж болзошгүй.

Шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхийг шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх олон улсын эрхийн үндсэн элемент гэж үздэг. НҮБ-ын Хүний эрхийн хорооноос “шашин буюу шүтлэгээ хэрэгжүүлэх, сургах гэдэгт өөрсдийн удирдагч, номлогч болон багшаа сонгох эрхээ эдлэх зэрэг шашны бүлгийн үндсэн асуудалд хамаарах үйл ажиллагааг багтаан ойлгоно...” гэжээ.<sup>70</sup> ЕАБХАБ/АИХЭА-аас өгсөн удирдамжид “үлсууд тухайн үндэстний хууль тогтоомжоор шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагт өөрийн удирдлага ... [болон] хамтлагийн бүтэц, лам санваартныг томилох арга зэргээ сонгон шийдвэрлэх боломжийг олгох үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх хэрэгтэй...” гэдгийг дурдсан байна.<sup>71</sup>

Европын Хүний эрхийн шүүх болон бусад эрх зүйн тогтолцоо нь шашны байгууллагын өөрийгөө засаглах эрхийг маш өргөн хүрээнд дэмждэг. <sup>72</sup> Түүхээс үзвэл энэ нь Магна Хартагийн үеээс эхлэлтэй шашны эрх чөлөөний талаарх хамгийн эртний бөгөөд амин чухал аспектуудын нэг юм. “Нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун болон бусдын суурь эрх, эрх чөлөөг хамгаалахад зайлшгүй тохиолдолд” шашнаа илчлэх эрхийг зөвхөн хуулиар зохицуулахыг зөвшөөрдөг.<sup>73</sup> Шашны өөрийгөө засаглах эрхийн хувьд түүнийг хязгаарлах “зайлшгүй” шаардлага нь аль болох нарийвчилсан хууль зүйн хязгаарлалт боловсруулсан явдал юм. Шашны байгууллага удирдлагаа сонгох, түүнд тавих шаардлагыг тогтоох асуудлыг хуулиар зохицуулж байгаа нь шашны өөрийгөө засаглах эрхэд тавьсан ноцтой хязгаарлалт мөн.

---

<sup>69</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2015), 31-р догол.

<sup>70</sup> Ерөнхий тайлбар №22(48), 4-р догол.

<sup>71</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2014), 31-р догол.

<sup>72</sup> Бессараба ба Молдавын хэрэг, ЕХЭШ №45701/99 (2001 оны 12-р сарын 13)-ийг харна уу; Сериф ба Грекийн хэрэг, ЕХЭШ №38178/97, (1997 оны 12-р сарын 14); Хасан болон Чауш ба Болгарын хэрэг, ЕХЭШ №30985/96, (2000 он); Герард Робберс, Сүмийн өөрийгөө засаглах эрх (2001 он).

<sup>73</sup> ИУТЭТОУП-ын 18.3-р зүйл.

9 дүгээр зүйл нь нэр сонгохтой холбогдуулан шашны байгууллагын өөрийн засаглах эрхэд зайлшгүй бус хязгаарлалт тавьсан байна. 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шашны байгууллагад “шашны үйл ажиллагаагаа эрхэлдэг болохоо илэрхийлсэн агуулга бүхий нэр оноосон байна” гэсэн шаардлагыг тавих бөгөөд 9.4 дэх хэсэгт зааснаар “Монгол, Монгол Улсын, Үндэсний, Нийтийн болон Нэгдсэн” зэрэг нэр томъёо ашиглахыг Монгол Улсын нутаг дэвсгэрт 50-аас дээш жилийн хугацаагаар хууль ёсны үйл ажиллагаа явуулж буй төвлөрсөн шашны байгууллагаар хязгаарласан. Нэрээ сонгох нь шашны тодорхой итгэл үнэмшлээ илчлэх, шашнаа хэрэгжүүлэх хэлбэр байж болох учир шашны байгууллагын нэрийн сонголтод төрөөс хязгаарлалт тавих нь маргаантай асуудал юм. ЕАБХАБ-ын Удирдамжид “төрийн зүгээс шашны эсхүл итгэл үнэмшлийн хамтлагуудад ... өөрийн нэр болон бусад бэлэг тэмдгээ сонгон шийдвэрлэх боломжийг үндэснийхээ хуулиар олгож, үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх хэрэгтэй” гэсэн тайлбар өгдөг.<sup>74</sup>

38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт “Шашны байгууллага нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнээс мөнгөн болон бусад хөрөнгө, санхүүжилт авсан бол бодит зарцуулалт, ашиглалтын талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт өөрийн цахим хуудаст тухай бүр байршуулна” гэж заасны дагуу шашны байгууллагаас санхүүгийн тодорхой мэдээллээ цахим хэлбэрээр нийтлэхийг шаардсан. 39 дүгээр зүйлийн 39.4 болон 43 дугаар зүйлүүдэд зааснаар нууц мэдээллээ олон нийтийн мэдээллийн санд оруулах шаардлагыг шашны байгууллагад тавьсан байна.

38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсэгт “Хувь хүн, хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандивыг зориулалтын дагуу хандив өгөгчийн заасан хугацаанд зарцуулах бөгөөд хэрэв хандив өгөгч зарцуулах тодорхой хугацаа заагаагүй бол хандивыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор зориулалтын дагуу зарцуулна” гэж заажээ.

Мөн түүнчлэн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт “Шашны байгууллагаас бусад этгээд нийтэд зориулсан мөргөлийн газар, том орон зай эзлэх шашны зориулалт бүхий хөшөө дурсгал, суварга байгуулах”-ыг хориглосон.

36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт тавьсан шаардлагын дагуу шашны байгууллага байнгын ажлын байрыг дүрэмдээ тусгаж, тухайн ажлын байранд ажиллах иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулна.

Төрөөс шашны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа нь татвараас чөлөөлөгдөх боломжтой эсэх, мөн эдгээр байгууллагууд залилах, мөнгө угаах болон бусад гэмт хэрэгт оролцоогүй болохыг баталгаажуулах үндэслэл бүхий хэрэгцээ байдаг ч Хуулийн төсөлд шашны байгууллагын санхүүгийн талаар зайлшгүй бус хязгаарлалт нэмэлт тусгасан байна. Хуулийн төсөлд зааснаар гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авахыг шашны байгууллагад хориглодог (27.2.8). ЕАБХАБ/АИХЭА-аас

---

<sup>74</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин, шүтлэгийн нийгэмлэгийн эрх зүйн байдлын талаарх удирдамж (2015), 31-р догол.

гаргасан Шашин эсхүл итгэл үнэмшилтэй холбоотой хууль тогтоомжийг хянан үзэх тухай удирдамж энэ төрлийн заалтын талаар дараах тайлбарыг гаргасан: “Төрөөс хэд хэдэн төрлийн санхүүгийн гүйлгээнд зохицуулалт хийх хууль ёсны үндэслэл байж болох ч шашны бүлгүүдийг шашны үндэслэлээр ялгаварлан гадуурхсан заалтууд батлахыг зөвшөөрч болохгүй.”<sup>75</sup> Үүний нэгэн адилаар виза олгох асуудалтай холбогдуулан зарим шашны эсрэг ялгаварлан гадуурхах үйлдэл гаргахыг Европын Хүний эрхийн шүүхээс зөвшөөрөөгүй.<sup>76</sup>

Олон шашны бүлгүүд олон улсын хэмжээнд хамаарал бүхий байгууллагуудтай холбоотой байдаг. Ийм шашны байгууллага хууль ёсны үйл ажиллагаандаа дэмжлэг болгон гадаадаас санхүүгийн дэмжлэг авах, үзүүлэх боломжийг хязгаарлах нь Монгол Улсын байгууллагуудыг зайлшгүй бусаар сулруулж, цаашид Монгол Улсын өнцөг булан бүрд нөлөөлөх, иргэдэд үр ашгаа өгөх орлогыг бүхэлд нь зогсооно. Гагцхүү нийтийн аюулгүй байдал эсхүл нийтийн хэв журамд заналхийлсэн терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх гэх мэт “нийгмийн тулгамдсан хэрэгцээ” үүссэн тохиолдолд шашнаа илчлэх энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулахыг зөвшөөрдөг. Гэхдээ энэхүү асуудал үүссэн тохиолдолд илүү нарийвчлан боловсруулсан хууль тогтоомж гаргах боломжтой. Ерөнхийдөө “хамгийн зохимжтой арга зам нь чухал бодлогыг зөрчөөгүй бол санхүүжилт босгохыг холбоодод зөвшөөрөх явдал юм.”<sup>77</sup> Жишээлбэл, Израил эсхүл Израил улсад байгаа еврейчүүд Монгол Улсад жүүдийн шашны мөргөлийн сүмийг сэргээн засварлах ажлыг олон улсын санхүүгийн шилжүүлэг хийх хуульд нийцүүлэн санхүүжүүлэхийг хориглох нь яагаад “ардчилсан нийгэмд зайлшгүй” шаардлагатай болохыг ойлгоход хэцүү юм. ЕАБХАБ-ын хэм хэмжээгээр шашны байгууллагууд нь олон улсын шашин нэгтгүүдэд харьяалагдаж, харилцаа холбоотой байх болон байгууллагын хандив хүсэх, хүлээн авах эрхийг хадгалах нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг.<sup>78</sup> Эдгээр эрхийн хүрээнд шашны байгууллага иргэн биш хүмүүсийг

---

<sup>75</sup> ЕАБХАБ/АИХЭА-ны Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний талаарх шинжээчдийн зөвлөхийн багаас Ардчилал тогтоох Европын хороо (Венецийн комисс)-той зөвлөлдөн гаргаж, Венецийн комиссоор батлуулан (2004 оны 6-р сарын 18-19, Венец) АИХЭА-ны парламентын чуулганаар (2004 оны 7-р сарын 5-9, Эдинбург) танилцуулсан Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг хэлэлцэх талаарх удирдамж, 20.

<sup>76</sup> Европын хүний эрхийн шүүх, *Нолан ба ОХУ-ын хэрэг №2512/04*-ийг харна үү, (2009 оны 2-р сарын 12).

<sup>77</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд оролцогч орнуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын баримт бичиг (1989 он)-ий 16.4 дэх зарчим (гишүүн орнууд шашны нийгэмлэгүүдийн “сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах” эрхийг хүндэтгэнэ)-ыг харна үү; НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 36/55 (1981 оны 11-р сарын 25-ны өдөр) тогтоолоор батлагдсан Шашин, шүтлэгээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай түнхаглалын 6(f) хэсэг (шашин шүтэх эрх чөлөөнд “хувь хүн болон байгууллагаас сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах эрх багтана.”).

<sup>78</sup> Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хуралд оролцогч улсуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын баримт бичиг (1989 он)-ийн 32-р догол; Европ дахь аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлын анхны акт (1975 он, Хельсинк хот), 1(d) бүлэг; Европын аюулгүй байдал,



тухайн улсын иргэдтэй адилаар ажилд авахыг зөвшөөрөх ёстой. Санхүүгийн асуудалд уян хатан хандаж, өөрийгөө засаглах эрхийг нь олгосноор шашны байгууллага бүх байнгын ажлын байрны талаарх мэдээллийг өөрсдийн дүрэмдээ тусгах шаардлагагүй болно.

Түүнчлэн, ЕАБХАБ-ын хэм хэмжээгээр үндэсний цөөнхийн “сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх боломжтой өөрийн боловсрол, соёл, шашны институт, байгууллага, холбоог байгуулж, үйл ажиллагаа явуулах” эрх болон “бусад улс дахь угсаатны эсхүл үндэсний гарал үүсэл, соёлын өв, шашны итгэл үнэмшил нэг иргэдтэй хил дамнан саад бэрхшээлгүй харилцаа холбоо тогтоох, тийнхүү харилцаа холбоотой байх” эрхийг баталгаажуулсан. Шашны бүлгүүдэд зориулан олон улсын санхүүгийн шилжүүлэг хийхийг хориглох нь шашны цөөнхийн байгууллага байгуулах болон гадаад улсын ижил итгэл үнэмшилтэй этгээдүүдтэй харилцаа холбоотой байх боломжид ихээхэн саад учруулна. Шашны бүлгүүдийг бусад бүлгүүдтэй ижил үндэслэлээр эх орон руугаа санхүүжилт авахыг зөвшөөрөх нь ардчилсан орнуудад өргөнөөр зөвшөөрөгдсөн практик юм. Зөвхөн шашны бүлгүүдэд зориулсан санхүүгийн шилжүүлгийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд зайлшгүй бус бөгөөд ялгаварлан гадуурхсан шинжтэй. Түүнчлэн 2013 оны 5-р сарын 31-ний өдөр батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-аар Монгол Улсаас бусад улсаас мөнгөн гүйлгээ хийхтэй холбоотой асуудлыг зохицуулдаг учир Хуулийн төсөлд эдгээр заалтуудыг оруулах шаардлагагүй. Банк болон бусад байгууллагууд 20 сая төгрөг (ойролцоогоор 7,307 ам.доллар), түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор Монгол Банканд мэдээлэх үүрэгтэй.<sup>79</sup>

Мөн шашны байгууллагын санхүүгийн бүтэц нь тухайн байгууллагын өөрийгөө засаглах эрх болон “бусадтай хамтран” шашнаа илчлэх эрхэд хамаарна.<sup>80</sup> Засгийн газар шашны байгууллагын дотоод бүтцэд нөлөөлөх аливаа оролдлого хийж болохгүй талаар Европын Хүний эрхийн шүүхээс удаа дараа анхааруулсан.<sup>81</sup> Хил дамнан болон бусад мөнгөн урсгал нь байгууллагын шатлан захирах эсхүл хурал цуглааны бүтцэд нөлөө үзүүлж болзошгүй бөгөөд байгууллагын итгэл үнэмшил,

---

хамтын ажиллагааны бага хуралд оролцогч орнуудын төлөөлөгчдийн Венийн уулзалтын баримт бичиг (1989 он)-ийн 16.4 дэх зарчим (гишүүн орнууд шашны нийгэмлэгийн “сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах” эрхийг хүндэтгэнэ); НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 36/55 (1981 оны 11-р сарын 25-ны өдөр) тогтоолоор батлагдсан Шашин, шүтлэгээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тунхаглалын 6(f) хэсэг (шашин шүтэх эрх чөлөөнд “хувь хүн болон байгууллагаас сайн дурын санхүүгийн болон бусад хандив хүсэх, хүлээн авах эрх багтана.”).

<sup>79</sup> *Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7.1-р зүйл.*

<sup>80</sup> Европын конвенцын 9-р зүйл.

<sup>81</sup> Европын хүний эрхийн шүүх, Сериф ба Грекийн хэрэг №38178/97 (1997 оны 12-р сарын 14); Европын хүний эрхийн шүүх, Хасан болон Чауш ба Болгарын хэрэг №30985/96 (2000 оны 10-р сарын 26); Европын хүний эрхийн шүүх, Бессараба ба Молдавын хэрэг №45701/99 (2001 оны 12-р сарын 13).

дотоод асуудлыг тусгадаг. Мөнгө угаах эсхүл террорист байгууллагыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудал нь бүх мөнгөн гүйлгээнд үйлчилдэг хууль тогтоомжоор шийдвэрлэх хэрэгтэй бөгөөд энд зөвхөн шашны бүлгүүдийг тусгайлан авч үзэж болохгүй.

Шашны бүлгүүд тайлангаа олон нийтэд ил хуваалцах шаардлагатай болсон нь бас нэгэн асуудал болж байна (Хуулийн төслийн 39.4, 43 дугаар зүйл). Төрөөс шашны байгууллагын татвар ногдох орлогын хэмжээг мэдэх, төрөөс олгосон санхүүжилтийг хэрхэн зарцуулсан талаарх тайлан хүлээн авах, эсхүл тухайн байгууллага үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж байгаа эсэхийг мэдэхийн тулд тайлан мэдээ тогтмол хүлээж авах хууль ёсны хэрэгцээ байдаг хэдий ч орлогоо нийтэд ил зарлахыг шаардах нь шашны байгууллагад тохиромжгүй хүндрэл үүсгэж, улмаар зөрчил, хулгай, эсхүл бусдын сүрдүүлэгт орох эрсдэл учруулж болзошгүй. Хуулийн төсөлд зөвхөн төрөөс санхүүждэг байгууллага тухайн санхүүжилтээ хэрхэн зарцуулсан талаарх тайлангаа өгдөг байхаар тусгаж, тодруулах хэрэгтэй.

### **Өөрийгөө засаглах эрх - Санал**

- Шашны байгууллага өөрийн нэрээ сонгох боломжийг нь хязгаарласан заалтыг 9 дүгээр зүйлээс хасах.
- Бизнесийн байгууллагын бүтцийн оронд шашны байгууллагын бүтцийн өөр өөр төрлийг зөвшөөрч, 16-22 дугаар зүйлд заасан бүртгэлтэй шашны байгууллагаас шаардах бүтцийг бүхэлд нь хялбарчлах.
- Гадаад улсын Засгийн газраас санхүүжилт авахыг хориглосон 27 дугаар зүйлийн 27.2.8 дахь хэсгийг хасах.
- Шашны байгууллагын санхүүжилтийг хязгаарласан 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсгийг хасах.
- Шашны байгууллага хандив тусламжийн мөнгийг хэдийд ашиглах талаар хязгаарлалт тавьсан 38 дугаар зүйлийн 38.5 дахь хэсгийг хасах.
- Шашны байгууллагыг санхүүгийн тайлангаа олон нийтэд ил байршуулахыг шаардсан 38.3, 39.4, 43 дугаар зүйлийг хасах.

## **Г. Хэт хяналт ба бүрхэг байдал**

### **1. 1993 оны хууль**

1993 оны Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд “хохирол учирч болох” нөхцөлд шашны үйл ажиллагааг зөвлөн зохицуулж, зогсоохыг зөвшөөрдөг. Үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөл үүссэн эсэхийг тогтоох тодорхойлолт эсхүл аливаа шалгуур

байхгүй. Удирдах албан тушаалтнууд аюул учирсан гэж төсөөлсөн эсхүл ямар ч аюул учраагүй нөхцөлд өөрийн бүрэн үзэмжээр шийдвэр гаргаж, улмаар шашны цуглаан, ёслол болон шашны бүлгийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авахад хүрэх нь санаа зовоосон асуудал мөн. Европын Хүний эрхийн шүүхийн стандартын дагуу шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохдоо төвийг сахисан, хөндлөнгийн байх зарчмыг баримталж,<sup>82</sup> дур зоргын хязгаарлалт тавихаас зайлсхийх ёстой.<sup>83</sup>

1993 оны Хуульд төр болон шашны байгууллагын ялгаатай түвшин дэх харилцаа ба Буддын болон Буддын бус шашны байгууллагуудын хоорондын харилцааны талаар тодорхой тусгаж өгөөгүй. 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт төрөөс “Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс” буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзэхийг зөвшөөрдөг боловч “энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй” гэж заасан. Тухайн улсын түүх, уламжлалд оролцоотой байсан шашныг төрөөс эрхэмлэн үзэх нь шашин эсхүл итгэл үнэмшлийн асуудлаарх олон улсын хэм хэмжээг зөрчихгүй бөгөөд энэ нь иргэдийн бусад шашин шүтэхэд саад болохгүй талаар 1993 оны Хуульд ухаалгаар дурдсан байна. Энэ заалтыг илүү тодорхой тусгаж өгсөн бол илүү үр нөлөөтэй байх байлаа. 1981 онд НҮБ-аас баталсан Шашин, итгэл үнэмшлээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тунхаглал<sup>84</sup> зэрэг олон улсын үүрэг амлалт, тунхаглалд бусдыг ялгаварлан гадуурхахгүй байхаар заасан бөгөөд үүнд нийцүүлэн 1993 оны хууль болон бусад нийтлэг хуулийн заалтуудад төрөөс шашин эсхүл итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхахыг илтэд хориглосон тухай зааж өгсөн бол дээрх заалт илүү тодорхой байх байсан. Төрөөс бүртгэл, визийн мэдүүлэг, газар ашиглалт болон бусад төртэй харилцах шаардлагатай асуудлаар ялгаварлан гадуурхах нь хууль бус болохыг тодруулж өгөх шаардлагатай. Энэхүү заалтаар хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй холбоотойгоор хувь хүн болон бүлгүүдийг үл ялгаварлан гадуурхах асуудлыг зохицуулсан хэрээр шашны байгууллагууд хүнийг шашин эсхүл итгэл үнэмшлээс нь хамаарч ажилд авах боломж олгох тусгай заалтыг эдгээр байгууллагад зориулан тусгах хэрэгтэй.

5 дугаар зүйлээр төр, сүм хийдийн харилцааг тодорхойлон хэрэгжүүлэх эрх үүргийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон үндэсний бөгөөд бүс нутгийн засаг захиргааны байгууллагуудад хуваарилсан байна. Улмаар шашны асуудлыг зохицуулахад илүү төвөгтэй болсон. Ихэнх улсын түршлагаар шашны байгууллагатай холбоотой харилцааг Засгийн газрын төв байгууллага эсхүл

<sup>82</sup> *Бессарабия ба Молдавын хэрэг* (ЕХЭШ, 2001 оны 12-р сарын 13, №45701/99) 116-р догол.

<sup>83</sup> *Бессарабия ба Молдавын хэрэг* (ЕХЭШ, 2001 оны 12-р сарын 13, №45701/99) 118-р догол; *Мануссакис, бусад этгээдүүд ба Грекийн хэрэг* 23 ЕХЭХ-ы тайлан 387 (1997) (ЕХЭШ, 1996 оны 9-р сарын 26) 43-53-р догол.

<sup>84</sup> 1981 оны тунхаглал, A/RES/36/55, 4-р зүйл.

хуулийн этгээдийн бүртгэлийг нийтэд нь хариуцсан Хууль зүйн яамны нэгж хариуцдаг.

Дээр дурдсанаар 7 дугаар зүйлд заасан хэд хэдэн хязгаарлалт хэтэрхий бүрхэг байгаагийн улмаар дур зоргоор, ялгаварлан гадуурхаж хэрэгжүүлэхэд хүргэж байна. Тухайлбал Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглосон заалт нь хууран мэхлэх, сэтгэл санаа үймүүлэхийг хязгаарласан заалтын нэгэн адил хэтэрхий бүрхэг байна.

## **2. Хуулийн төсөл**

Засгийн газарт хэт их хяналт тавих боломж олгосон нь энэ хуулийн төслийн томоохон дутагдлын нэг болж байна. Зөвлөлт холбоот улсын нөлөөт дэглэмийн үед төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн шашин, цаашлаад хувийн амьдралын асуудалд хүртэл хяналт тавьж байсан. Олон улсын хэм хэмжээ болон хууль дээдлэх ёсонд нэгдсэнээр төрөөс хүлээх үүрэг нь өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг ганцаарчлан болон хамтаараа эдлэхэд нь иргэдэд дэмжлэг үзүүлэх болж өөрчлөгдсөн. Экстремизм болон бусад гэмт хэргийн шинжтэй үйлдлийн улмаас үүссэн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхдээ итгэл үнэмшлийг бусдад түгээх болон бүлгүүд оршин тогтнох аргад зохицуулалт хийхээс илүү уламжлалт эрүүгийн хууль болон бусдад хор хохирол учруулах үйлдэл гаргахыг хориглосон хуулиар шийдвэрлэх нь хамгийн зөв арга юм.

Хуулийн төсөлд шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хангах энэ үүрэг амлалтыг хангаж, сайжруулах хэрэгтэй байна. Уг хуулийн төсөлд хэд хэдэн учир дутагдалтай зүйл бий. Уг баримт бичигт “хүмүүнлэг бус” болон “харгис” гэх мэт нэр томъёог удаа дараа ашигласан бөгөөд үүнийг өргөн хүрээнд тайлбарлах боломжтой. 2 дугаар бүлгийн төгсгөл хэсэг дэх тэмдэглэлд “харгис, хүмүүнлэг бус шашин”-ыг тодорхойлохыг оролдсон боловч тухайн хэсэгт авсан жишээ нь харгис бөгөөд хүмүүнлэг бус байдлын талаар бүрэн дүүрэн ойлголтыг гаргаж чадаагүй тул уг нэр томъёог илүү нягтлан тодруулах хэрэгтэй. Жишээ нь, “шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалах, номлох” эсхүл “бусад шашныг үгүйсгэх” гэдэг нь чухам юуг хэлж байгаа талаарх тайлбар алга. Шашингүй үзэлтэй байх эсхүл бусад шашинд харьяалагддаг байх нь хангалтгүй эсхүл цаг хугацаанаас гадуур үр дагаварт хүргэнэ гэж хэлэх нь “шашингүй үзлийг үл хүлээх зөвшөөрөх”-д тооцогдох уу? Тиймээс, холбогдох заалтуудыг хасах нь шилдэг түршлагад нийцнэ. 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт “Шашин шүтлэгийн ялгаа, шашин шүтэх, эс шүтэх байдлаас хамаарч бусдад давуу байдал олгох болон хязгаарлалт бий болгох, түүнчлэн аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах”-ыг хориглосон нь хэтэрхий бүрхэг байна.

“Хүмүүнлэг бус журам” гэх нэр томъёог ашигласан 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэг болон “харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлол” гэх нэр томъёог ашигласан 11 дүгээр зүйлийн 11.4.5 болон 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь хэсгүүдийг нэмж тодруулах эсхүл хасах шаардлагатай. Жишээ нь, амьтныг алж үйлддэг ёслолыг харгис үйлдэлд тооцох эсэх нь тодорхой бус байна. 27 дугаар зүйлийн 27.2.4 дэх хэсэгт аливаа этгээдийг шашны байгууллагад элсүүлэх зорилгоор “хүч” хэрэглэх тухай дурдсан боловч “хүч” гэх тодорхойлолт нь ойлгомжгүй байна. Үүний адилаар 27.2.6 дахь хэсэг дэх “шаардах” болон “албадах” гэх нэр томъёо мөн адил ойлгомжгүй. 27.2.10 дахь хэсэгт “...шашны номлол, үзэл баримтлалаар нь ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал тогтоох” гэж заажээ. Түүнчлэн “шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, хэт даврах болон салан тусгаарлахыг үхуулах, уриалах зэргээр үндэсний эв нэгдлийг бүснүүлэх үйл ажиллагаа явуулах” хэмээн заасан 27.2.13 дахь хэсгийг тодруулах шаардлагатай.

Одоо мөрдөгдөж буй хуулиудаар эдгээр асуудлыг аль хэдийн зохицуулсан бөгөөд эдгээр хүчин төгөлдөр хуулийг адил тэгшээр хэрэгжүүлэх нь нийтлэг түршлага мөн. Тухайлбал “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ын 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт үндэсний эв нэгдлийг бүснүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хуульд нийцээгүй бусад аргаар явуулах, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг түгээх, сурталчлах, хэрэглэхийг хориглосон байдаг.<sup>85</sup> Монгол Улсын Үндсэн хуулиар хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно гэж заасан тул Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.2.10 дахь хэсэгт ялгаварлан гадуурхах гэсэн хэллэг хэрэглэсэн заалт оруулах нь зайлшгүй биш юм.<sup>86</sup> Мөн Монгол Улсын Эрүүгийн хуулиар шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулсан бол дараах ял шийтгэнэ: Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор үршиг учруулахаар сүрдүүлж шашны байгууллагын үйл ажиллагаа, эсхүл шашны зан үйл үйлдэхэд саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах.<sup>87</sup> Мөн Эрүүгийн хуульд зааснаар Шашны байгууллага, шашны төлөөлөгч, номлол түгээгч өөрийн шашны

---

<sup>85</sup> Гэвч, энэ хууль нь ч ойлгомжгүй бөгөөд “хүмүүнлэг бус шашны сургаал, номлол”, “хүмүүнлэг бус шашин шүтлэг” гэх нэр томъёонууд нь бүрхэг байна.

<sup>86</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16.2-р зүйл.

<sup>87</sup> Эрүүгийн хуулийн 14.4.1-р зүйл.

үзэл номлолоо бусдад хүчээр тулгасан, шахалт үзүүлсэн, хууран мэхэлж татан оруулсан, эсхүл шашны харгис үзэл номлолыг сурталчилсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.<sup>88</sup>

Эдгээр бүрхэг нэр томъёонуудын нэлээд нь шашнууд хооронд хурцадмал байдал эсхүл санал зөрөлдөөн үүсгэх үг хэллэг, итгэл үнэмшилтэй холбоотой байна. Европын Хүний эрхийн шүүх “Шашны эсхүл аливаа бусад хамтлаг хуваагдсан тохиолдолд тэдгээрийн хооронд хурцадмал байдал үүсэж болзошгүй ч энэ нь ...олон ургалч үзлийн улмаас гарцаагүй үүсэх үр дагавар юм. Энэ тохиолдолд эрх бүхий байгууллага олон ургалч үзлийг үгүйсгэх замаар хурцадмал байдлыг үүсгэсэн шалтгааныг арилгах бус, харин хурцадмал харилцаанд орж буй бүлгүүд бие биеэ хүлцэн тэвчих нөхцөлийг бий болгох хэрэгтэй...”<sup>89</sup> гэсэн зарчмыг удаа дараа бататгасаар ирсэн.

Мөн НҮБ-ын Дээд комиссар нь Рабатын үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулахдаа дараах тайлбарыг өгсөн:

Хязгаарлалт тогтоохын цорын ганц гол зорилго нь итгэл үнэмшлийн тогтолцоо, шашин эсхүл институтийг шүүмжлэлд өртөхөөс нь хамгаалахаас илүүтэй шашны эсхүл түүнтэй адил шинж бүхий тодорхой итгэл үнэмшил, үзэл бодол бүхий үндэстний, угсаатны эсхүл шашны бүлгүүдэд харьяалагдах хувь хүн, хамтлагуудыг дайсагнал, ялгаварлан гадуурхалт эсхүл хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах тухай гэдгийг ойлгомжтой тайлбарлан гаргах ёстой. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хувь хүнийг эсхүл бүлэг хүмүүсийг хүчирхийлэх, дайсагнах эсхүл ялгаварлан гадуурхахад өдөөн түрхирсан үзэн ядалтыг дэмжээгүй л бол шашны болон бусад итгэл үнэмшлийн тогтолцоо, үзэл бодол болон институтын талаар сайтар судлах, нээлттэй маргах болон шүүмжлэх боломжтой байхыг шаарддаг.<sup>90</sup>

27 дугаар зүйлийн 27.2.3 дахь хэсэгт зааснаар “гишүүд, дагагч болон бусад этгээдийг өөрийн эрхээс татгалзуулж, шашны байгууллагад ашигтай байдал үүсгэхэд нь албадах”-ыг шашны байгууллагад хориглодог. Энэ хориглолт нь шашны байгууллагаас хуурамч шалтаг хэлж иргэдийг мөнгө эсхүл эд хөрөнгө шилжүүлэхийг ятгах замаар залилах үйлдлийг авч үзжээ. Дээр дурдсанчлан, сайн дурын үндсэн дээр өгсөн хандивыг хүлээн авсны төлөө шашны байгууллагыг яллахаас сэргийлэх үүднээс энэ төрлийн залиланг шашны холбогдолгүй бусад залилантай ижлээр авч үзэх хэрэгтэй.

<sup>88</sup> Эрүүгийн хуулийн 14.4.2-р зүйл.

<sup>89</sup> *Сериф ба Грекийн хэрэг*, Европын хүний эрхийн шүүх (ЕХЭШ), (№38178/97, 1999 оны 12-р сарын 14) (тодруулга нэмсэн).

<sup>90</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын Ээлжит тайлан: үндэс угсаа, арьсны өнгө эсхүл шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь үзэн ядахыг өдөөн түрхирахыг хориглох тухай шинжээчдийн судалгаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын гаргасан тайлан, A/HRC/22/17/Add.4 (11 Jan. 2013), 11-р догол.

Хуулийн төсөлд хэт бүрхэг стандартуудыг оруулж өгсөн нь шашны итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхах, шийдвэр гаргахдаа өөрийн үзэмжийг урвуулан ашиглах боломжийг нээж өгч байна. Энэ байдал нь 1981 оны НҮБ-ын Шашин, итгэл үнэмшлээр нь үл тэвчих, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай тунхаглалд “аливаа ялгаварлан гадуурхалтыг хориглоход зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийг батлах эсхүл цуцлах, болон шашин эсхүл бусад итгэл үнэмшлээр нь үл тэвчих байдалтай тэмцэхийн тулд зохих бүх арга хэмжээг авахаар хүчин чармайлт гаргах” хэмээн уриалсныг үл тоож байна.<sup>91</sup> Ардчиллыг хуулиар тогтоох Европын комисс (Венецийн комисс) болон ЕАБХАБ-ын шинжээчдийн зөвлөх багаас “Төрөөс хууль тогтоомж батлахаар хэлэлцэж буй олон асуудлууд дээр үнэн хэрэгтээ хууль тогтоомж батлан гаргах шаардлагагүй гэдгийг санах хэрэгтэй. Заримдаа шашны асуудлыг зохицуулах гэж тусгайлсан хууль тогтоомж өргөн барьдаг ч бодит байдал дээр ...эдгээр асуудлыг ердийн эрүүгийн эсхүл захиргааны аргаар шийдвэрлэх нь илүү үр дүнтэй” гэжээ.<sup>92</sup>

Хуулийг үзэмжээрээ хэрэгжүүлэх, шашны үйл ажиллагааг гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцохоос урьдчилан сэргийлэх үүднээс Хуулийн төсөл дэх бүрхэг нэр томъёонуудыг хасаж өөрчлөх хэрэгтэй. Олон улсын хэм хэмжээ болон хууль дээдлэх ёсны дагуу төрийн үүрэг нь өөрийн нутаг дэвсгэр дээр шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг дангаараа болон хамтаараа хэрэгжүүлэхийг дэмжих чиглэдэг. Хуулийн төсөлд энэ үүрэг амлалтыг тусгаж, шинэчлэн найруулах нь зүйтэй.

Нийтийн эзэмшлийн талбайд шашны болон шашны бус үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангах болон нийтийн хэв журам, аюулгүй байдалд заналхийлсэн үйлдэлтэй тэмцэх нь төрийн хууль ёсны үүрэг мөн. Гэсэн хэдий ч нийгэм дэх шашны болон шашны бус итгэл үнэмшлийн тэнцвэрийг олох эсхүл нийгмийн хувьд зохицолдоогүй гэж үзсэн тодорхой итгэл үнэмшлийг эсэргүүцэх нь төрийн үүрэг биш, харин хувь хүний тодорхой итгэл үнэмшлийг шүтэх, эс шүтэх орон зайг бий болгож, нийтийн хэв журам, аюулгүй байдалд заналхийлсэн үйлдэл (итгэл үнэмшил бус)-ийг эсэргүүцэх нь төрийн үүрэг мөн.

45 дугаар зүйлээр Хуулийн төсөлд заасан зөрчилд эрүүгийн болон бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр байна. Ямар үйлдлийг эрүүгийн гэмт хэрэг (амь нас, эрүүл мэндэд аюул учруулсан гэх мэт)-т тооцох, ямар үйлдлийг сайн дурын үйлдэл эсхүл захиргааны зөрчилд тооцохыг нарийн тодруулах шаардлагатай. ЕАБХАБ-ын удирдамжаар дараах тайлбарыг өгсөн:

Зарим улс оронд шашин болон итгэл үнэмшлийн үйл ажиллагаатай холбоотой хууль зөрчсөн тохиолдолд хүнд ял шийтгэл (их хэмжээний торгууль эсхүл хорих ял) оногдуулдаг. Захиргааны журмыг зөрчсөн

<sup>91</sup> 1981 оны тунхаглал, A/RES/36/55, 4-р зүйл.

<sup>92</sup> 2004 оны ЕАБХАБ-ын удирдамж, 8.

жижиг зөрчилд бага хэмжээний торгууль ногдуулах нь тохиромжтой боловч ердийн захиргааны алдаанд эрүүгийн хууль зөрчсөн мэтээр шийтгэх эсхүл захиргааны ял (punitive administrative penalty) ногдуулах нь тохиромжгүй юм. Тухайлбал, бүртгэлтэй холбоотой жижиг алдаанд хүнд ял шийтгэл оногдуулах нь эрүүгийн хуулийг урвуулан ашиглаж хүний шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрхийг зөрчсөн эсэх ноцтой асуудал үүсгэдэг. Уламжлалт эрүүгийн хуульд хамаарах үйл ажиллагаа (бусдын санаатай алах, бусдын бие махбодод гэмтэл учруулах, хулгайлах, дээрэмдэх зэрэг)-г үг хуулиар хориглож хүнд ял шийтгэл оногдуулах нь тохиромжтой боловч захиргааны журмыг зөрчсөн ердийн зөрчилд тийм хүнд ял шийтгэлийг ногдуулах нь хараахан тохиромжгүй юм. Жишээлбэл, лам санваартны бие махбодод гэмтэл учруулахыг хориглосон эсхүл гэмт хэргийн бүлэглэлийг нуун дарагдуулах зорилгоор шашны холбооны статусыг ашиглахыг хориглосон хууль батлах нь зүйтэй юм шиг санагдаж магадгүй. Гэвч, шашны холбоогоор бүртгүүлээгүй ердийн алдаанд эрүүгийн ял шийтгэл оногдуулах нь тохиромжгүй. Бүртгэл хийлгээгүй алдаанд эрүүгийн ял шийтгэл оногдуулж, бүртгэлтэй холбоотой төвөгтэй шаардлагуудыг төрийн зүгээс хуульчлах нь ноцтой хардлага төрүүлдэг.<sup>93</sup>

### **Бүрхэг байдал – Санал**

- 1993 оны Хууль болон бусад хуулийн нийтлэг заалтуудыг хэрэглэхдээ шашин эсхүл итгэл үнэмшлээр нь ялгаварлан гадуурхахыг төрд илтэд хориглохыг заасан 1993 оны Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тодорхой болгох. Төрийн зүгээс бүртгэл, визийн мэдүүлэг, газар ашиглалт болон бусад байдлаар төрийн байгууллагатай харилцахад ялгаварлан гадуурхах нь хууль бус гэдгийг тодорхой заах шаардлагатай.
- 1993 оны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг хасах шаардлагатай.
- Ямар байгууллага шашны асуудлыг хариуцан ажиллахыг тодорхой, энгийн болгох.
- Дараах хэт өргөн хүрээтэй, бүрхэг нэр томъёог хасах эсхүл тодруулах:
  - 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэг дэх “хүмүүнлэг бус журам”;
  - 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг дэх “Шашин шүтлэгийн ялгаа, шашин шүтэх, эс шүтэх байдлаас хамаарч бусдад давуу байдал олгох болон хязгаарлалт бий болгох, түүнчлэн аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах”-ыг хориглох;
  - 11 дүгээр зүйлийн 11.4.5, 12 дугаар зүйлийн 12.3.3 дахь хэсэг дэх “харгис, хүмүүнлэг бус шашны номлол, сургаал”;
  - 27 дугаар зүйлийн 27.2.4, 27.2.6 дахь хэсэг дэх “албадах,” “шаардах”;
- 27 дугаар зүйлийн 27.2.13 дахь хэсэг дэх “шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, хэт даврах болон салан тусгаарлахыг ухуулах,

---

<sup>93</sup> 2004 онд ЕАБХАБ-аас гаргасан Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг хэлэлцэх тухай удирдамж, 24-р хуудас.



уриалах зэргээр үндэсний эв нэгдлийг бусниулах үйл ажиллагаа явуулах” гэсэн заалтыг хасах эсхүл үүнд итгэл үнэмшлийн ялгааны улмаас үүссэн хурцадмал байдлыг багтаахгүй гэдгийг тодруулах;

- Ямар үйлдэл нь эрүүгийн гэмт хэрэг (амь нас, эрүүл мэндэд аюул учруулсан)-т тооцогдох, мөн ямар үйлдэл нь сайн дурын үйлдэл болох эсхүл захиргааны зөрчилд тооцогдох талаар 45 дугаар зүйлийг тодруулах.

## **О.Мөнхсайхан: Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө<sup>1</sup>**

Үндсэн хуулийн 16.15-д Монгол Улсын иргэн бүр “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй,” “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөөтэй гэжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын *18-р зүйлд заасныг дараах байдлаар орчуулжээ*: “Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.” ИБУТЭТОУП-ын *18.1-ийг* “Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөний зэрэгцээ ганцаар буюу бусадтай хамтран олон нийтэд буюу хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны болон зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэг номлох эрх чөлөө багтана” гэж орчуулжээ.

Шашин, итгэл үнэмшил нь өргөн хүрээтэй хамгаалагддаг: Пактын 18-р зүйл нь “теист, теист биш, атеист итгэл, аливаа шашин эсхүл итгэлийг эс шүтэх эрхийг хамгаалдаг” бөгөөд “уламжлалт шашин эсхүл институцлагдсан шашин, итгэл, уламжлалт итгэлтэй адил практикаар хязгаарлагдахгүй”<sup>2</sup> учраас аливаа шашин, итгэл үнэмшлийг шинээр бий болсон эсхүл цөөнхийн шүтдэг зэрэг ямар нэгэн шалтгаанаар ялгаварлан гадуурхаж болохгүй юм. Иймээс, шашин, итгэл үнэмшил нь нэг бурхантай, олон бурхантай, эсхүл бурхангүй эсхүл бурхныг үгүйсгэдэг байж болно. Мөн, агностисизм, пасифизм, атеизм, рационализм зэргийг чин үнэнчээр баримталж буй итгэл үнэмшил нь уламжлалт шашинтай адил төвшинд хүлээн зөвшөөрөгдөж хамгаалагдана.

Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нь дотоод болон гадаад талтай. Нэг талаас, хүний үхамсар, бодлын эрх чөлөө эсхүл шашин, итгэлтэй байх, түүнийг хүлээн авах, сонгох, татгалзах, өөрчлөх эрх чөлөө нь ямар нэгэн нөхцөлгүйгээр хамгаалагдах туйлын шинжтэй, дотоод эрх чөлөө бөгөөд онц

---

<sup>1</sup> МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхан дараах номд энэ сэдвээр бүлэг бичсэнийг энэхүү эмхэтгэлд оруулав: О.Мөнхсайхан, Р.Очирбал, *Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл (тойм судалгаа)* (УБ, 2021), 130-142.

<sup>2</sup> CCPR General Comment No. 22, §2.

байдал зарласан үед ч хязгаарлаж болохгүй (ИУБУТЭТОУП-ын 4.2). Жишээлбэл, ямар шашин, итгэл дагадаг эсхүл ямар бодолтой гэдгээ илчлэхэд хэнийг ч албадаж болохгүй.<sup>3</sup> Нөгөө талаас, шашин, итгэлээ номлох (илэрхийлэх, илчлэх) нь гадаад эрх чөлөө бөгөөд онцгой нөхцөлд зохих ёсоор хязгаарлагдах боломжтой. Номлох гэдэг нь хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэрэг олон янзын хэлбэртэй байж болно. Шашин, итгэлээ номлох эрх чөлөөгөө хүн дангаараа эсхүл бусадтай хамтран, мөн нийтийн өмнө болон хувийн журмаар хэрэгжүүлж болно.

ИБУТЭТОУП-ын 18.3-т “Freedom to manifest one's religion or beliefs may be subject only to such limitations as are prescribed by law and are necessary to protect public safety, order, health, or morals or the fundamental rights and freedoms of others” гэж заасныг Монгол хэлээр “Шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөөг зөвхөн хуулиар тогтоосон болон нийгмийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах [зайлшгүй] шаардлагын үүднээс хязгаарлаж болно” гэж орчуулжээ. Энэхүү Монгол орчуулга нь уг заалтын агуулгаа бүрэн илэрхийлж чадахгүйн дээр “зайлшгүй” нэн чухал үг орхигджээ. Өөрөөр хэлбэл, ИБУТЭТОУП-ын 18.3-т заасны дагуу шашин, итгэлээ номлох эрх чөлөөг хязгаарлахад наад зах нь дараах дөрвөн шаардлагыг хангасан байх ёстой: хязгаарлалт нь (1) хуулиар тогтоосон байх; (2) нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх; (3) энэ зорилгод хүрэхэд зайлшгүй байх шаардлагатай. (4) “Хязгаарлалтыг ялгаварлан гадуурхах зорилгоор тогтоож эсхүл ялгаварлан гадуурхах зорилгоор хэрэгжүүлж болохгүй.”<sup>4</sup> Эдгээр шаардлагын аль нэгийг хангаагүй хязгаарлалт нь тухайн эрхийн зөрчил болно гэсэн үг. Мөн, шашин, итгэлийг номлохдоо “дайныг аливаа хэлбэрээр сурталчлах,” “алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа үхүүлгэ сурталчилгаа” явуулахыг хуулиар хориглох үүрэгтэй (ИБУТЭТОУП-ын 20.1, 20.2).

Монгол Улсын Үндсэн хуулиар шашин, итгэл үнэмшилтэй байх, түүнийгээ хүлээн авах, өөрчлөх нь туйлын эрх ч шашин, итгэл үнэмшлээ номлох нь онцгой нөхцөлд зохих ёсоор хязгаарлагдах боломжтой. Үндсэн хуулиар хамгаалсан туйлын эрхээс бусад эрхийг хязгаарлахад наад зах нь дараах зургаан нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хууль тавьдаг: (1) хүний эрхэд тавьж буй аливаа хязгаарлалтыг хуульд тодорхой заах; (2) хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой; (3) хязгаарлалт нь эдгээр зорилгын нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон байх; (4) үндсэн эрхийг аль болох эдлүүлэх; (5) ялгаварлан

---

<sup>3</sup> CCPR General Comment No. 22, §3.

<sup>4</sup> CCPR General Comment No. 22, §8.

гадуурхахгүй байх, туйлын эрхийг зөрчөөгүй байх; (б) хараат бус шүүхээр хянагддаг байх.<sup>5</sup> Иймд, шашин, итгэл үнэмшлээ номлох эрх чөлөөнд тавих аливаа хязгаарлалт нь эдгээр зургаан нөхцөлийн аль нэгийг хангаагүй бол уул эрхийн зөрчил болно.

Монгол Улсад төр, сүм хийдийн харилцаанд баримтлах зарчмыг Үндсэн хуулиар тогтоож өгсөн. Үндсэн хуулийн 9.1-д “Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ,” 9.2-т “Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй,” 9.3-т “Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна” гэж тусгайлан заасан. Мөн, төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулахдаа Үндсэн хуулийн 16.15, 16.6-д хүлээн зөвшөөрсөн “шашин шүтэх, эс шүтэх,” “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөө, Үндсэн хуулийн 1.2-т “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх” зарчмыг хүндэтгэх үүрэгтэй. Жишээлбэл, төр аливаа шашны маргаанд аль нэг талд тал засах, тодорхой шашны байгууллага эсхүл түүний удирдагчийн талд орох, шашны байгууллагыг бүртгэхэд хэлбэрийн бус агуулгын шаардлага тавих зэрэг нь төвийг сахиагүй хэрэг тул тэгш байдлыг зөрчинө.<sup>6</sup> Мөн, шашин хоорондын аливаа ялгаа нь зүй ёсны объектив хүчин зүйл, үндэслэлээр зөвтгөгдөх бөгөөд ялгаварласан хандлага гаргахгүй байх шаардлагатай.<sup>7</sup> Учир нь, Үндсэн хуулийн 14.1-д “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна,” “Хүнийг... шашин шүтлэг[ээр] нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заасан тул төрөөс шашин эсхүл итгэл үнэмшлийн эрх чөлөөг ямар ч ялгаварлан гадуурхалгүйгээр эдлүүлэх ёстой.

ИБУТЭТОУП-ын 18.2-т “Хэний ч өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөг хязгаарлахаар албадан шахах ёсгүй” гэж заасан. Жишээлбэл, шашин эсхүл итгэлээ өөрчлөхийг зүй бусаар ятгах, өөрчлөхөд нь зүй бусаар саад хийх нь уг заалтаар хориотой. Мөн, ИБУТЭТОУП-ын 18.4-т “Энэхүү Пактад оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхдэдээ хувийн үзэл итгэлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ” гэжээ. Хүүхдийн шашны болон ёс суртахууны хүмүүжлийн асуудлыг зохицуулахад хүүхдийн бие даасан байдал, эцэг эхийн эрх, хүүхдийн ашиг сонирхлыг зохистой хангах нь чухал. Хүүхдийн шашин болон ёс суртахууны асуудал дээр эцэг эх оролцох эрхтэй боловч уг эрх нь хүүхдийн бие даасан байдлыг хүндэтгэж хүүхдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой. Хүүхэд нас биед хүрэхийн хэрээр шашны болон ёс суртахууны асуудалд бие даан шийдвэр гаргах зарчим жин дарвал зохилтой.

---

<sup>5</sup> О.Мөнхсайхан, “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт,” *Ардчиллын хөгжил – иргэний оролцоо Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл* дотор (2017), 91-108.

<sup>6</sup> *Guidelines For Review of Legislation Pertaining to Religion or Belief* (OSCE, ODIHR, 2004), 11.

<sup>7</sup> Мөн тэнд, 10.

Олон шашныг зэрэгцэн оршихыг хүлээн зөвшөөрөх нь Монголын төрт ёсны уламжлал юм. Жишээлбэл, Их засаг хуульд “Аливаа шашин суртахууныг хүндэтгэмүй. Гэвч ямар нэг шашин ч онц эрхийг эдэлж үл болно” гэж тунхагласан талаар Монголчууд бичиж ирсэн.<sup>8</sup> “Чингис хаан хүн бүрд шашин шүтэх эрх чөлөөг бүрэн, цогцоор зарлигдсан нь дэлхий дээрх энэ төрлийн анхны хууль байх магадлалтай” бөгөөд “Бүх шашныг хөхиүлэн дэмжихийн тулд Чингис хаан шашны удирдагч нар болон тэдгээрийн өмч хөрөнгийг татвар, нийтийн үйлчилгээний бүх хэлбэрээс чөлөөлж байсан.”<sup>9</sup> Социализмын үед Монголд шашин шүтэх эрх чөлөөг эдлэх боломжгүй байсан.

1992 оны Үндсэн хуулиар итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаажуулсан нь олон янзын шашин, итгэлтэй хүмүүс энх тайвнаар зэрэгцэх орших урьдач нөхцөл болсон. Монгол Улсад 2010 оны тооллогоор 15, түүнээс дээш насны хүн амын 61.4 хувь нь шашин шүтдэг, 38.6 хувь нь шүтдэггүй гэсэн бол 2020 оны тооллогоор хүн амын 59.4 хувь нь шашин шүтдэг, 40.6 хувь нь шүтдэггүй гэжээ.<sup>10</sup> 15, түүнээс дээш насны хүн амын хувьд 2010 оны тооллогоор 53 хувь нь Будда, 3 хувь нь Ислам, 2.9 хувь нь Бөө, 2.1 хувь нь Христийн шашин шүтдэг гэсэн бол 2020 оны тооллогоор 51.8 хувь нь Будда, 3.2 хувь нь Ислам, 2.5 хувь нь Бөө, 1.3 хувь нь Христ, 0.6 хувь нь бусад шашин шүтдэг гэжээ.<sup>11</sup>

Монгол Улсад хувь хүмүүс шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг эдэлдэг. Будда, мусульман, христ, бөө зэрэг шашны удирдагчид “шашин чөлөөтэй шүтэхэд хүндрэл байхгүй” гэж мэдээлсэн бөгөөд “тэдний хэлж буйгаар Монгол Улсын ихэнх иргэд шашны ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, өөр өөр шашны итгэгчид эв найртай амьдардаг.”<sup>12</sup> 2021 онд Фрийдом хаус байгууллагаас Монгол Улсыг “хувь хүмүүс нийтийн эсхүл хувийн хүрээнд шашин шүтэж эсхүл эс шүтэж түүнийгээ илэрхийлэх, хэрэгжүүлэх эрх чөлөөтэй юү” гэсэн асуултад 4 онооноос 4-ийг өгч дараах дүгнэлтийг хийжээ: “хэдийгээр шашны бүлгүүд засгийн газарт бүртгүүлэх шаардлагатай бөгөөд бүртгэх процедурын хялбар байдал нь орон нутаг бүрд харилцан адилгүй боловч хувь хүмүүс хууль зүйн хувьд болон бодит байдалд шашин шүтэхэд чөлөөтэй.”<sup>13</sup>

<sup>8</sup> Сайшаал, *Чингис хааны товчоон*, Дэд дэвтэр (УБ, 2004), 405; Баабар, *Монголчууд: нүүдэл суудал*, 1 дүгээр дэвтэр (УБ, 2006), 61.

<sup>9</sup> Jack Weatherford, *Genghis Khan and the Making of the Modern World* (Three Rivers Press, 2004), 69.

<sup>10</sup> Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, *Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого: нэгдсэн дүн* (2020), 61.

<sup>11</sup> АНУ-ын Элчин сайдын яам, “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан – Монгол Улс 2019,” <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-international-religious-freedom-report-mn/>; “Хүн ам,” Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, <https://www.1212.mn/haos/haoscount.aspx>

<sup>12</sup> АНУ-ын Элчин сайдын яам, “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан – Монгол Улс 2019,” <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-international-religious-freedom-report-mn/>

<sup>13</sup> “Freedom in the World 2021: Mongolia,” Freedom House, <https://freedomhouse.org/country/mongolia/freedom-world/2021>

Итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудлыг тоймлон хүргэе.

	<b>Тулгамдсан асуудал</b>	<b>Зөвлөмж</b>
1.	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар шашны байгууллагууд төрийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Монгол Улсад сүм, хийдийг бүртгэх нэгдсэн зохицуулалтгүй тул өөрөөр бүртгэл явагдаж, тодорхойгүй байдал, үзэмжээрээ хандах эрсдэл үүсгэдэг. “[Бүртгүүлэхэд] шаардагдах бичиг баримтыг дэлгэрэнгүй хуульчилсан ч хэрэгжилттэй холбоотой нарийвчилсан журмыг орон нутгийн эрх баригчдын мэдэлд үлдээсэн. ...Аймгуудын бүртгэлийн журам харилцан адилгүй байх, бүртгэлийн үйл ажиллагаа тодорхойгүй байх, ажилтнууд нь ойр ойрхон солигдох, эсвэл шашны бүлгийн салбар бүрийг тусад нь бүртгүүлэх шаардлага зэргээс болж бүртгүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй тулгарч буй талаар зарим шашны бүлэг мэдээлсэн.” <sup>14</sup> Сүм, хийдийг хуулийн этгээдээр бүртгэхэд зүй бус хязгаарлалт тавих нь эвлэлдэн нэгдэх эрх болон шашин шүтэх эрх чөлөөнд нийцэхгүй бөгөөд бүртгэхэд хэт урт цаг алддаг, хүнд сурталтай эсхүл үзэмжээрээ шийдвэрлэхийг зөвшөөрөх нь зүй бус хязгаарлалтад тооцогддог. <sup>15</sup>	НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл: “Шашин шүтэх, эс шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, үүнд хууль, эрх зүйн зохицуулалтын орчныг бүрдүүлж шашны бүлэг, байгууллагуудад чөлөөтэй бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах боломжийг олгох (АНУ).” <sup>16</sup>
2.	Монгол Улсад “Иргэний боловсрол,” “Иргэний ёс зүйн боловсрол” гэсэн заавал үзэх хичээлийн хөтөлбөр, сурах бичигт нисваанисыг тэвчих ёс,	“Иргэний боловсрол,” “Иргэний ёс зүйн боловсрол” зэрэг хичээлийн хөтөлбөр,

<sup>14</sup> АНУ-ын Элчин сайдын яам, “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан – Монгол Улс 2019,” <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2019-international-religious-freedom-report-mn/>

<sup>15</sup> *Guidelines For Review of Legislation Pertaining to Religion or Belief* (OSCE, ODIHR, 2004), 13, 17.

<sup>16</sup> “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн ажлын хэсгийн 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр бусад улсаас өгсөн зөвлөмж” (2020), §78.

<p>сэтгэлийн ариусгах зан үйл, их таван ухаан, бага таван ухаан,<sup>17</sup> шүтэн барилдлага, ивээл, харш жил, жил орох ёс,<sup>18</sup> арга билэг,<sup>19</sup> үйлийн үр<sup>20</sup> гэх мэтээр Буддын шашны номлолыг туйлын үнэн мэт сурагчдад зааж сургаж буй нь хэт нэг талыг барьсан, ялгаварлан гадуурхсан шинжтэй байна. Ерөнхий боловсролын сургуульд Буддын шашныг зааж буй нь ИБУТЭТОУП-ын 18.4-р зүйлийн “Энэхүү Пактад оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхдэдээ хувийн үзэл итгэлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ” гэсэн заалтад нийцэхгүй байна. Учир нь, НҮБ-ын Хүний эрхийн хорооныхоор “хэрэв нийтийн сургууль нь шашны болон ёс зүйн ерөнхий онол зэрэг сэдвийг төвийг сахисан, объектив байдлаар сургаж буй бол Пактын 18.4-р зүйлээр зөвшөөрөгддөг,” харин “Тодорхой шашин эсхүл итгэлийг сургадаг нийтийн боловсрол нь эцэг эхийн хүсэлтийг хангахуйц, ялгаварлан гадуурхаагүй өөр хувилбарыг санал болгоогүй бол 18.4-р зүйлд нийцэхгүй.” Мөн, ерөнхий боловсролын сургуульд зөвхөн нэг шашны сургаалыг номлож буй нь Үндсэн хуулийн 9.2-т “Төрийн байгууллага шашны ... үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй,” 16.15, 16.6-д Монгол Улсын иргэн бүр “шашин шүтэх, эс шүтэх,” “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөөтэй, 14.1-т хүн бүр “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна,” 14.2-т “Хүнийг ...шашин шүтлэг ...оор нь ялгаварлан гадуурхаж үл болно,” 1.2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх</p>	<p>сурах бичгийн агуулгад шашны сэдвийг хөндвөл аль нэг шашны номлолыг туйлын үнэн мэтээр сургах бус, харин өөр өөр шашны уламжлалуудыг төвийг сахисан, объектив байдлаар танилцуулж сургалтаар заахаар хуульчлах.</p> <p>Ерөнхий боловсролын сургуульд зааж буй хичээлийн агуулга нь эцэг эхийн шашны итгэл үнэмшилтэй ноцтой зөрчилдвөл (гэвч, фашизм зэрэг хэт туйлширсан үзэл суртлын эсрэг агуулгыг хичээлээр орохыг төрд зөвшөөрдөг) уг хичээлд суухаас татгалзаж өөр байдлаар хичээлээ тооцуулах эрхийг сурагч, эцэг эхэд эдлүүлэх.<sup>21</sup></p>
--	---

<sup>17</sup> *Иргэний боловсрол XI* (БШУЯ, 2014), 66-74, 92-103.

<sup>18</sup> *Иргэний ёс зүйн боловсрол XI* (БШУЯ, 2020), 110-126, 135-141.

<sup>19</sup> *Иргэний ёс зүйн боловсрол X* (БШУЯ, 2020), 5-41.

<sup>20</sup> *Иргэний ёс зүйн боловсрол VII* (БШУЯ, 2020), 75-106.

<sup>21</sup> *Guidelines For Review of Legislation Pertaining to Religion or Belief* (OSCE, ODIHR, 2004), 14.

	<p>чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж тус тус заасантай нийцэж буй эсэх эргэлзээтэй.</p>	
<p>3.</p>	<p>ХЗДХЯ-аас Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн болон дагалдах хуулиудын төслийг вэбсайт дээрээ нийтэлж олон нийтээс санал авсан бөгөөд уг төслийн агуулгаар нээлттэй хэлэлцүүлгийг 2018.10.26-д зохион байгуулсан. Энэ төсөл нь төр, сүм хийдийн харилцаа, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний эрх зүйн орчин сайжруулахад чиглэсэн боловч хэд хэдэн асуудал байгаагаас жишээ болгон зургааг нь товч танилцуулъя.</p> <p>Нэгд, Эрүүгийн хуулийн 14.4-р зүйлийн 3 дахь хэсэгт “Шашны байгууллагын үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн, эсхүл шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг зөвшөөрөлгүй байгуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заахаар дагалдах хуулийн төсөлд тусгасан нь хэт хүнд шийтгэлтэй байх тул Үндсэн хуулийн 1.2-т заасан шударга ёсны зарчим (зөрчлийн шинж чанарт ял шийтгэл тохирсон байх)-ыг хангахгүй, улмаар Үндсэн хуулийн 16.10-т заасан “эвлэлдэн нэгдэх эрх,” 16.15-д буй “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө,” 16.16-д буй “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөөг тус тус зөрчсөн шинжтэй байна. Шашны байгууллагыг зөвхөн бүртгүүлээгүйн төлөө эрүүгийн ялаар шийтгэх нь зохисгүй төдийгүй бүртгүүлэлгүй үйл ажиллагаа явуулж буй</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулиар шашин, итгэлтэй байх, түүнийгээ хүлээн авах, өөрчлөх нь туйлын эрх ч шашин, итгэлээ номлох нь онцгой нөхцөлд зохих ёсоор хязгаарлагдах боломжтой. Туйлын эрхээс бусад эрхийг хязгаарлахад наад зах нь дараах зургаан нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хууль тавьдаг: (1) хүний эрхэд тавьж буй аливаа хязгаарлалтыг хуульд тодорхой заах; (2) хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой; (3) хязгаарлалт нь эдгээр зорилгын аль нэгэнд хүрэхэд зайлшгүй, тохирсон байх; (4) үндсэн эрхийг аль болох эдлүүлэх; (5) ялгаварлан гадуурхахгүй байх, туйлын эрхийг зөрчөөгүй байх; (6) хараат бус шүүхээр хянагддаг байх.<sup>24</sup> Гэтэл, Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн болон дагалдах</p>

<sup>24</sup> О.Мөнхсайхан, “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт,” *Ардчиллын хөгжил – иргэний оролцоо Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл* дотор (2017), 91-108.



<p>шашны бүлэгт шийтгэл, хязгаарлалт оногдуулж болохгүй.<sup>22</sup></p> <p>Хоёрт, дагалдах хуулийн төслөөр Эрүүгийн хуулийн 14.4-р зүйлийн 4, 5 дахь хэсэгт дараах заалт тусгахаар байна.</p> <p>4.Шашны байгууллага:</p> <p>4.1.улс төрийн нам болон улс төрийн хөдөлгөөний үйл ажиллагаанд оролцсон, улс төрийн үйл ажиллагаанд эд материалын болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлсэн;</p> <p>4.2.шашны нэр хүнд, хүн амын сүсэг бишрэлийг ашиг олох болон улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хангах зорилгод нийцүүлэн ашигласан;</p> <p>4.3.зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрээс гадна үйл ажиллагаа явуулсан;</p> <p>4.4.зөвшөөрөлгүйгээр дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл нэр, байршлаа өөрчилсөн;</p> <p>4.5.гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянга дөрвөн зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.</p> <p>5.Шашны номлол түгээгч, шашны бүлэг энэ зүйлийн 4.1, 4.2-т заасан үйл ажиллагаа явуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>“Тайлбар: - Энэ хуульд заасан “харгис, хүмүүнлэг бус шашин” гэж гэж дайн, террорист үйл ажиллагаа, хэт даврах буюу экстремист үйл ажиллагаа, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис</p>	<p>хуулиудын төслийн олон заалт нь эдгээр шаардлагыг хангахгүй байх тул эдгээрт нийцүүлэх нь зүйтэй. Жишээлбэл, Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 7.3, 7.8, 9.4, 11.4.5, 27.2.14, 40 болон бусад заалтууд,<sup>25</sup> уг хуулийн төслийг дагалдаж Эрүүгийн хуулийн 14.4 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5 дахь хэсэг болон Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1-т нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Үндсэн хуульд нийцүүлэх хэрэгтэй.</p>
---	---

<sup>22</sup> Мөн тэнд, 12, 24.

<sup>25</sup> Дээрхээс гадна Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 6.2.2, 6.2.7, 6.4, 8.8, 12.3.2, 12.3.3, 26.1.2, 27.2, 29.4, 30.4, 31.4, 33.4, 37.1.5, 37.1.6 зэрэг заалт нь үндсэн эрхийг хязгаарлахад тавигддаг нөхцөлд бүрэн нийцүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, ялгаварлан гадуурхах, хүний амь нас, эрүүл мэндийг хохироох зэрэг хууль зөрсөн хэлбэрээр зан үйл, ёслол үйлддэг, бусад шашныг үгүйсгэх, шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалдаг, номлодог шашны урсгал, чиглэлийг ойлгоно.”

Төслийн дагуу Эрүүгийн хуулийн 14.4-р зүйлийн 4 дэх хэсэгт 4.1-4.5-т заасан үйл ажиллагааг шашны байгууллага, шашны номлогч, шашны бүлэгт хориглох нь Үндсэн хуулийн 19.3-т буй үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн зорилго (ИБУТЭТОУП-ын 18.3-т буй нийтийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх)-ын алинд хүрэхэд чиглэсэн эсэх ойлгомжгүй, аль нэг зорилгыг нь агуулж байлаа гэхэд түүнд хүрэхэд үнэхээр зайлшгүй эсэх нь эргэлзээтэй байна.

Гуравт, Шашин шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 27.2.14-т “харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх”-ийг шашны байгууллагад хориглохоор заасан байх бөгөөд “харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг түгээн дэлгэрүүлэхээр бол” шашны байгууллагыг бүртгүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзах (Шашин шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 11.4.5), ял шийтгэл хүлээлгэх (Эрүүгийн хуулийн 14.4-р зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төсөл)-ээр бичжээ. Эдгээр зохицуулалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журмыг хамгаалах зорилготой байж болох ч “харгис, хүмүүнлэг бус” гэдгийн агуулга тодорхойгүй, хэт ерөнхий учраас тухайн зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон эсэх эргэлзээтэй. Шашин шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 27-

<p>р зүйлийн тайлбарт “харгис, хүмүүнлэг бус шашин” гэж “дайн, террорист үйл ажиллагаа, хэт даврах буюу экстремист үйл ажиллагаа, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, ялгаварлан гадуурхах, хүний амь нас, эрүүл мэндийг хохироох зэрэг хууль зөрсөн хэлбэрээр зан үйл, ёслол үйлддэг, бусад шашныг үгүйсгэх, шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалдаг, номлодог шашны урсгал, чиглэлийг ойлгоно,” Эрүүгийн хуулийн 14.4-р зүйлийн Тайлбарт “Энэ хуульд заасан “харгис, хүмүүнлэг бус шашин” гэж гэж дайн, террорист үйл ажиллагаа, хэт даврах буюу экстремист үйл ажиллагаа, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, ялгаварлан гадуурхах, хүний амь нас, эрүүл мэндийг хохироох зэрэг хууль зөрсөн хэлбэрээр зан үйл, ёслол үйлддэг, бусад шашныг үгүйсгэх, шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалдаг, номлодог шашны урсгал, чиглэлийг ойлгоно” гэж тус тус заажээ. Эдгээр тодорхойлолт дахь “бусад шашныг үгүйсгэх, шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалдаг, номлодог шашны урсгал, чиглэл” гэдэг нь хэт тодорхойгүй, үзэмжээрээ тайлбарлах, улмаар урвуулан ашиглах эрсдэлтэй байна. “Шашин эсхүл итгэлээ номлох эрх нь тодорхой итгэл үнэмшлийг шүүмжлэлээс хамгаална гэсэн утгагүй” бөгөөд иргэд нь “бусдаас өөрсдийнх нь шашны итгэлийг үгүйсгэх, бүр итгэл үнэмшилд нь дайсагнасан номлолыг дэлгэрүүлэх явдлыг хүлцэх, хүлээн зөвшөөрөх ёстой.”<sup>23</sup></p> <p>Дөрөвт, Шашин шүтэх эрх чөлөөний тухай</p>	
--	--

<sup>23</sup> Nihal Jayawickrama, *The Judicial Application of Human Rights Law: National, Regional and International Jurisprudence*, 1st ed. (Cambridge University Press, 2003), 650-651.

<p>хуулийн 9.4-т “Сүм, хийд, дацан, төв зэрэг тодотголыг шашны байгууллагын оноосон нэрэндээ хэрэглэж болох бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс хойш 50-аас багагүй жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа төвлөрсөн шашны байгууллага нэрэндээ МОНГОЛ, МОНГОЛЫН, ҮНДЭСНИЙ, НИЙТИЙН, НЭГДСЭН гэсэн үг болон эдгээр үгнээс үүссэн бусад нийтийг төлөөлсөн утга бүхий үг ашиглах эрхтэй” гэсэн нь Үндсэн хуулийн 19.3-т заасан ямар зорилгод үйлчилж буй нь ойлгомжгүй, зайлшгүй эсэх эргэлзээтэй, хэр хэмжээнээс хэтэрсэн, шашны дотоод хэрэгт оролцсон, шинээр үүссэн эсхүл цөөнхийн шүтдэг шашныг ялгаварлан гадуурхсан шинжтэй байна.</p> <p>Тавд, Шашин шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 40 дүгээр зүйлд зааснаар Шашны асуудал эрхэлсэн зөвлөл нь шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг цуцлах, шашин хоорондын харилцааг зохицуулах гэх мэт өргөн бүрэн эрхтэй ч түүний бүрэлдэхүүний дийлэнх олонх нь төрийн байгууллын төлөөлөл бөгөөд тэнцвэргүй байх тул төвийг сахиж хараат бусаар ажиллах эсэх дээр эргэлзээ үүсгэж байна.</p> <p>Зургаад, Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 7.1-д “Иргэд шашин шүтэх эрхээ хамтран хэрэгжүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг шашны бүлэг гэнэ,” 7.2-д “Шашны бүлгийн гишүүн нь Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн байж болно” гэж</p>	
--	--

<p>тодорхойлжээ. Мөн, энэ төслийн 7.3-д “Шашны бүлгийн үйл ажиллагаа явуулах байр, эд хөрөнгө нь зөвхөн гишүүдээс олгогдсон байх бөгөөд бусад этгээдээс хандив, дэмжлэг, тусламж авахыг хориглоно” гэж заахын зэрэгцээ Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 15.2-р зүйлийн 1-д “Шашны бүлэг нь гишүүн бус этгээдээс хандив, санхүүгийн дэмжлэг авсан... бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” хэмээн заажээ. Түүнчлэн, Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 7.8-д “Шашны бүлэг нь шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны болон шашны ёс зүйн талаар сургалтыг зөвхөн бүлгийн гишүүдийг оролцуулан зохион байгуулах эрхтэй” гэж заахын зэрэгцээ Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 15.2-р зүйлийн 1-д “Шашны бүлэг нь ...олон нийтэд шашин түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” хэмээн бичжээ. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн 7.3, 7.8 болон Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 15.2-р зүйлийн 1 дэх заалтууд нь Үндсэн хуулийн 19.2-т заасан аль зорилгод үйлчилж буй эсэх ойлгомжгүй, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг зохих үндэслэлгүйгээр хэт хумьсан байх тул Үндсэн хуулийн 16.15, 16.16-д “шашин шүтэх, эс шүтэх,” “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөөтэй гэсэн заалтыг зөрчсөн шинжтэй байна.</p>	
--	--

# Хавсралт

## Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)<sup>26</sup>

### 2 дугаар зүйл

Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.

### 18 дугаар зүйл

Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.

---

<sup>26</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалжээ. <https://legalinfo.mn/mn/detail/1271>

# Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)<sup>1</sup>

## 2 дугаар зүйл

1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.

## 4 дүгээр зүйл

1. Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь олон улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.

2. Энэ заалт нь 6, 7, 8, /1, 2 дахь хэсэг/, 11, 15, 16, 18 дугаар зүйлээс ямар нэгэн байдлаар ухрах үндэслэл болохгүй.

3. Ухрах эрхээ хэрэгжүүлж буй, энэхүү Пактад оролцогч аливаа улс ухарч байгаа заалт болон ухрах болсон шалтгааны талаар уг Пактад оролцогч бусад улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан даруй мэдэгдэх ёстой. Түүнчлэн ухарсан үүргээ сэргээсэн хугацааг мөнхүү зуучлагчаар уламжлан мэдэгдсэн байх ёстой

## 18 дугаар зүйл

1. Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөний зэрэгцээ ганцаар буюу бусадтай хамтран олон нийтэд буюу хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны болон зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэг номлох эрх чөлөө багтана.

2. Хэний ч өөрийн сонгосон шашин буюу шүтлэгтэй байх эсхүл тийм шашин буюу шүтлэгтэй болох эрх чөлөөг хязгаарлахаар албадан шахах ёсгүй.

3. Шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөөг зөвхөн хуулиар тогтоосон болон нийгмийн аюулгүй байдал, хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын

---

<sup>1</sup> Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон, <https://legalinfo.mn/mn/detail/1257>

4. Энэхүү Пактад оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхэддээ хувийн үзэл итгэлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ.

## **20 дугаар зүйл**

1. Дайныг аливаа хэлбэрээр сурталчлахыг хуулиар хориглоно.
2. Алагчилан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн түрхирдаг үндсэрхэх үзлээр, арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа үхүүлга сурталчилгааг хуулиар хориглоно.



## **Монгол Улсын Үндсэн хууль (1992)<sup>1</sup>**

### **Есдүгээр зүйл.**

1. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.
2. Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй.
3. Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.

### **Арван дөрөвдүгээр зүйл.**

1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
2. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

### **Арван зургадугаар зүйл.**

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:  
15/шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

### **Арван есдүгээр зүйл.**

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.
2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.
3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

---

<sup>1</sup> 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр. <https://legalinfo.mn/mn/detail/367>

## **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт (1994.01.12, №02)**

*Төр, сүм хийдийн харилцааны тухай  
хуулийн зарим заалт үндсэн хууль  
зөрчсөн тухай маргааныг хянан  
хэлэлцсэн тухай*

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг 1994 оны 1 дүгээр сарын 11-нд Төрийн ордны 251 дүгээр өрөөнд үйлдэв. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн гишүүн Н.Жанцан даргалж, гишүүдэд Г.Нямдоо, Ц.Цолмон, С.Жанцан /илтгэгч/, Д.Чилхаажав нарын бүрэлдэхүүнтэй хийв.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Цэцийн нарийн бичгийн дарга Б.Цэндээхүү оролцов.

Маргагч талуудыг төлөөлж Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Ч.Ган-Өлзий, Ч.Зоригтбаатар нар оролцов.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7, 8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн иргэдийг төлөөлж иргэн Р.Гончигдорж, Д.Ламжав тухайн хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг Үндсэн хууль зөрчсөн гэж өргөдөл гаргасан иргэн Д.Дашдэндэв, энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгүүд Үндсэн хууль зөрчсөн гэж нэхэмжилсэн иргэн Н.Алтанчимэг нар оролцов.

**Д.Ламжав нарын хэсэг иргэд Үндсэн хуулийн Цэцэд 1993 оны 12 дугаар сарын 13-нд хандсан гомдолдоо:** "Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганаар батлагдсан "Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн "... шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн "лам, санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулж", 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Сүм хийд нь ... Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", мөн зүйлийн 6 дахь хэсгийн "Монгол Улс дахь буддын болон мусульман шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна", 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна", 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин номын

зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн, харъяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 15 дахь хэсгийн "Монгол Улсын иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй", 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд ... хуулиар зохих хязгаарлал тогтоож болно", 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хүнийг ... шашин шүтлэгээр нь ... гадуурхаж үл болно", 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн нь нэг шашныг бусдаас илүүд үзэх тухай тунхагласан, буддын болон мусульман шашнаас бусад шашныг гадуурхсан санааг агуулж байна" гээд Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэж өгөхийг хүссэн байна.

**Иргэн Д.Дашдэндэв 1993 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:** "Төр, сүм хийдийн харилцааны хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7; 7 дугаар зүйлийн 6; 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг нь уг хуулийнхаа 1 дүгээр бүлэгтэйгээ, Үндсэн хууль, НҮБ-ын хүний эрхийн түгээмэл тунхаглалын 18, 19, 26 дугаар зүйлүүдтэй бүрэн зөрчилдсөн, Христэд итгэгч иргэдийн эрх чөлөөг боогдуулсан, ялгаварлан гадуурхах үзлээр дүүрэн болсон байна. Итгэгч бидний эрхийг хамгаалсан хууль гаргахад та бүгдийг тусална гэдэгт итгэнэ" гэжээ.

Мөн Баянзүрх дүүргийн 18 дугаар хорооны иргэн Н.Алтанчимэг, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны иргэн Б.Цэрэндаш нар Цэцэд хандсан өргөдөлдөө: "Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ" гэсэн нь Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчиж байна.

Мөн Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн харъяалал бүхий сургууль байгуулагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалтыг, мөн түүнчлэн тус хуулийн 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн захиргааны шийтгэл оногдуулах тухай заалт Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн шашны асуудал эрхлэх зөвлөлийн зохицуулагч Г.Лхагвасүрэн Үндсэн хуулийн Цэцэд өгсөн тодорхойлолтдоо: "Энэ хуулийн төслийг хүний шүтэх, эс шүтэх эрхийг баталгаатай хангах, төр шашны байгууллагуудын

хоорондын харилцааг зохицуулах үүднээс Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан гэж үздэг. Гаднаас шашныг зохион байгуулалттайгаар оруулж байгаа нь нууц биш. Үүнийг улсынхаа үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдлийг хамгаалах үүднээс түүнийг хориглох нь зүйтэй" гэжээ.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Элбэгдорж Үндсэн хуулийн Цэцэд өгсөн тодорхойлолтдоо: "Энэ хууль зөвхөн Төр, сүм хийдийнхээ харилцааг л зохицуулсан бол бидэнд маргалдах шаардлага гарахгүй байсан. Энэ харилцаанаас хэтрээд шашны олон асуудлыг хамарсан, хүн бүрийн салшгүй эрх болох шүтэх бишрэх эрхэд зохицуулалт, хязгаарлалт тогтоох гэж оролдсоноороо уг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байна" гэжээ.

Монголын бурхан шашинтны төв, Гандантэгчилэн хийд Үндсэн хуулийн Цэцэд ирүүлсэн албан бичигтээ: "Бурханы шашин туурга тусгаар Монгол Улсын түүхээс үзвэл хэд хэдэн удаа төрийн шашин байсан нь үнэн бөгөөд энэ шашинтай хамт урлаг, соёл, шинжлэх ухаан дэлгэрсэн, олон зуун жилд уламжлагдан шүтэгдэж ирсэн шашин учраас Төр нь зайлшгүй хүндэтгэх нь зүйтэй. Энэ үүднээс Төр, сүм хийдийн харилцааны хууль хүн ард, сүсэгтэн олны сэтгэл санаанд нийцэж байгаа юм" гэжээ.

МУҮИС-ийн оюутан Д.Отгонбаатар, С.Сүхбаатар нарын 70 оюутан, иргэн Ж.Лхамсүрэн нар ирүүлсэн захидалдаа: "Буддын шашны зонхилох байр суурийг төрөөс хуулиар баталгаажуулсан нь ард түмний эв нэгдэл, түүхэн уламжлал, эрх ашигт нийцсэн, энэ хууль хувь хүний шүтэх, эс шүтэх эрхийг хязгаарлаагүй.

Төр, сүм хийдийн хууль хэвээрээ үлдэнэ гэдэгт найдаж байна" гэжээ.

**Иргэн Ж.Батбаяр, Б.Цэрэндорж, С.Алтанзул, Д.Оюунгэрэл нараас Цэцэд хандаж гаргасан өргөдөл, хүсэлтдээ:** "Энэ хууль Үндсэн хууль зөрчиж бидний оюун санааны эрх чөлөөг хязгаарлалаа. Энэ хуулийн заалт нэг нь нөгөөдөө харшилж байгаа бөгөөд олон заалтаараа Үндсэн хууль зөрчсөн байна" гэжээ.

Цэцийн хуралдаан дээр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Ган-Өлзий, Ч.Зоригтбаатар нар хэлсэн үгэндээ: "Буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэнэ гэсэн нь Үндсэн хуулийн заалтын эх үндэстэй тунхаглалын шинжтэй заалт тул Үндсэн хууль зөрчөөгүй. Монголд хамгийн хэлмэгдсэн шашин бол буддын шашин юм. Бид тэр шашны өмнө гэм буруугаа наманчилах учир бий. Хүн амын олонхи шүтэж байгаа тул хүндэтгэнэ гэж хэлсэн юм.

Гадаадаас шашныг зохион байгуулалттай нэвтрүүлэх нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд нөлөөлөхийг үгүйсгэхгүй. Ер нь хүний эрхийг баталгаажуулсан олон улсын пактад шүтэж бишрэх эрх чөлөөтэй байх заалтуудыг ямар нөхцөлд хязгаарлаж болохыг заасан байдаг. Маргаж буй бусад заалтуудад хийсэн хязгаарлалтууд ч үүнтэй холбоотой юм. Бид энэ хуулийг Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна" гэжээ.

**Үндсэн хуулийн Цэцийн хуралдаан дээр нэхэмжлэгч тал болон оролцсон Р.Гончигдорж, Д.Ламжав, Д.Дашдэндэв, Н.Алтанчимэг нар хэлсэн үгэндээ** "Төр, сүм хийдийн харилцааны хууль нь Монгол Улсын Үндсэн хуультай үзэл баримтлалын хувьд зөрчилдөж байгаа бөгөөд Үндсэн хуульд бүх шашин тэгш эрхтэй түүнд Монголын болон гадаадын иргэдийн шүтэх эрхийг нэгэн адилаар тунхагласан байхад ноцтой зөрчсөн байна.

Энэ хуулиар буддын болон мусульман шашныг бусад шашны дээгүүр тавьж гадаадын иргэдийн шашны сургалт, сурталчилгааг хаасан, шүтэх эрх чөлөөг сүм, хийд нь Монголд байхгүй бүх шүтлэгтний тухайд хязгаарласан хууль болжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг ийнхүү ноцтой гуйвуулсан нь манай улсын нэр хүндийг олон улсын хэмжээнд унагах аюулд ч хүргэх юм. Иймд төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд байгаа бидний маргаж байгаа зүйлүүд хүчингүй болоод зогсохгүй уг хууль бүхэлдээ хүчингүй болох ёстой" гэжээ.

## **ХЯНАВАЛ:**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улс дахь буддын болон мусульман шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно гэсэн заалт нь сүм хийд нь Монголд байхгүй бусад сүсэгтнүүдийн шашны номлол, сургалт, сурталчилгаа явуулах эрхийг хязгаарласан агуулга илэрхийлж байна.

Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна гэдэг заалт нь шашны байгууллагын дотоод хэрэгт төрөөс оролцож байгаа агуулгатай болжээ.

Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин-номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн харъяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно гэдэг заалт тус улсад шашин-номын зорилгоор ирснээс бусад бүх гадаадын иргэн, харъяалалгүй хүний салшгүй эрх болох шашин шүтэх шашны сурталчилах эрхэнд халдсан агуулгатай болжээ.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7, 8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад

шашин шүтэхэд саад болохгүй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн удиртгал хэсгийн үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх, мөн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэх гэсэн заалтуудтай уялдан гарсан тунхаглалын шинжтэй заалт тул Үндсэн хуультай нийцэж байна.

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн "... шашныг гаднаас зохион байгуулалттай нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн заалт нь үндэсний эв нэгдэл, аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, Монголын ард түмний түүхэн уламжлал, зан заншилд хохирол учруулж болох хүмүүнлэг бус үйл ажиллагаатай аливаа шашны үрсгалыг Монгол Улсад зориуд нэвтрүүлэх тохиолдолд хязгаарлалт болох агуулгаараа Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 18, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна.

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн "Лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна" гэсэн заалт, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн харъяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно", 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ", 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 15000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна", мөн зүйлийн 3 дахь хэсгийн " Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх 5000-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна" гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасан дагуу төр, сүм хийдийн харилцааг хуулиар зохицуулах хүрээнд багтаж байгаа асуудал тул Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг удирдлага болгон Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанаас дараахь **ДҮГНЭЛТИЙГ** гаргав.

1. Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Монгол Улс дахь буддын болон мусульман, шашин, бөө мөргөлөөс

бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно", 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Бүддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна", 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн, харъяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь, 16 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэв.

2.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 7, 8 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

3.Манай дүгнэлтийг хэрхэн шийдсэн тухай хариуг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор мэдэгдэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилж байна.

ДАРГА

Н.ЖАНЦАН

ГИШҮҮД

Г.НЯМДОО

Ц.ЦОЛМОН

С.ЖАНЦАН

Д.ЧИЛХААЖАВ

# **Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хууль (1993)**

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулиар зарлан тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах баталгааг тогтоож, төр, сүм хийдийн хоорондын харилцааг зохицуулахад оршино.

### **2 дугаар зүйл.Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах хууль тогтоомж**

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

/Энэ зүйлд 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

### **3 дугаар зүйл.Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө**

1.Аливаа шашныг шүтэх буюу эс шүтэх нь тухайн хүний итгэл үнэмшлийн хэрэг байна.

2.Иргэнийг шашин шүтэх, эс шүтэхэд албадах, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

3.Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4.Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг гагцхүү бусад иргэний мөнхүү эрх чөлөө, эрүүл мэнд, ёс суртахуун болон үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг тогтон зохицуулж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээр зохицуулан хэрэгжүүлнэ.

5.Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгахыг хориглоно.



## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦАА**

### **4 дүгээр зүйл.Төр, сүм хийдийн харилцааны үндэс**

1.Монгол Улс дахь төр, сүм хийдийн харилцаа төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ.

2.Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй.

3.Төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

4.Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөлд төрөөс сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах, шаардлагатай бол зогсоох эрхтэй.

5.Сүм хийд, лам санваартан нар Монгол Улсын хууль тогтоомжийг дээдлэн үзэж биелүүлнэ.

6.Сүм хийдээс төрийн байгууллагын үүргийг эрхлэн гүйцэтгэхгүй бөгөөд төрийн эрх мэдлийн төлөө улс төрийн үйл ажиллагаа явуулах, түүнд оролцох, санхүүжүүлэхийг хориглоно.

7.Шашны нэр хүнд, хүн амын сүсэг бишрэлийг улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны эрх ашигт нийцүүлэн ашиглах, шашныг гаднаас зохион байгуулалттайгаар нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

8.Лам санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна.

### **5 дугаар зүйл.Төр, сүм хийдийн харилцааг тодорхойлон хэрэгжүүлэх**

1.Төрөөс шашин, сүм хийдийн талаар баримтлах бодлогын үндсийг Монгол Улсын Их Хурал тодорхойлно.

2.Ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна.

3.Төрөөс сүм хийдтэй харилцах харилцааг зохион байгуулж хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга тус тус эрхлэн гүйцэтгэнэ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ**

### **6 дугаар зүйл.Шашны байгууллага**

Сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг /цаашид энэ хуульд "сүм хийд гэх/ шашны байгууллага гэнэ.

### **7 дугаар зүйл.Сүм хийд, лам санваартны үйл ажиллагааны эрх зүйн үндэс**

1.Шашин-номын үйлсийг эрхлэн гүйцэтгэгч лам санваартан нар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу иргэний эрхээ эдэлж, үүрэг хүлээнэ.

2.Сүм хийд, лам санваартан нар бурхан тахилын зүйлс, ном судар бүтээх, шашны зан үйл үйлдэх, хурал ном хурах зэргээр сүсэгтэн олонд чөлөөтэй үйлчилнэ.

3.Шашны зан үйлийг тухайн шашны уламжлалт ёс журмын дагуу энэ хууль, бусад хууль тогтоомжоор тусгайлан хориглоогүй газарт сүсэгтний хүсэлтээр тэдэнд зориулж чөлөөтэй үйлдэж болно.

4.Сүм хийд бие дааж буюу удирдах төвөөрөө уламжлан төрийн аль ч шатны байгууллагад асуудлаа тавих, харилцах эрхтэй.

5.Сүм хийд нь тухайн шашны уламжлалт ёс дэгийг тусгасан дотоод журмыг чанд баримтлах бөгөөд Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

6-/Энэ хэсгийг 1994 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй/.

7.Аливаа шашны байгууллага, лам санваартан өөрийн шашныг эс шүтэгчдэд үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэхийг хориглоно.

8.Сүм хийд нийгмийн даатгалын шимтгэл төлж лам санваартнаа тэтгэвэр, тэтгэмжид хамруулж болно. Лам санваартан эрүүл мэндийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдана.

9.Сүм хийдэд гэрээгээр ажиллагсдын хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

10.Шашны байгууллага гадаад харилцааны асуудлаа эрх бүхий төрийн байгууллагатай зөвлөлдөн шийдвэрлэнэ.

## **8 дугаар зүйл.Шашны сургалт**

1.Шашны боловсролыг шашны сургууль, гэрийн сургалтаар олгоно.

2.Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагуудад шашны сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно. Энэ заалт нь шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалтад үл хамаарна.

3.Шашны сургуульд суралцагчдад иргэний суурь боловсрол олгохыг тухайн сургууль хариуцна. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газраас баталсан журмын дагуу үүнд шаардагдах зардлын тодорхой хэсгийг гаргаж, багшлах боловсон хүчнээр ханган, мэргэжлийн хяналт тавина.

## **9 дүгээр зүйл.Сүм хийд байгуулах**

1.Сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдлийг дүрмийн хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Олгосон зөвшөөрлийг үндэслэн сүм хийдийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2./Энэ хэсгийг 1994 оны 1 дүгээр сарын 14-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/.

3.Сүм хийд дүрэмтэй байна. Дүрэмд дор дурдсан зүйлийг тусгана:

1/сүм хийдийн нэр, хаяг;

2/шашны харьяалал, бүтэц, үйл ажиллагаагаа эхлэх үеийн бүрэлдэхүүний байдал;

3/үйл ажиллагааны хамрах хүрээ, хэлбэр;

4/шашин-номын хэрэгслэлийн хангамжийн байдал;

5/үйл ажиллагаа явуулах, өргөжин бэхжих хөрөнгө санхүүгийн бодит боломж, анхдагч хөрөнгийн хэмжээ;

6/хуулийн этгээд болох үндэслэл;

7/бусад зүйл.

4.Сүм хийд нь дүрэмдээ оруулсан нэмэлт, өөрчлөлтийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр албан ёсоор мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

5.Сүм хийдийн дүрэм, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлах бол сүм хийд байгуулах зөвшөөрөл олгохгүй буюу олгосон зөвшөөрлөө цуцална. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо хууль тогтоомжийн дагуу шүүхэд гаргаж болно.

## **10 дугаар зүйл.Сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох**

1.Сүм хийдийн үйл ажиллагааг дараахь үндэслэлээр зогсооно:

1/тухайн сүм хийд өөрөө үйл ажиллагаагаа зогсоохоор шийдвэрлэсэн;

2/Монгол Улсын хууль тогтоомж зөрчигдсөн нь шүүхээр тогтоогдсон тохиолдолд зөвшөөрөл олгосон байгууллага тухайн сүм хийдийн үйл ажиллагааг зогсоохоор шийдвэрлэсэн.

2.Сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргасан байгууллага энэ тухай улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэж бүртгэлээс хасуулна.

/Энэ хэсэгт 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

3.Сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох шийдвэрийг эс зөвшөөрвөл хууль тогтоомжийн дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

## **11 дүгээр зүйл.Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг зохицуулах**

1.Сүм хийдийн өмч, аж ахуйн харилцааг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

2.Сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд байгаа газраас үл салах түүх, соёлын үл хөдлөх дурсгал, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд, дурсгалын талаарх мэдээллийг соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлнэ.

/Энэ хэсгийг 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хууль, 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3.Сүм хийд шашин номын үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад нь шаардлагатай музей, номын сангуудад хадгалагдаж буй түүх, соёлын дурсгалт зүйлсийг гэрээ хэлцлийн дагуу авч хэрэглэж болно.

/Энэ хэсгийг 2014 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

4.Сүм хийд нь шашин-номын үйл ажиллагаагаа эрхлэн явуулах, ахуйн хэрэгцээгээ хангахад зайлшгүй шаардагдах аж ахуйг өмчийнхөө хүрээнд эрхэлж болно.

5.Сүм хийд үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоох тохиолдолд үүсгэн байгуулагчид нь анх оруулсан эд хөрөнгөө нэхэмжилбэл тэдгээрт хөрөнгийг нь олгож, хөрөнгийн бусад хэсгийг лам санваартнуудын саналыг харгалзан аль нэгэн сүм хийдэд, боломжгүй бол төрийн мэдэлд шилжүүлнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **12 дугаар зүйл.Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль тогтоомж гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хамаарах**

1.Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хууль тогтоомж нь тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

2./Энэ хэсгийг 1994 оны 1 дүгээр сарын 14-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/.

### **13 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

/Энэ зүйлийг 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.БАГАБАНДИ

## Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал (2018)<sup>1</sup>

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй”<sup>2</sup>, “Хүнийг ...шашин шүтлэг, үзэл бодлоор ... нь ялгаварлан гадуурхаж үл болно.”<sup>3</sup>, “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гахцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг... үл хөндөнө.”<sup>4</sup> хэмээн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нь хүний салшгүй эрх болохыг хуульчлан баталгаажуулсан.

2010 онд батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд<sup>5</sup> иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг хангах асуудал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох соёл, иргэншил, үндэсний эв нэгдэл, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй болохыг тодорхойлсон байна.

Түүнчлэн Монгол Улс нь иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг хангах чиглэлд үүрэг хүлээлгэсэн Иргэний болон Улс төрийн эрхийн пакт<sup>6</sup>, Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн пакт<sup>7</sup>, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц<sup>8</sup>, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц<sup>9</sup>, Хүүхдийн эрхийн тухай конвенцид<sup>10</sup> тус тус нэгдэн орсон байна.

<sup>1</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, <https://moiha.gov.mn/wp-content/uploads/2018/10/Shashin-huuliin-uzel-barimtlal.pdf>

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 15.

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2.

<sup>4</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2.

<sup>5</sup> Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоол.

<sup>6</sup> Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18- ны өдөр соёрхон баталсан.

<sup>7</sup> Монгол Улс 1974 оны 11 дүгээр сарын 18- ны өдөр соёрхон баталсан.

<sup>8</sup> Монгол Улс 1969 оны 03 дугаар сарын 31-ний өдөр нэгдэн орсон.

<sup>9</sup> Монгол Улс 1981 оны 7дугаар сарын 20-ны өдөр нэгдэн орсон.

<sup>10</sup> Монгол Улс 1970 оны 7 дугаар сарын 05-ны өдөр нэгдэн орсон.

Ийнхүү Монгол Улс нь 1993 онд Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр Монгол Улсад олон шашны байгууллагууд зэрэгцэн оршиж, үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн бөгөөд сүм, хийд шинээр байгуулах зөвшөөрөл олгох ажиллагаа 1994 оноос эхэлсэн байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд 1993 онд улсын хэмжээнд 93 сүм, хийд үйл ажиллагаа явуулж байсан<sup>11</sup> бол 2004 онд 225<sup>12</sup>, 2016 онд 350 сүм хийдийг тоолсон байна.<sup>13</sup>

Зөвхөн Нийслэлийн хэмжээнд 2000 онд 35 сүм, хийд үйл ажиллагаа явуулж байсан бол 2014 онд 286 болж даруй 8 дахин нэмэгдсэн<sup>14</sup>, 2016 оны 5 сарын байдлаар 330 болж<sup>15</sup>, сүүлийн 2 жилийн дотор 44 шашны байгууллага шинээр байгуулагджээ.<sup>16</sup>

Эдгээрээс гадна байгууллагын буюу хуулийн этгээдийн статусаар бус хувиараа шашин, сүсэг бишрэлийн зан үйл хийдэг үзмэрч, зөн билэгтэн, бөөгийн шашны удган, зайран зэрэг иргэд ч олширсон байна.

1992 оноос хойш Монгол Улсын хүн амын шашин шүтлэгийн талаарх мэдээллийг харьцуулж үзэхэд шашин шүтдэг хүн амын хувь хэмжээ, иргэдийн шүтдэг шашны урсгал, чиглэлийн эзлэх хувьд ч томоохон өөрчлөлт гарсан байна.

Тухайлбал, 2003 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны захиалгаар хийгдсэн судалгаанд оролцсон иргэдийн 22.9% нь шашин шүтдэггүй гэсэн бол 2010 он (Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого) энэ хувь 38.6% болж өссөн байна. Түүнчлэн 2003 онд судалгаанд оролцогчдын 66.8 % нь буддын шашин шүтдэг гэсэн бол 2010 онд энэ хувь 53% болж буурсан байна.

Үүнээс дүгнэхэд Монгол Улс дахь шашны байгууллагуудын үйл ажиллагаа өргөжихийн хэрээр иргэдийн шашинд хандах хандлага, шашин шүтлэгийн байдал өөрчлөгдөж, улмаар нийгэм, соёл боловсрол, эдийн засгийн гээд бүхий л салбарт хүчтэй нөлөө үзүүлэх болжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн шалгалтын мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд 6 төрлийн шашны 20 гаруй урсгалын 848 хуулийн этгээд шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагаас 54.2% нь христийн, 34.6% нь буддын, 5.1% нь исламын, үлдсэн 6 % нь бусад чиглэлийн шашны байгууллага байна.<sup>17</sup>

---

<sup>11</sup> “Гадаадын болон олон улсын шашны төрийн бус байгууллагуудын Монгол дахь үйл ажиллагаа, үр нөлөө” судалгаа. Хууль сахиулахын их сургууль. 2017 он.

<sup>12</sup> Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны толлогын тайлан.

<sup>13</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. /[www.nso.mn/](http://www.nso.mn/)-2016 он.

<sup>14</sup> Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны тооллогын тайлан.

<sup>15</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. /[www.nso.mn/](http://www.nso.mn/)-2016 он.

<sup>16</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн.

<sup>17</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн.

Энэхүү өргөн өөрчлөлтийн үр дүнг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулах боломжгүйн зэрэгцээ хуулийн зохицуулалтын хүрээ нь зөвхөн шашны байгууллагатай холбоотой харилцаагаар хязгаарлагдсан, мөн шашны харилцаанд тавих хяналтын хэлбэрийг уламжлалт буюу Буддын шашны шинж, онцлогт тулгуурлан сүм, хийд, дацан, төв гэсэн хэлбэрээр тодорхойлсон (Христийн шашны байгууллага нь ихэвчлэн чуулган, цуглаан гэсэн нэрээр үйл ажиллагаа явуулдаг) зэргээс хамаарч тус хуулийг хэрэгжилттэй холбоотой олон бэрхшээл үүсэх болжээ.

1994 онд Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн "Монгол Улс дахь буддын болон мусульман, шашин, бөө мөргөлөөс бусад шашны номлол, сургалт, сурталчилгааг тухайн шашны сүм хийдээс гадуур явуулахыг хориглоно" гэсэн, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Буддын болон мусульман шашны сүм хийд байгуулахад Монгол Улс дахь тухайн шашны удирдах төвийн албан ёсны санал дүгнэлтийг авсан байна" гэсэн, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Тус улсад шашны байгууллагын шугамаар шашин номын зорилгоор ирснээс бусад гадаадын иргэн, харъяалалгүй хүн шашны сурталчилгаа явуулахыг хориглоно" гэсэн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 15 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр<sup>18</sup> хүчингүй болсон байна.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 25 жилийн хугацаанд дээрх өөрчлөлтөөс гадна тус хуульд 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Тодруулбал, 1995 онд тус хуулийг зөрчсөн байгууллага, хүн, албан тушаалтанд хүлээлгэх торгуулийн хэмжээг нэмэгдүүлсэн, 1997 онд сүм хийд өөрийн эзэмшилд болон өмчлөлд буй газраас үл салах түүх, соёлын дурсгалт зүйл, бусад үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд заавал бүртгүүлэх үүргийг хүлээлгэсэн нэмэлтийг тусгасан бол 2014, 2015 онуудад Соёлын өвийг хамгаалах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагалдуулж тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.<sup>19</sup>

Гэвч эдгээр нэмэлт, өөрчлөлт нь төр, шашны байгууллага хоорондын болон шашны үйл ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хуулийн шинэчлэл, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Ийнхүү өнөөгийн нийгэм, эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд<sup>20</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг "Шашны

<sup>18</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) Үндсэн Хуулийн Цэцийн 1994 оны 02 дугаар дүгнэлт.

<sup>19</sup> [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn). Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль.

<sup>20</sup> Монгол Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 111-ний өдрийн 11 дүгээр тогтоол.



байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоо, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох”<sup>21</sup> чиглэлээр шинэчлэх зорилгыг дэвшүүлжээ.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээгээр<sup>22</sup> “... хуулийн хэрэгжилт хангалтгүй, хуулийн зохицуулалтын хийдлээс шалтгаалан шашны үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхлэх, ТББ болон хуулийн этгээдийн бусад хэлбэрээр халхавчлан хяналтгүйгээр шашны үйл ажиллагаа явуулах, сүсэг бишрэлээр нь далимдуулан иргэдийг сэтгэл санаа, эд хөрөнгөөр хохироох, насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд олноор нь татан оролцуулах зэрэг хууль зөрчсөн олон асуудал байна.” хэмээн дүгнэсэн байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2016 онд 350 сүм хийдийг тоолсон бол мөн оны байдлаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 439 шашны байгууллага бүртгэлтэй<sup>23</sup> гэсэн мэдээлэл байна.

Харин Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн шалтгалтаар 848 шашны байгууллага<sup>24</sup> үйл ажиллагаа явуулж байгаа нь тогтоогдсон бөгөөд эдгээр шашны байгууллагын 41.5 хувь буюу 352 байгууллага зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан байна.<sup>25</sup>

Энэ нь шашны байгууллагыг тодорхойлж буй хуулийн зохицуулалт оновчтой бус, сүм хийдийн салбар, төлөөлөгчийн газрууд нь тусгай зөвшөөрөлтэй байх эсэх асуудлыг тодорхой хуульчлаагүйтэй холбоотой байна.

Ийнхүү хяналт, бүртгэлийн сүл талыг ашиглан шашны үйл ажиллагааг төрийн бус байгууллага (ТББ), боловсролын, эрүүл мэндийн болон хэвлэл мэдээллийн байгууллага төдийгүй ашгийн төлөөх хуулийн этгээдийн хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагууд ч эрхлэн явуулж байгаа тохиолдол цөөнгүй байна.<sup>26</sup>

Тухайлбал, 2017 оны байдлаар шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 гаруй олон улсын ТББ байна<sup>27</sup> гэсэн судалгааны дүн байгаа боловч өөр зорилго,

---

<sup>21</sup> Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл 160 дахь зорилт.

<sup>22</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. ХЗДХЯ.2018 он.

<sup>23</sup> ХЗДХЯ-нд ирүүлсэн Оюун өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 2/10283 дугаар албан бичиг.

<sup>24</sup> ХЗДХЯ-наас 2016 онд явуулсан шалгалтын тайлан.

<sup>25</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн

<sup>26</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүнд хавсаргасан шалгалт хийх шаардлагатай шашны үйл ажиллагаа явуулдаг байгууллагын жагсаалтанд ТББ, ББСБ, ХХК, эмнэлэг, худалдааны төв, сургууль, цэцэрлэг, хүүхийн зуслан, хэвлэлийн статус бүхий байгууллагыг хамруулсан байсан болно.

<sup>27</sup> “Гадаадын болон олон улсын шашны төрийн бус байгууллагуудын Монгол дахь үйл ажиллагаа, үр нөлөө” судалгаа. ХСИС.2017 он.

үйл ажиллагааны хэлбэрээр халхавчлан шашны үйл ажиллагаа эрхэлж байгаа хэчнээн ТББ байгааг тодорхойлох боломжгүй юм.

Үндэсний статистикийн мэдээллээр 2016 оны байдлаар улсын хэмжээнд 1731 лам санваарта<sup>28</sup>н бүртгэгдсэний 1327 нь буддын, 345 нь христийн, 46 нь исламын, 13 нь бусад буюу бахай, мүүн, бөөгийн шашны санваартан байна гэжээ.<sup>29</sup>

Түүнчлэн сүүлийн жилүүдэд хувиараа шашны зан үйл, засал хийдэг, мэргэлдэг, зөн билэгтэн гэх иргэд болон бөөгийн шашны удган, зайран олширсон бөгөөд сүм хийдэд харьяалагдахгүй тул бүртгэл, хяналтгүйгээр өөрсдийн тогтоосон журмаар иргэдэд үйлчилж байна.

Иймд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэх хүрээнд хуулиар тогтоосон хэм хэмжээг иргэд, нийгмийн бүхий л бүлэг сахих үүрэгтэй төдийгүй энэхүү хуулийн үйлчлэл нь дан ганц шашны байгууллага/сүм хийд/-д хамааралтай бус хувийн журмаар шашны үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг ч хамааруулан зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас(цаашид ИТХ гэх) сүм хийдийг байгуулах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэдэг боловч хуульд зөвшөөрөл олгоход харгалзах нөхцөл, бүртгэхээс татгалзах үндэслэлийг тусгайлан заагаагүйгээс ямар шалгуур тогтоох нь тухайн орон нутгийн ИТХ-ын эрх хэмжээний асуудал болсон байна.

Хэдийгээр хуульд сүм хийдэд зөвшөөрөл олгох, сүм хийдийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг аймаг, нийслэлийн ИТХ-аас батлан мөрдүүлэх талаар эрх олгосон заалт байхгүй ч нийслэл болон 7 аймагт харьяа ИТХ-аас баталсан журмыг мөрдөж байгаа бол 14 аймагт энэ талаар тусгайлан баталсан журамгүй байна.<sup>30</sup>

Ийнхүү хуульд зохицуулалтгүй орхисон хэсгийг ИТХ-аас журам баталж нөхөн зохицуулах ородлого хийж байгаа нь зүйтэй мэт боловч шалгуурыг орон нутаг бүр өөр өөрөөр тогтоох, тухайн үеийн ИТХ-ын гишүүдийн ойлголт, хандлагаас хамаарч шалгуурыг өөрчлөх эрсдэлтэй байдал нь шашны асуудлаар Монгол Улсын баримтлах нэгдмэл бодлогыг гажуудуулж, хууль тэгш үйлчлэх, нэг мөр хэрэгжих, тогтвортой байх зарчмыг алдагдуулж байна.

Тухайн нутаг дэвсгэрийн хүн амын байршлаас хамаарч сүм хийдийн тооны харьцаа ялгаатай байж болох ч зөвшөөрлийг орон нутгийн ИТХ-аас олгодог, энэ талаар улсын хэмжээнд нэгдсэн бодлого байхгүй, нэгдсэн хяналт, бүртгэлийг сулруулсан зэрэг бэрхшээлийг үүсгэж байна.

---

28

<sup>29</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

<sup>30</sup> ХЗДХ-ийн сайдаас өгсөн үүргийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын тайлан. 2015 он. ХЗДХЯ

Тухайлбал, 2014 оны байдлаар нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын 25% нь Баянзүрх дүүрэгт, 19% нь Сонгинохайрхан дүүрэгт, 16% нь Баянгол дүүрэгт байна. Эдгээр шашны байгууллагуудын 61.3% нь христийн шашны сүм хийд бөгөөд зөвхөн Баянзүрх дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа 92 шашны байгууллагын 65 буюу 71% нь гэхэд христийн шашны байгууллага байна.<sup>31</sup>

Мөн насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах, шашны боловсрол олгох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн сүүлийн 9 жилийн(2007-2016) статистикийг харьцуулж үзвэл шашны сургууль, дацанд суралцагсдын тоо жилээс жилд буурсан үзүүлэлттэй байна.

**Эх сурвалж:** Монгол Улсын Үндэсний статистик: 2016 он

Он	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Суралцагчид	2251	1820	1273	1564	1362	779	591	342	269	163

2016 оны байдлаар шашны сургуульд суралцаж байгаа хүүхдийн 63,8% нь буддын, 14.7% нь христийн, 21.4% нь исламын шашны чиглэлээр суралцаж байна.<sup>32</sup>

2014 онд Хүүхдийн төлөө үндэсний газар, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран 21 аймаг, Нийслэлийн 3 дүүргийн хүрээнд сүм хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг 2282 хүүхдийг хамруулан хийсэн судалгаагаар тогтмол шавилан суудаг 502 хүүхэд байна<sup>33</sup> гэсэн дүн гаргасан байна.

Үүнээс дүгнэхэд шашны сургуульд суралцагч хүүхдийн тоо бодитой эсэх нь эргэлзээтэй байна.

Үндэсний статистикийн хорооны 2016 оны мэдээллээр гэрээр шашны номонд суралцагч 2581 хүүхэд байгаагийн 2.4% нь буддын, 19.9 % нь христийн, 2.5 % нь исламын шашны чиглэлээр суралцаж байгаа бол 77.6% нь бусад шашны буюу бөө, бахай, мүүний шашны чиглэлд хамаарч байна.<sup>34</sup>

Статистик мэдээллээр гэрээр шашны ном заалгадаг хүүхдийн тоо шашны сургуульд суралцагч хүүхдээс даруй хэд дахин их байгаа нь цаашид анхаарах тулгамдсан асуудлын нэг юм.

Хүний эрхийн үндэсний комиссоос 2012 онд буддын шашны 54, христийн шашны 7, исламын шашны 1 буюу нийт 62 шашны сургуульд суралцаж буй 290

<sup>31</sup> Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны тооллогын тайлан.

<sup>32</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. <https://www.nso.mn>

<sup>33</sup> Сүм, хийдийн үйл ажиллагаанд хамрагддаг болон шавилан сууж буй хүүхдүүдийн сүм хийдэд татагдаж буй шалтгаан. ХТҮГ, НҮБ-ын ХС-ын хамтарсан үнэлгээний тайлан 2014 он

<sup>34</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. <https://www.nso.mn>

хүүхдийн дунд хийсэн судалгаанаас<sup>35</sup> үзэхэд хүүхдэд иргэний суурь боловсрол олгох нь хангалтгүй бөгөөд огт хамруулахгүй байх, эсхүл сургалтыг ёс төдий, чанаргүй зохион байгуулах нь түгээмэл байна. Тухайлбал, буддын шашны сургалт явуулдаг 54 сургуулийн 11-д нь шавилан сууж байгаа 30 хүүхэд ерөнхий боловсролын сургалтанд огт хамрагдаж байгаагүй сургууль завсардсан бөгөөд сургуульд элсэн орох 6 наснаасаа сүм хийдэд шууд шавилан сууж, сургуульд явж үзээгүй хүүхэд ч тэдний дунд байсан байна.

Эдгээр бодит байдал нь шашны боловсрол олгох үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцөлийг тодорхойлж, шашны сургуулийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулах, суралцагсдын бүртгэл мэдээлэлд анхаарах, түүнчлэн гэрээр шашны боловсрол олгох асуудалд тавих хяналтыг тодорхой хуульчлах шаардлагатайг илэрхийлж байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж ирсэн харилцааг төрөөс шашны талаар баримтлах бодлого, иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрхийн баталгааг хангахад чиглүүлэн өргөжүүлж, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн нэрийг “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль” гэж өөрчилнө.

## **Хоёр.Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

1993 онд батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж ирсэн нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарсан тул хуулийн төслийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль болгон өргөжүүлж Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан, Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн талаархи олон улсын гэрээний суурь зарчимд нийцүүлэн дараахь агуулгаар шинэчилнэ:

1. Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлж, иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг аливаа хэлбэрээр зөрчихөөс хамгаалахтай холбоотой зарчмыг тодорхой хуульчилна. Энэхүү хуулийн үйлчлэлд шашны байгууллагаас гадна хуулийн этгээдийн эрхгүй шашны бүлэг болон хувийн журмаар шашны үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг хамааруулна.
2. Иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийн баталгааг сайжруулахад анхаарч хуулийн зохицуулалтын шинэчлэлийг Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээний суурь зарчимд нийцүүлнэ. Энэ

---

<sup>35</sup> Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 12 дахь итгэл. ХЭҮК. 2014 он.

зорилтын хүрээнд Үндсэн хуульд заасан “төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх” зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгана.

3. Шашны байгууллагыг сүм хийд, дацан, төв гэсэн буддын шашны уламжлалт хэлбэрээр байгуулахаар, мөн тэдгээрийн эрхлэх үйл ажиллагааг зөвхөн зан үйл, хурал ном, боловсролын үйл ажиллагаа гэж хязгаарлан тодорхойлсныг өөрчилнө. Иргэд сайн дураар нэгдэн шашин шүтэх эрхээ хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр эдлэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ хуулийн этгээдийн бусад хэлбэрээр халхавчлан шашны үйл ажиллагаа явуулахыг хориглож, эдгээр үйлдэлд Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулна. Шашны байгууллага нь үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хүрээнээс хамаарч орон нутгийн болон төвлөрсөн байгууллага гэсэн төрөлтэй байхаар хуульчилж, тавигдах шаардлага, үүсгэн байгуулагч, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг ялгаатай тодорхойлно.
4. Насан хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах хүрээг тогтоож, хүүхдээс өөрийн шашныг сонгох, өөрчлөх, татгалзах болон шашин шүтэх эрхийг хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог тодорхойлж, мөн насанд хүрээгүй хүүхдийг шашин, сүм хийдийн ажиллагаанд оролцуулахад эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг заавал авах зохицуулалтыг шинээр тусгана.
5. Шашны байгууллага байгуулахтай холбоотой зөвшөөрөл, бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгож, иргэдийн шашин шүтэх эрх чөлөөтэй байх эрхийн хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах, шашин хоорондын харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий шашны асуудал эрхэлсэн Зөвлөлийн ажиллах эрх зүйн үндэслэлийг хуульчилна.
6. Шашны бүлэг болон шашны байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор тэдгээрийн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлагыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тодорхойлно. Мөн шашны бүлэг, шашны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй байх журмыг тогтооно. Энэ хүрээнд шашны бүлэг, шашны байгууллагын орлого болон бусдын өгсөн хандивыг хэрхэн бүртгэх, гадаадын иргэн, байгууллагын хандив, санхүүжилтэд тавих хяналт зэрэг асуудлыг тодорхой болгож, шашны байгууллагад үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ гаргаж, тайлагнах үүргийг хүлээлгэнэ.
7. Шашны бүлэг, шашны байгууллагаас явуулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тогтоож, олон нийтэд шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх

чөлөөтэй байх эрхийг баталгаажуулах зарчимд нийцүүлнэ.

8. Төрөөс шашны талаар баримтлах бодлогыг тодорхойлоход шашны байгууллагад татварын болон бусад хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, шашны байгууллагын өмчлөл, эзэмшилд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, хадгалах, сэргээн засахад хөрөнгийн болон бусад туслалцаа үзүүлэх зэргээр төрөөс шашны байгууллагыг дэмжих, хамтран ажиллах хэлбэрийг тогтооно.
9. Шашны боловсрол олгох үйл ажиллагаанд тавигдах шаардлага, нөхцөлийг тодорхой зааж, шашны сургуулийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулах, түүнд дотоод хэргийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тавих хяналтын хүрээг тодорхойлно.
10. Шашны байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах үндэслэлийг тогтооно. Татан буулгах үндэслэлд тухайн шашны байгууллагын өөрийн шийдвэрээс гадна, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл алдагдсан буюу дампуурсан, мөн хууль тогтоомжоор тавигдах хориглолт, хязгаарлалтыг ноцтой зөрчсөн байх нөхцөлийг тогтоон хуульчилна.
11. Тус хуульд тусгасан бүртгэлийн шинэ зохицуулалтанд нийцүүлэн шашны байгууллагыг шинэчилсэн бүртгэлд хамруулахтай холбоотой шилжилтийн зохицуулалт болон холбогдох бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хамтад нь боловсруулна.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль(Шинэчилсэн найруулга) батлагдсанаар иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрхийг хангах нөхцөл бүрдэж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүсээд байгаа зөрчил, хийдэл арилж, нэгдсэн зохицуулалттай болно.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой хэмжээний зардал гарах боловч энэ нь иргэдийн эрхийг хангах, үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдлийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Хууль батлагдсаны дараа хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцсон үнэлгээг Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хийнэ.

### **Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын

үзэл баримтлал болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд үр нөлөөг үнэлж, улмаар практикт хэрэгжих боломж, харилцан уялдаа, давхардал, хийдэл, зөрчлийг нягтлан, боловсруулалтыг сайжруулна.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан 1993 онд батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, холбогдох бусад хуулийн төслийг боловсруулах болно.

# “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төслийн тухай танилцуулга (2018)<sup>1</sup>

## Нэг. Хуулийн төслийн зорилго, ач холбогдол

Монгол Улс нь ардчилсан, нээлттэй нийгмийн шилжилтийн эхний жилүүдэд Үндсэн хуулийнхаа үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн төрөлжсөн хуулиудыг батлан хэрэгжүүлж эхэлсний нэг нь 1993 онд баталсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль билээ.

Тус хуулийн дагуу Монгол Улсад олон шашны байгууллагууд зэрэгцэн оршиж, үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн бөгөөд сүм, хийд шинээр байгуулах зөвшөөрөл олгох ажиллагаа 1994 оноос эхэлсэн байна.

Монгол Улсад 1993 онд улсын хэмжээнд 93 сүм, хийд үйл ажиллагаа явуулж байсан<sup>2</sup> бол 2004 онд 225<sup>3</sup>, 2016 онд 350, 2017 онд 344 сүм хийдийг тоолсон байна.<sup>4</sup>

2017 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын 52.3% нь христийн, 39.5% нь буддын, 6.1% нь исламын, үлдсэн 2.1 % нь бусад чиглэлийн шашны байгууллага байна.<sup>5</sup>

Эдгээрээс гадна байгууллагын буюу хуулийн этгээдийн статусаар бус хувиараа шашин, сүсэг бишрэлийн зан үйл хийдэг үзмэрч, зөн билэгтэн, бөөгийн шашны удган, зайран зэрэг иргэд ч олширсон байна.

Үүнээс дүгнэхэд Монгол Улс дахь шашны байгууллагуудын үйл ажиллагаа өргөжихийн хэрээр иргэдийн шашинд хандах хандлага, шашин шүтлэгийн байдал өөрчлөгдөж, улмаар нийгэм, соёл боловсрол, эдийн засгийн гээд бүхий л салбарт хүчтэй нөлөө үзүүлэх болжээ.

Энэхүү өргөн өөрчлөлтийн үр дүнг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулах боломжгүйн зэрэгцээ хуулийн зохицуулалтын хүрээ нь зөвхөн шашны байгууллагатай холбоотой харилцаагаар хязгаарлагдсан, мөн шашны харилцаанд тавих хяналтын хэлбэрийг уламжлалт буюу Буддын шашны шинж, онцлогт тулгуурлан сүм, хийд, дацан, төв гэсэн хэлбэрээр тодорхойлсон (Христийн шашны

<sup>1</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2018/10/Shashin-huuiin-Taniitsuulqa.pdf>

<sup>2</sup> “Гадаадын болон олон улсын шашны төрийн бус байгууллагуудын Монгол дахь үйл ажиллагаа, үр нөлөө” судалгаа. Хууль сахиулахын их сургууль. 2017 он.

<sup>3</sup> Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны толлогын тайлан.

<sup>4</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. [www.nso.mn/](http://www.nso.mn/)-2016 он.

<sup>5</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн



байгууллага нь ихэвчлэн чуулган, цуглаан гэсэн нэрээр үйл ажиллагаа явуулдаг) зэргээс хамаарч тус хуулийг хэрэгжилттэй холбоотой олон бэрхшээл үүсэх болжээ.

Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 25 жилийн хугацаанд тус хуульд 5 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан боловч эдгээр нь төр, шашны байгууллага хоорондын болон шашны үйл ажиллагаатай холбоотой тулгараад байгаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд бус харин салбарын бусад хуулийн шинэчлэл, эсхүл тэдгээрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Ийнхүү эрх зүйн зохицуулалтын хийдэл, хяналт, бүртгэлийн сул талыг ашиглан шашны үйл ажиллагааг төрийн бус байгууллага (ТББ), боловсролын, эрүүл мэндийн болон хэвлэл мэдээллийн байгууллагаас гадна ашгийн төлөөх хуулийн этгээдийн хэлбэрээр бүртгэгдсэн байгууллагууд ч эрхлэн явуулж байгаа тохиолдол цөөнгүй байна.<sup>6</sup>

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн шалгалтын мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд 6 төрлийн шашны 20 гаруй үрсгалын 848 хуулийн этгээд шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагаас 41.5 хувь буюу 352 байгууллага зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан байна.<sup>7</sup>

2017 оны байдлаар улсын хэмжээнд 1529 лам санваартан бүртгэгдсэний 1303 нь буддын, 197 нь христийн, 26 нь исламын, 3 нь бусад буюу бахай, мүүн, бөөгийн шашны санваартан байна гэжээ.<sup>8</sup>

Гэвч сүүлийн жилүүдэд хувиараа шашны зан үйл, засал хийдэг, мэргэлдэг, зөн билэгтэн гэх иргэд болон бөөгийн шашны удган, зайран олширсон бөгөөд сүм хийдэд харьяалагдахгүй тул бүртгэл, хяналтгүйгээр өөрсдийн тогтоосон журмаар иргэдэд үйлчилж байна.

Иймд шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэх хүрээнд хуулиар тогтоосон хэм хэмжээг иргэд, нийгмийн бүхий л бүлэг сахих үүрэгтэй төдийгүй энэхүү хуулийн үйлчлэл нь дан ганц шашны байгууллага/сүм хийд/-д хамааралтай бус хувийн журмаар шашны үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг ч хамааруулан зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Мөн насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах, шашны боловсрол олгох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн сүүлийн 9 жилийн(2007-2016) статистикийг харьцуулж үзвэл шашны сургууль, дацанд суралцагсдын тоо жилээс жилд буурсан үзүүлэлттэй байгаа боловч гэрээр шашны ном заалгадаг

---

<sup>6</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүнд хавсаргасан шалгалт хийх шаардлагатай шашны үйл ажиллагаа явуулдаг байгууллагын жагсаалтанд ТББ, ББСБ, ХХК, эмнэлэг, худалдааны төв, сургууль, цэцэрлэг, хүүхийн зуслан, хэвлэлийн статус бүхий байгууллагыг хамруулсан байсан болно.

<sup>7</sup> ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн

<sup>8</sup> Үндэсний статистикийн хорооны мэдээлэл.

хүүхдийн тоо шашны сургуульд суралцагч хүүхдээс даруй хэд дахин их байгаа нь цаашид анхаарах тулгамдсан асуудлын нэг болжээ.

Ийнхүү өнөөгийн нийгэм, эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд<sup>9</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг “Шашны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоо, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох”<sup>10</sup> чиглэлээр шинэчлэх зорилгыг дэвшүүлсэн.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж ирсэн харилцааг төрөөс шашны талаар баримтлах бодлого, иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрхийн баталгааг хангахад чиглүүлэн “Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль” нэрээр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

## **Хоёр.Хуулийн төслийн боловсруулалт**

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, Монгол Улс дахь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтын судалгаа болон төр, шашны эрх зүйн зохицуулалтын талаархи гадаад улсын туршлага судлах харьцуулсан судалгааг тус тус гүйцэтгэсэн байна.

Эдгээр үнэлгээ болон судалгааны дүгнэлт, зөвлөмжийг хуулийн төсөл боловсруулахад ашигласан болно.

## **Гурав.Хуулийн бүтэц**

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль нь 5 бүлэг, 45 зүйлтэй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулагдсан.

Тус хуулийн төсөлд дараахь шинэлэг зохицуулалтыг тусгасан болно:

1. Иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх, шашны бүлэг болон шашны байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор тэдгээрийн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлагыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тодорхойлсон.

Энэ хүрээнд иргэн, шашны бүлэг, шашны байгууллага нь хууль тогтоомж зөрчөөгүй тохиолдолд тэдний үйл ажиллагаанд төр хөндлөнгөөс оролцохгүй байх

---

<sup>9</sup> Монгол Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 111-ний өдрийн 11 дүгээр тогтоол.

<sup>10</sup> Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл 160 дахь зорилт.

зарчимд тулгуурлан хуулиар тогтоох хязгаарлалт, түүний үндэслэл, журмыг тодорхой заасан.

Энэ дагуу 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн нь шашны бүлэг, шашны байгууллагыг үүсгэн байгуулах эрхтэй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн нь шашны бүлэг, байгууллагад гишүүнээр элсэх, үйл ажиллагаанд нь оролцох болон шашны байгууллагад хөдөлмөр эрхлэх эрхтэй байхаар хязгаарлан зохицуулсан.

Түүнчлэн тус хуулиар шашны байгууллагаас гадна хуулийн этгээдийн эрхгүй шашны бүлэг болон хувийн журмаар шашны үйл ажиллагаа эрхлэгч буюу шашны номлол түгээгчийн(лам, хуврага, санваартан, пастер, бөө, удган гэх мэт) үйл ажиллагааг зохицуулсан.

2. Иргэд сайн дураар нэгдэн шашин шүтэх эрхээ хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр эдлэх боломжийг бүрдүүлж, шашны бүлэг болон шашны байгууллагыг үүсгэн байгуулах журам, тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлсон.

Шашны бүлгийг иргэд шашин шүтэх эрхээ хамтран хэрэгжүүлэх зорилгоор нэгдэн байгуулах бөгөөд зөвхөн гишүүддээ чиглэсэн үйл ажиллагааг тэдний хөрөнгө, хандивын санхүүжилтээр явуулахаар хязгаарласан.

Харин шашны байгууллагыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр орон нутгийн болон төвлөрсөн шашны байгууллага хэлбэрээр байгуулах бөгөөд зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэрийн хүрээнд сүсэгтэн олонд үйлчлэх, шашны сургалт, боловсрол олгох, ном судар бүтээх зэргээр шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахаар зохицууллаа.

Шашны ижил үрсгал, чиглэлд хамаарах 10-аас доошгүй орон нутгийн шашны байгууллага нэгдэж төвлөрсөн шашны байгууллага байгуулах бөгөөд шашны сургууль, шашны хэвлэл мэдээллийн байгууллага байгуулах, нийтэд зориулж шашны ном, зохиол хэвлэх, мөргөл, тахилын зориулалттай бусад зүйл үйлдвэрлэх, түгээх эрхтэй байхаар тусгасан.

3. Шашны бүлэг, шашны байгууллагын орлого болон бусдын өгсөн хандивыг хэрхэн бүртгэх, гадаадын иргэн, байгууллагын хандив, санхүүжилтэд тавих хяналт зэрэг асуудлыг тодорхой болгож, шашны байгууллагад үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ гаргаж, тайлагнах үүргийг хүлээлгэсэн.

Мөн шашны байгууллагад татварын болон бусад хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, шашны байгууллагын өмчлөл, эзэмшилд байгаа түүх, соёлын дүрсгалт зүйлсийг хамгаалах, хадгалах, сэргээн засахад хөрөнгийн болон бусад туслалцаа үзүүлэх зэргээр төрөөс шашны байгууллагыг дэмжих, хамтран ажиллах хэлбэрийг тогтоолоо.

Ийнхүү тус хуулиар төр, бизнес, улс төрийн үйл ажиллагааг шашны нөлөөллөөс ангид байлгах, хуулийн этгээдийн бусад хэлбэрээр болон соёл урлаг, буюны үйл

ажиллагаагаар халхавчлан шашны үйл ажиллагаа явуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

4. Насан хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах хүрээг тогтоож, хүүхдээс өөрийн шашныг сонгох, өөрчлөх, татгалзах болон шашин шүтэх эрхийг хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог тодорхойлсон.

Насанд хүрээгүй хүүхдийг шашин, сүм хийдийн ажиллагаанд оролцуулахад эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг заавал авах зохицуулалтыг шинээр тусгасан.

5. Шашны бүлэг болон шашны байгууллагад хориглох үйл ажиллагааг тодорхой зааж, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, холбогдуулан авах арга хэмжээг тогтоосон.

Шашны бүлэг, шашны байгууллага, шашны номлол түгээгч нь харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хууль бус бусад аргаар явуулахыг хориглосон.

Ийнхүү хууль бус үйл ажиллагаа явуулсан нь ял, шийтгэл хүлээх төдийгүй шашны байгууллагыг татан буулгах үндэслэл болно.

6. Үндэсний аюулгүй байдал, иргэдийн шашин шүтэх эрх чөлөөтэй байх эрхийн хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилго бүхий шашны асуудал эрхэлсэн зөвлөлийг чиг үүргийг тодорхойлсон.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан 1993 онд батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай, Сонгуулийн тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Улс төрийн намын тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Зар сурталчилгааны тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

# Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай Монгол Улсын хуулийн төсөл (шинэчилсэн найруулга, 2018)<sup>1</sup>

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, шашин шүтлэгийн байдлаас хамаарч хүнийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, төр, шашны харилцаа болон шашны байгууллага, шашны бүлэг, шашны номлол түгээгчийн үйл ажиллагаатай холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний хууль тогтоомж

2.1. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>2</sup>, Иргэний хууль<sup>3</sup>, Улсын бүртгэлийн ерөнхий хууль<sup>4</sup>, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль<sup>5</sup>, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт шашны үйл ажиллагаа явуулж байгаа шашны бүлэг, шашны байгууллага, шашны номлол түгээгчийн үйл ажиллагаа хамаарна.

### 4 дүгээр зүйл.Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрх

4.1. Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг баталгаатай эдэлнэ.

4.2. Иргэн нь сүсэг бишрэлтэй байх, ганцаарчлан болон хамтран шашин шүтэх, эс шүтэх, чөлөөтэйгөөр шашнаа сонгох, өөрчлөх, татгалзах, шашны үйлсэд зүтгэх, сүм, хийд, дацан, мөргөлийн газар болон шашны үйлчилгээ үзүүлдэг бусад газар шавьлан суух, шашны бүлэг, шашны байгууллага байгуулах, шашны зан үйл,

<sup>1</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, <https://mojha.gov.mn/>

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Улсын бүртгэлийн ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны ... дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны ... дугаарт нийтлэгдсэн.

ёслол үйлдэх, шашны ёс зүйн болон шашны бусад сургалтанд хамрагдах зэргээр шашны үйл ажиллагаанд оролцох, шашны сургаал, номлолыг хууль тогтоомжийн хүрээнд дэлгэрүүлэх эрх, эрх чөлөөтэй.

4.3. Иргэн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

4.4. Шашин шүтлэгийн ялгаа, шашин шүтэх, эс шүтэх байдлаас хамаарч бусдад давуу байдал олгох болон хязгаарлалт бий болгох, түүнчлэн аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4.5. Иргэн шашин шүтлэгийн ялгаа, шашин шүтэх, эс шүтэх байдлаас үл хамааран хуулийн өмнө тэгш эрхтэй байна.

4.6. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн сүсэг бишрэл, шашин шүтлэгийн талаархи өөрийн хандлага, байр суурь, үзэл бодлын талаар мэдээлэл өгөх үүрэг хүлээхгүй.

4.7. Иргэнийг шашин шүтэх, эс шүтэх, шашны зан үйл, ёслол үйлдэх, сургалт, шашны байгууллагын үйл ажиллагаанд оролцох, эс оролцох болон шашны үйл ажиллагаанд хандив өгөх, эд материалын дэмжлэг үзүүлэхийг аливаа хэлбэрээр албадах, дарамт үзүүлэх, заналхийлэхийг хориглоно.

4.8. Наминчлалын нууц нь хуулиар хамгаалагдана. Шашны байгууллагын номлол түгээгч иргэний өөрт нь наминчилсан асуудлаар хууль сахиулах байгууллага болон шүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзах нь хуулийн хариуцлага хүлээх үндэслэл болохгүй.

4.9. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 5-д заасныг үндэслэн энэ хуулийн холбогдох зохицуулалтаар гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний шашны бүлэг, шашны байгууллага байгуулах, шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх эрхэнд хязгаарлалт тогтооно.

4.10. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн нь шашны бүлэг, байгууллагад гишүүнээр элсэх, үйл ажиллагаанд нь оролцох болон хуульд заасны дагуу шашны байгууллагад хөдөлмөр эрхлэх эрхтэй.

## **5 дугаар зүйл. Хүүхдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрх**

5.1. Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зохицуулалт нь хүүхдэд нэгэн адил хамаарна.

5.2. Шашны бүлэг, шашны байгууллагын гишүүнчлэлд бага насны хүүхдийг элсүүлэх, татан оролцуулах, хүүхдийн хүсэл зоригийн эсрэг болон эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр шашны сургуульд элсүүлэх, шашны сургалтанд хамруулах, шашны үйл ажиллагаа болон шашны бүлэг, шашны байгууллагаас зохион байгуулж байгаа бусад арга хэмжээнд оролцуулахыг хориглоно.

5.3. Хүүхдэд шашны хүмүүжил, боловсрол олгох, хүүхдийг оролцуулах шашны аливаа зан үйл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжилд харшлахгүй, нас болон бусад онцлогт нийцсэн байх ёстой.

Тайлбар: - Энэ хуульд заасан “бага насны хүүхэд” гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно.

## **6 дугаар зүйл. Төр, шашны бүлэг, шашны байгууллагын харилцаа**

6.1. Төр, шашны бүлэг, шашны байгууллагын хоорондын харилцаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэнэ.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан зарчмыг дараахь агуулгын хүрээнд төр баримтална:

6.2.1. Монгол Улсын төр нь шашнаас ангид бөгөөд аливаа нэг шашин, шашны урсгал, чиглэлийг төрийн, эсхүл албан ёсны шашин гэж тогтоохгүй байх;

6.2.2. төрт ёс, үндэсний эв нэгдэл, түүх соёлын уламжлалыг нандигнан өвлөх үүднээс Монгол Улс дахь буддын шашин /цаашид “уламжлалт шашин” гэх/-ы зонхилох байр суурийг хүндэтгэх бөгөөд энэ нь иргэн бусад шашныг шүтэхэд саад болохгүй байх;

6.2.3. иргэний шашин шүтлэгийн талаархи хандлага, байр суурь, үзэл бодлыг тодорхойлж, бүртгэхгүй байх;

6.2.4. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүүхэддээ өөрийн итгэл үнэмшлийн дагуу шашны албан бус боловсрол, мэдлэг, дадал олгох эрхийг аливаа хэлбэрээр хязгаарлах, хууль зөрчсөнөөс бусад тохиолдолд хөндлөнгөөс оролцохгүй байх;

6.2.5. шашны бүлэг, шашны байгууллагад төрийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэх, сонгуулийн үйл ажиллагаа, сурталчилгаанд оролцохыг тулгах, эсхүл үүрэг хүлээлгэхгүй байх;

6.2.6. шашны бүлэг, шашны байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомж зөрчөөгүй тохиолдолд үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс оролцохгүй байх;

6.2.7. Монгол Улсын Үндсэн хуулийн байгуулал, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учирч болох нөхцөлд төрөөс шашны бүлэг, шашны байгууллагын үйл ажиллагаа, эсхүл тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах, шаардлагатай бол зогсоох.

6.3. Төрийн байгууллага, төрийн албан тушаалтан нь энэ хуульд заасан шашны бүлэг, байгууллага болон гадаад улсын шашны байгууллагаас аливаа

хэлбэрээр хандив, эд материаллын дэмжлэг авахын хориглоно.

6.4. Энэ хуулийн 6.1-д заасан зарчмыг дараахь агуулгын хүрээнд шашны бүлэг, шашны байгууллага баримтална:

6.4.1. шашны бүлэг, шашны байгууллага нь төрийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг гүйцэтгэхгүй байх;

6.4.2. Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

6.4.3. улс төрийн нам болон улс төрийн хөдөлгөөний үйл ажиллагаанд оролцохгүй, улс төрийн үйл ажиллагаанд эд материалын болон бусад дэмжлэг, туслалцаа үзүүлэхгүй байх;

6.4.4. шашны нэр хүнд, хүн амын сүсэг бишрэлийг ашиг олох болон улс төрийн нам, байгууллага, албан тушаалтны эрх ашгийг хангах зорилгод нийцүүлэн ашиглахгүй байх.

6.5. Шашны бүлэг, шашны байгууллагын гишүүн иргэн бусад иргэний адил төрд ажиллах, бүх шатны сонгуульд нэр дэвших, оролцох, улс төрийн намын болон нийгмийн бусад эвсэл, хөдөлгөөнд гишүүнчлэлтэй байх нь тухайн шашны бүлэг, шашны байгууллага төрийн үйл ажиллагаа, улс төрийн намын болон улс төрийн хөдөлгөөний үйл ажиллагаанд оролцсон гэж үзэхгүй.

6.6. Төрийн эрх бүхий байгууллага нь шашны бүлэг, шашны байгууллагатай холбоотой асуудлаар шийдвэр гаргахдаа тухайн шашны бүлэг, шашны байгууллагад уг асуудлаар байр сууриа илэрхийлэх боломж олгоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШАШНЫ БҮЛЭГ, ШАШНЫ БАЙГУУЛЛАГА**

### **7 дугаар зүйл. Шашны бүлэг**

7.1. Иргэд шашин шүтэх эрхээ хамтран хэрэгжүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг шашны бүлэг гэнэ.

7.2. Шашны бүлгийн гишүүн нь Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн байж болно.

7.3. Шашны бүлгийн үйл ажиллагаа явуулах байр, эд хөрөнгө нь зөвхөн гишүүдээс олгогдсон байх бөгөөд бусад этгээдээс хандив, дэмжлэг, тусламж авахыг хориглоно.

7.4. Шашны бүлгийг байгуулснаас хойш 30 хоногт багтаан бүлэг байгуулсан тухай харьяа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт мэдэгдэнэ.

7.5. Энэ хуулийн 7.4-т заасан мэдэгдэлд тухайн бүлгийн баримтлах шашны урсгал, чиглэл, гол сургаал, номлол, бүлгийн гишүүдийн овог, эцэг, эхийн болон өөрийн нэр, оршин суугаа хаяг, үйл ажиллагаагаа явуулах байршлын талаархи мэдээллийг батлагдсан маягтийн дагуу хавсаргана.



7.6. Шашны бүлэг нь энэ хуулийн 7.4-т заасан мэдэгдэлийг хүргүүлснээс хойш 2 жилд тутамд үйл ажиллагааны тайланг харьяа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт нэгээс цөөнгүй удаа гаргах үүрэгтэй. Тайланд бүлгийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал, бүлгийн гишүүнчлэлд гарсан өөрчлөлтийн талаар тусгана.

7.7. Энэ хуулийн 7.4-т заасан мэдэгдэл, түүнд хавсаргах мэдээллийн маягт болон 7.6-д заасан тайлан гаргах журмыг шашны асуудал эрхэлсэн зөвлөлөөс батална.

7.8. Шашны бүлэг нь шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны болон шашны ёс зүйн талаар сургалтыг зөвхөн бүлгийн гишүүдийг оролцуулан зохион байгуулах эрхтэй.

7.9. Шашны бүлэг нь буяны үйл ажиллагаа явуулж болох бөгөөд буяны үйл ажиллагааг зохион байгуулахад аливаа хэлбэрээр шашны зан үйл, ёслол үйлдэх, шашин түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.10. Зорилго, үйл ажиллагаа нь хуульд нийцээгүй шашны бүлэг үүсгэн байгуулах, энэ хуулийн 27.2-т заасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.11. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар нь 2 жил тутамд нэг удаа өөрийн харьяалах нутаг дэвсгэрт хамаарах шашны бүлгийн үйл ажиллагааны талаархи нэгдсэн тайлан гаргаж шашны асуудал эрхэлсэн зөвлөлд тайлагнана.

## **8 дугаар зүйл.Шашны байгууллага**

8.1. Шашны аль нэг чиглэлийн сургаал, номлолд үндэслэн шашны зан үйл, ёслол үйлдэх, шашны болон шашны ёс зүйн сургалт, боловсрол олгох, ном судар бүтээх зэргээр шашныг үхуулан дэлгэрүүлэх, олон нийт, сүсэгтэн болон дагагч нартаа мөргөл, тахилга, залбиралын чиглэлээр нээлттэй үйлчлэх зорилготой хуулийн этгээдийг шашны байгууллага гэнэ.

8.2. Шашны байгууллагыг үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрээс хамаарч орон нутгийн болон төвлөрсөн гэж ангилна.

8.3. Орон нутгийн шашны байгууллагыг 18 насанд хүрсэн 10-аас доошгүй Монгол Улсын иргэн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулж болно.

8.4. Шашны ижил үрсгал, чиглэлд хамаарах 10-аас доошгүй орон нутгийн шашны байгууллага сайн дурын үндсэн дээр нэгдэж төвлөрсөн шашны байгууллага байгуулж болно.

8.5. Орон нутгийн шашны байгууллага нь төвлөрсөн шашны байгууллагад гишүүнээр элсэж болно.

8.6. Шашны байгууллага нь хууль тогтоомж болон дүрэмдээ заасан журмаар үйл ажиллагаагаа явуулна.

8.7. Орон нутгийн шашны байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасны дагуу олгосон зөвшөөрөлд тодорхойлсон нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

8.8. Шашны байгууллага нь шашны уламжлал, зан заншлаа тусгасан дотоод журамтай байж болно. Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах, хүмүүнлэг бус, хууль тогтоомжтой зөрчилдсөн журам тогтоохыг хориглоно.

8.9. Зорилго, үйл ажиллагаа нь хуульд нийцээгүй шашны байгууллага үүсгэн байгуулах, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

## **9 дүгээр зүйл.Шашны байгууллагын нэр**

9.1. Шашны байгууллага нь шашны үйл ажиллагаа эрхэлдэг болохоо илэрхийлсэн агуулга бүхий оноосон нэртэй байна.

9.2. Шашны байгууллагын нэр нь түүний оноосон нэр болон “Шашны байгууллага” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “ШБ” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

9.3. Шашны байгууллагын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс өөр этгээд өөрийн оноосон нэртэй хамт “Шашны байгууллага” болон “ШБ” гэсэн тэмдэглэгээг хэрэглэхийг хориглоно.

9.4. Сүм, хийд, дацан, төв зэрэг тодотголыг шашны байгууллагын оноосон нэрэндээ хэрэглэж болох бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдснээс хойш 50-аас багагүй жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулж байгаа төвлөрсөн шашны байгууллага нэрэндээ МОНГОЛ, МОНГОЛЫН, ҮНДЭСНИЙ, НИЙТИЙН, НЭГДСЭН гэсэн үг болон эдгээр үгнээс үүссэн бусад нийтийг төлөөлсөн үтга бүхий үг ашиглах эрхтэй.

9.5. Шашны байгууллага нь нэр, байршилаа шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн зөвшөөрөлтэйгээр өөрчилнө.

9.6. Шашны байгууллага нь аливаа үйл ажиллагаа явуулахдаа өөрийн нэрийг мэдээлэх үүрэгтэй.

## **10 дугаар зүйл.Шашны байгууллага үүсгэн байгуулах**

10.1. Шашны байгууллага байгуулахаар тохиролцсон этгээдүүд үүсгэн байгуулах хурал зохион байгуулж, дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

10.1.1. шашны байгууллага байгуулах тухай шийдвэр гаргах;

10.1.2. 10.1.2.шашны байгууллагын дүрмийг батлах;

10.1.3. удирдах зөвлөлийг томилох.

## **11 дүгээр зүйл. Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл**

11.1. Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрлийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан шашны асуудал эрхэлсэн зөвлөл олгоно.

11.2. Орон нутгийн шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараахь мэдээллийг батлагдсан маягтын дагуу хавсаргана:

11.2.1. үүсгэн байгуулагчдын овог, эцэг, эхийн болон өөрийн нэр, тэдгээрийн төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суух хаягийн талаархи мэдээлэл;

11.2.2. иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспорт, тэдгээртэй адилтгах баримт бичгийн хуулбар;

11.2.3. шашны байгууллагын дүрэм;

11.2.4. үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэр, хүн амын талаархи мэдээлэл.

11.3. Төвлөрсөн шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараахь мэдээллийг хавсаргана:

11.3.1. үүсгэн байгуулагчдын оноосон нэр, тэдгээрийн үүсгэн байгуулагдсан он, сар, өдөр, хаягийн талаархи мэдээлэл;

11.3.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

11.3.3. үүсгэн байгуулах шашны байгууллагын дүрэм.

11.4. Дараахь тохиолдолд шашны байгууллага байгуулах улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзана:

11.4.1. тухайн шашны байгууллагын зорилго, үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн тодорхой зүйл заалттай зөрчилдөхөөр бол;

11.4.2. үүсгэн байгуулагч нь шашны бус чиглэлийн байгууллага, эсхүл шашны байгууллага үүсгэн байгуулахыг хориглосон этгээд бол;

11.4.3. дүрэм болон бусад мэдүүлсэн баримт бичиг нь хууль тогтоомжоор тогтоосон шаардлагад нийцэхгүй байх, мөн түүнчлэн эдгээр баримт бичигт агуулагдаж байгаа мэдээлэл нь зөрүүтэй бол;

11.4.4. үүсгэн байгуулагч /байгуулагчид/ эрх зүйн чадамжгүй бол;

11.4.5. харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг түгээн дэлгэрүүлэхээр бол.

11.5. Шашны асуудал эрхэлсэн зөвлөл нь энэ хуулийн 11.2, 11.3-т заасан хүсэлтийг хүлээж авснаас хойш 60 хоногт багтаан шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Шашны байгууллагын эрх олгох, цуцлах журмын дагуу шийдвэрлэнэ.

11.6. Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг шийдвэрлэхэд хянан үзэх нөхцөл байдал байна гэж үзвэл энэ хуулийн 11.5-д заасан хугацааг 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

11.7. Энэ хуулийн 11.2, 11.3-т заасан мэдээлэл гаргах маягт болон мөн хуулийн 11.5-д заасан Шашны байгууллагын зөвшөөрөл олгох, цуцлах журмыг шашны асуудал эрхэлсэн зөвлөл батлана.

## **12 дугаар зүйл.Шашны байгууллагыг үүсгэн байгуулагч**

12.1. Шашны байгууллагыг үүсгэн байгуулах тухай шийдвэр гаргаж, шашны байгууллагын дүрмийг баталсан этгээдийг шашны байгууллагын үүсгэн байгуулагч гэнэ.

12.2. Үүсгэн байгуулагч удирдах зөвлөлийн гишүүн байж болно.

12.3. Дараахь этгээд нь шашны байгууллагын үүсгэн байгуулагч байхыг хориглоно:

12.3.1. гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;

12.3.2. Эрүүгийн хуулийн 14.1, 14.4, 18.6, 19.8, 19.9, 20.2, 20.3, 29.1, 29.2, 29.3, 29.8, 29.9, 29.10, 29.11 дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн бол ял эдэлж дууссанаас хойш 10 жил өнгөөрөөгүй бол;

12.3.3. үндсэн хуульт тогтолцоо, төрийн байгууламжийг хууль бусаар, хүч хэрэглэн өөрчлөх, устгах, үндэсний эв нэгдэлийг бусниулах, төрлөөр устгах зорилгоор шашны үйл ажиллагаа явуулсан, харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг түгээн дэлгэрүүлдэг шашны бүлэг, шашны байгууллагын гишүүн.

12.4. Шашны байгууллага байгуулагдсаны дараа тухайн шашны байгууллагад хандив өгсөн, тусламж, дэмжлэг үзүүлсэн этгээдийг үүсгэн байгуулагчид тооцохгүй.

12.5. Үүсгэн байгуулагч болон энэ хуулийн 12.4-т заасан этгээдийн шашны байгууллагад оруулсан хөрөнгө тухайн шашны байгууллагын эд хөрөнгө болно.

12.6. Үүсгэн байгуулагч шашны байгууллагын эд хөрөнгийг өмчлөх эрхгүй байна.

## **13 дугаар зүйл.Шашны байгууллагын дүрэм**

13.1. Шашны байгууллага нь хууль тогтоомжид нийцсэн дүрмийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

13.2. Шашны байгууллагын дүрмийг тухайн шашны байгууллагын үүсгэн байгуулагчдын хурлаас батална.

13.3. Төвлөрсөн шашны байгууллага нь өөрийн гишүүн орон нутгийн шашны байгууллагын дүрэмд тусгах асуудлын талаар чиглэл өгч болно.

13.4. Шашны байгууллагын дүрэмд доор дурдсан зүйлийг тусгана:

13.4.1. нэр, байршил, шашны байгууллагын төрөл, шашны төвлөрсөн байгууллагад харьяалагддаг бол түүний нэр;

13.4.2. шашны байгууллагын зорилго, үйл ажиллагааны үндсэн хэлбэр, шашны сургаал, номлол, шашны мөргөл, зан үйл, ёслол, гишүүддээ тусгай шаардлага тавьдаг эсэх талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, тайлбар;

13.4.3. өөрчлөн байгуулагдах болон татан буугдах үндэслэл, журам;

13.4.4. шашны байгууллагын бүтэц, тогтолцоо болон түүнийг байгуулах журам, гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ;

13.4.5. байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр болон өмчлөлд байгаа мөнгөн болон бусад эд хөрөнгийн эх үүсвэр/гарал/-ийн талаархи мэдээлэл;

13.4.6. дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах журам;

13.4.7. үйл ажиллагаа зогссон үед өмчийн захиран зарцуулалт хийх журам;

13.4.8. тухайн шашны байгууллагын онцлогоос хамаарч бусад мэдээлэл.

13.5. Шашны байгууллагын дүрэмд эрх барих байгууллагын шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд холбогдох хөдөлгөөнийг хийлгэснээр хүчин төгөлдөр болно.

13.6. Энэ хуулийн 13.4-т заасантай холбоотой асуудлаар шашны байгууллагын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай шашны асуудал эрхэлсэн зөвлөлд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байна.

13.7. Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх болон дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахад хууль тогтоомжоор тогтоосон хэмжээгээр хураамж төлнө.

## **14 дүгээр зүйл. Шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх**

14.1. Энэ хуулийн 11.1-д заасан зөвшөөрлийг үндэслэн шашны байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

14.2. Шашны байгууллагын хуулийн этгээдийн эрх нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэнээр үүснэ.

14.3. Шашны байгууллагыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх харилцааг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулна.

## **15 дугаар зүйл.Шашны байгууллагын удирдлага, зохион байгууллалт**

15.1. Шашны байгууллагын эрх барих байгууллага нь удирдах зөвлөл байна.

15.2. Шашны байгууллага нь хяналтын болон гүйцэтгэх байгууллагатай байна.

## **16 дугаар зүйл.Удирдах зөвлөл**

16.1. Удирдах зөвлөл хандивлагч, дэмжигч тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ.

16.2. Удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, бүрэн эрхийн хугацааг дүрмээр тогтооно.

16.3. Удирдах зөвлөл гишүүд дотроосоо даргаа сонгоно.

## **17 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн бүрэн эрх**

17.1. Удирдах зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

17.1.2. шашны байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах

17.1.3. шашны байгууллагын жилийн төсвийг батлах;;

17.1.4. шашны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;

17.1.5. гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх түүнтэй гэрээ байгуулах, эд хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой эрх хэмжээг нь тодорхойлох;

17.1.6. хяналтын байгууллагыг томилох.

## **18 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн хурал**

18.1. Удирдах зөвлөлийн ээлжит хурлыг жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулах ба хурлыг Удирдах зөвлөлийн дарга товлон.

18.2. Хяналтын байгууллагын шаардсанаар ээлжит бүс хурлыг зарлан хуралдуулж болно.

18.3. Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцсоноор удирдах зөвлөлийн хурал хүчин төгөлдөр болно.

18.4. Удирдах зөвлөлийн хурлыг удирдах зөвлөлийн дарга, түр эзгүйд нь түүний даалгасан гишүүн удирдана.

18.5. Удирдах зөвлөлийн дарга, гишүүд хуралдааны тэмдэглэл үнэн, зөв хөтлөгдсөн эсэхийг хянаж, гарын үсэг зурна.

## **19 дүгээр зүйл. Удирдах зөвлөлийн шийдвэр**

19.1. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр энэ хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Удирдах зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

19.2. Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхэд хуралд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

19.3. Удирдах зөвлөлийн хуралд оролцсон гишүүн бүр нэг саналын эрхтэй байна.

19.4. Удирдах зөвлөл нь цөөн гишүүнтэй бөгөөд тэдгээр нь тодорхой асуудлаар адил саналтайгаа бичгээр илэрхийлсэн тохиолдолд хурал хийхгүйгээр уг асуудлаар шийдвэр гаргаж болно.

19.5. Удирдах зөвлөлийн хурал хийхгүйгээр гишүүдийн саналыг бичгээр авсаны үндсэн дээр шийдвэрлэж болох асуудлыг удирдах зөвлөл тогтооно.

## **20 дугаар зүйл. Удирдах зөвлөлийн дарга, гишүүний цалин, урамшуулал**

20.1. Удирдах зөвлөлийн дарга, гишүүд үүргээ гүйцэтгэснийхээ төлөө шашны байгууллагаас цалин, урамшуулал авахгүй.

## **21 дүгээр зүйл. Хяналтын байгууллага, түүний эрх, үүрэг**

21.1. Хяналтын байгууллага 3, түүнээс дээш гишүүнтэй байна.

21.2. Хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд шашны байгууллагын гүйцэтгэх удирдлага байхыг хориглоно.

21.3. Хяналтын байгууллага нь гүйцэтгэх удирдлагын болон шашны байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үндсэн үүрэгтэй.

21.4. Хяналтын байгууллагын бусад эрх, үүргийг шашны байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан дүрмээр тодорхойлно.

21.5. Хяналтын байгууллагыг мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэх удирдлага хариуцна.

## **22 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага**

22.1. Гүйцэтгэх удирдлага дараахь эрх, үүрэгтэй байна:

22.1.1. шашны байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

22.1.2. удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд шашны байгууллагын эд хөрөнгийг захиран зарцуулах;

22.1.3. шашны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх;

22.1.4. дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

22.2. Гүйцэтгэх удирдлагын тухайн шашны байгууллагын онцлогтой холбоотой бусад эрх, үүрэг болон хүлээх хариуцлага, хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл журам, ажлын хөлс, ажлын нөхцөл зэргийг түүний удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээгээр зохицуулна. Удирдах зөвлөлийн дарга гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулна.

## **23 дугаар зүйл. Шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газар**

23.1. Шашны байгууллага салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно.

23.2. Шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрыг байгуулахад энэ хуулийн 11.1-д заасны дагуу зөвшөөрөл авсан байна.

23.3. Шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд түүний эрх, үүргийг нь байгууллагын дүрмээр тодорхойлно.

23.4. Шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг тухайн байгууллагын дүрэмд заасан эрх бүхий байгууллага томилно.

23.5. Шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь гагцхүү түүнийг байгуулсан байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

23.6. Орон нутгийн шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь энэ хуулийн 8.5 дахь хэсэгт заасан тухайн шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах эрхтэй.

23.7. Төвлөрсөн шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг энэ хуулийн 23.2-т заасан зөвшөөрөлд тодорхойлсон байна.

23.7. Шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.



23.8. Гадаадын улсын шашны байгууллага нь салбар, төлөөлөгчийн газарт орон нутгийн шашны байгууллагын нэгэн адил шаардлага тавигдана.

23.9. Гадаадын улсын шашны байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрыг шашны асуудал эрхэлсэн зөвлөлөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллага бүртгэнэ.

## **24 дүгээр зүйл.Шашны байгууллагыг өөрчлөн байгуулах**

24.1. Шашны байгууллагыг түүний эрх барих байгууллагын шийдвэрээр хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулж болно.

24.2. Шашны байгууллага зохион байгуулалтын хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдахыг хориглоно.

24.3. Шашны байгууллагыг хуваах, тусгаарлах бол энэ хуулийн 11.1-д заасны дагуу зөвшөөрөл авсны үндсэн дээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

24.4. Шашны байгууллагыг өөрчлөн байгуулсан бол зохих журмын дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.

## **25 дугаар зүйл.Шашны байгууллагыг татан буулгах**

25.1. Шашны байгуулагыг дараахь тохиолдолд татан буулгана:

25.1.1. шашны байгууллагын удирдах зөвлөлөөс тухайн шашны байгууллага нь зорилгодоо хүрсэн буюу цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй болсон, эсхүл дүрэмд заасан бусад үндэслэлээр татан буулгах тухай шийдвэр гаргасан бол;

25.1.2. Эрүүгийн хуульд заасан татан буулгах албадлагын арга хэмжээ авагдсан;

25.1.3. дампуурсанд тооцсон;

25.1.4. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрлийг хүчингүй болгох эрх хасах шийтгэл оногдуулсан;

25.1.5. шашны байгууллагын зөвшөөрлийг цуцалсан;

25.1.6. хуульд заасан бусад.

25.3. Шүүх энэ хуулийн 25.1.3-т заасан шийдвэрийг Дампуурлын тухай хуульд заасан хариуцагч, нэхэмжлэгчийн хүсэлтээр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар, мөн хуулийн 25.1.2-т заасан шийдвэрийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмаар тус тус гаргана.

25.4. Энэ хуулийн 25.1.5-д заасан шийдвэрийг шашны асуудал эрхэлсэн зөвлөл, мөн хуулийн 25.1.4-т заасан шийдвэрийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай

хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8-д заасан эрх бүхий албан тушаалтан гаргана.

## **26 дугаар зүйл.Шашны байгууллагын зөвшөөрлийг цуцлах**

26.1. Шашны асуудал эрхэлсэн зөвлөл нь дараахь үндэслэлээр энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу шашны байгууллагад олгосон зөвшөөрлийг цуцлана:

26.1.1. энэ хуулийн 8.1-т заасан үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

26.1.2. энэ хуулийн 6.4.3, 6.4.4-т заасныг зөрчсөн бол.

26.2. Шашны байгууллагын эрхийг Шашны байгууллагын эрх олгох, цуцлах журмын дагуу цуцлана.

26.3. Шашны байгууллага нь энэ хуулийн 26.1-д заасны дагуу шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүхэд гомдол гаргах эрхтэй.

26.4. Энэ хуулийн 26.1-д заасны дагуу гаргасан шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн гаргасан шийдвэр нь тухайн шашны байгууллагыг татан буулгах үндэслэл болно.

## **27 дугаар зүйл.Шашны байгууллагад хориглох зүйлс**

27.1. Шашны байгууллага нь өөрийн зорилго, үйл ажиллагаагаараа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж зөрчихийг хориглоно.

27.2. Шашны байгууллага нь доор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

27.2.1. албадан гэрлүүлэх болон гэр бүлийг албадан салгахад чиглэгдсэн, эсхүл бөөнөөр гэрлэх үйл ажиллагаа явуулах, уриалах;

27.2.2. зайлшгүй эзэмших шаардлагатай суурь боловсрол эзэмшихэд нь саад болсон үйл ажиллагаа явуулах;

27.2.3. гишүүд, дагагчболон бусад этгээдийг өөрийн эрхээс татгалзуулж, шашны байгууллагад ашигтай байдал үүсгэхэд нь албадах;

27.2.4. шашны байгууллагад элсүүлэх, эсхүл гишүүнчлэлээс гарахгүй байх зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, иргэний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр хүндэд нь хохирол учруулахаар сүрдүүлэх, хууль бус бусад үйл ажиллагаа явуулах замаар саад болох;

27.2.5. шашны зан үйл, ёслол үйлдэхдээ хүрээлэн байгаа орчныг бохирдуулах;

27.2.6. хандив, тусламж, өргөл барьц барихыг шаардах, албадах;

27.2.7. сүсэг бишрэл болон эмзэг байдлыг нь ашиглан үзэл номлолоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх;

27.2.8. гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүждэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авах;

27.2.9. шашны үйл хэрэгтээ холбоотойгоор мансууруулах болон сэтгэцэт нөлөөт бодис ашиглах, садар самуун болон хууль бус бусад үйл ажиллагаа явуулах;

27.2.10. амиа хорлохыг уриалах, амиа хорлох байдлыг өдөөх, турхирах, шашны номлол, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал тогтоох, хүчирхийлэл үйлдэх, шашны сэдлээр амь нас, эрүүл мэндэд нь аюул учирсан этгээдэд тусламж үзүүлэхээс татгалзахыг номлох, уриалах;

27.2.11. энэ хуулийн 8.10.2, 8.10.3-т заасан хүнийг шашны байгууллагын гишүүнээр элсүүлэх, шашны байгууллагаас зохион байгуулах шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцуулах;

27.2.12. үндсэн хуульт тогтолцоо, төрийн байгууламжийг хууль бусаар, хүч хэрэглэн өөрчлөх, устгах зорилгоор шашны үйл ажиллагаа явуулах, энэхүү үйл ажиллагаа явуулахаар зохион байгуулах, бусдыг элсүүлэх;

27.2.13. шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, хэт даврах болон салан тусгаарлахыг ухуулах, уриалах зэргээр үндэсний эв нэгдлийг бусниулах үйл ажиллагаа явуулах;

27.2.14. харгис, хүмүүнлэг бус шашны сургаал, номлолыг дэлгэрүүлэх, шашны үйл ажиллагааг хүний эрхийг зөрчсөн, хууль бус бусад аргаар явуулах;

27.2.15. хуульд заасан бусад.

27.3. Шашны байгууллагын удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хяналтын байгууллагын дарга, гишүүн нь хувь хүн, байгууллагаас хувьдаа хандив авахыг хориглоно.

Тайлбар: - “харгис, хүмүүнлэг бус шашин” гэж дайн, террорист үйл ажиллагаа, хэт даврах буюу экстремист үйл ажиллагаа, садар самуун, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, ялгаварлан гадуурхах, хүний амь нас, эрүүл мэндийг хохироох зэрэг хууль зөрсөн хэлбэрээр зан үйл, ёслол үйлддэг, бусад шашныг үгүйсгэх, шашингүй үзлийг үл хүлээн зөвшөөрөх үзлийг уриалдаг, номлодог шашны үрсгал, чиглэлийг ойлгоно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**  
**ШАШНЫ ЗАН ҮЙЛ, ЁСЛОЛ, ШАШНЫ ҮЙЛ**  
**АЖИЛЛАГАА**

**28 дугаар зүйл.Шашны зан үйл, ёслолын ажиллагаа**

28.1. Шашны байгууллага нь олон нийт, сүсэгтэн олон, дагагч нартаа үйлчлэх зорилгоор шашны үйл ажиллагаа, тахилга, мөргөл залбиралын болон шашны цуглаан зохион байгуулах зориулалт бүхий тусгайлсан тахилын байр, хөшөө дурсгал, суварга, барилга байгууламж буюу сүм, хийд байгуулах эрхтэй.

28.2. Төрийн байгууллагын албан байранд шашны зан үйл, ёслол үйлдэх, сургалт, цугларалт зохион байгуулахыг хориглоно.

28.3. Шашны байгууллага нь иргэдийн хүсэлтээр эмнэлэг, сувилалын газар, хүүхдийн, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн газарт шашны зан үйл, ёслолыг тусгайлан энэ үйл ажиллагаанд зориулагдсан талбай, байр, өрөөнд үйлдэж болно. Энэхүү үйл ажиллагаа нь тухайн байгууллагын дотоод журамд нийцсэн байна.

28.4. Цагдан хорих байр болон хорих байгууллагад шашны зан үйл, ёслол үйлдэх харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, цагдан хорих болон хорих байгууллагын дотоод дүрэмд заасны дагуу зохицуулна.

28.5. Хууль, цэргийн дүрэмд өөрөөр заагаагүй бол цэргийн алба хаагчид мөргөл үйлдэх, шашны бусад зан үйл, ёслол үйлдэж болно.

28.6. Олон нийтийн газарт нийтийг хамарсан мөргөл, шашны бусад зан үйл, ёслол үйлдэх ажиллагаа нь олон нийтийн болон оролцогчдын аюулгүй байдлыг хангасан, холбогдох хууль тогтоомжоор тогтоосон журамд нийцсэн байна.

28.7. Энэ хуулийн 28.2-т заасан хориглолт нь боловсрол, соёл, урлагийн байгууллагад шашны түүх, соёл, өв уламжлалын тухай мэдлэг олгох шинжлэх ухааны сургалт, соёл, урлагийн арга хэмжээнд болон иргэний шашин шүтэх эрх чөлөөтэй байх эрхийг хангах зорилго бүхий мөргөлийн өрөө, тасалгааг байгуулахад үл хамаарна.

28.8. Шашны байгууллагаас бусад этгээд нийтэд зориулсан мөргөлийн газар, том орон зай эзлэх шашны зориулалт бүхий хөшөө дурсгал, суварга байгуулахыг хориглоно.

**29 дүгээр зүйл.Шашны ном, зохиол, шашны зориулттай эд зүйлс**

29.1. Хуульд өөрөөр заагаагүй бол шашны байгууллага нь шашны ном, зохиол, шашны зориулалттай хэвлэмэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг бүхий материал болон бусад эд зүйлсийг үйлдвэрлэх, олж авах, олон нийтийн хэрэгцээнд зориулж экспортлох, импортлох, түгээх эрхтэй.

29.2. Шашны байгууллага нь өөрийн дотоод хэрэгцээндээ зориулж шашны

ном, зохиол хэвлэх болон мөргөл, тахилын зориулалттай бусад зүйл үйлдвэрлэх нэгжтэй байж болно.

29.3. Төвлөрсөн шашны байгууллага нь олон нийтэд зориулж шашны ном, зохиол хэвлэх, мөргөл, тахилын зориулалттай бусад зүйл үйлдвэрлэж болно.

29.4. Төвлөрсөн шашны байгууллагаас бусад этгээд шашны ном, зохиол, шашны зориулалттай эд зүйлсийг олон нийтэд худалдах, түгээх зорилгоор хэвлэх, үйлдвэрлэх, экспортлох, импортлохыг хориглоно.

29.5. Шашны байгууллага нь өөрийн оноосон нэрийг үйлдвэрлэх, хэвлэх болон ухуулан элсүүлэх үйл ажиллагаандаа зориулж тараах ном, зохиол, бусад хэвлэмэл материал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг дээр дурдах үүрэгтэй.

### **30 дугаар зүйл. Шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа**

30.1. Шашны байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ болон бусад хууль ёсны аргыг ашиглан шашнаа ухуулан дэлгэрүүлж болно.

30.2. Төвлөрсөн шашны байгууллага нь шашин ухуулан дэлгэрүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллага байгуулж болно.

30.3. Энэ хуулийн 30.2-т заасан байгууллага нь шашны байгууллага гэсэн бүртгэлтэй байна.

30.4. Тухайн иргэн хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд иргэдийн орон сууцны байр, талбайд шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах, шашны ном, зохиол, шашны зориулалттай хэвлэмэл материал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон бусад эд зүйлсийг тараахыг хориглоно.

30.5. Шашны байгууллага бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд түүний байр талбай, эзэмшлийн газарт бусад шашны байгууллагаас шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

30.6. Шашныг ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг шашны байгууллагын нэрийн өмнөөс түүний удирдлага, гишүүн, эсхүл тусгайлан томилсон шашны байгууллагын номлол түгээгч явуулна.

30.7. Шашны байгууллага нь энэ хуулийн 30.6-д заасны дагуу шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах иргэнд тухайн шашны байгууллагыг төлөөлөх эрхтэйг нотолсон баримт бичгийг олгосон байна.

Тайлбар: - “шашны номлол түгээгч” гэж шашныг ухуулан дэлгэрүүлэх зорилгоор шашны сургаал, номлолыг түгээдэг, олон нийт, сүсэгтэн олон, дагагч нарт зориулж тухайн шашны зан үйл, ёслол, бусад үйл ажиллагааг гүйцэтгэдэг хүнийг ойлгоно. Шашны номлол түгээгч нь тухайн шашны онцлогоос хамаарч лам, хуврага, санваартан, пастер, бөө, удган зэрэг нэршилтэй байж болно.

30.8. Шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг дараахь газарт

чөлөөтэйгээр явуулж болно:

30.8.1. энэ хуулийн 28.1-д заасан зорилгоор байгуулсан тахилга, мөргөлийн барилга байгууламж, тэдгээрийн оршин байгаа газар;

30.8.2. шашны байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтанд байдаг барилга байгууламж, газар;

30.8.3. өмчлөгч, эзэмшигчийнх нь зөвшөөрлөөр бусдын эзэмшлийн барилга байгууламж, талбай, газар;

30.8.4. оршуулгын болон шарил чандарлах газар;

30.8.5. олон нийтийн эзэмшлийн газар, талбайд.

### **31 дүгээр зүйл.Шашны байгууллагын буяны болон соёл, гэгээрлийн үйл ажиллагаа**

31.1. Шашны байгууллага нь өөрөө шүүд болон буяны байгууллагатай хамтран буяны үйл ажиллагаа явуулж болно.

31.2. Шашны байгууллага нь буяны үйл ажиллагаа явуулах зорилгоор музей, номын сан, эмнэлгийн тусламж, үйлчилгээний болон асрамж, халамжийн байгууллагыг холбогдох хуульд заасны дагуу байгуулж болно.

31.3. Төрийн байгууллага шашны байгууллагын буяны үйл ажиллагаа болон соёл, гэгээрлийн төсөл, хөтөлбөрийг хууль тогтоомжийн хүрээнд дэмжих болон хамтран ажиллаж болно.

31.4. Энэ хуулийн 31.1-д заасны дагуу шашны байгууллагаас буяны үйл ажиллагаа явуулах үеэр болон энэ хуулийн 31.2-т заасан байгууллага нь шашны зан үйл, ёслол үйлдэх, шашин ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

### **32 дугаар зүйл.Шашны боловсролын байгууллага**

32.1. Шашны төвлөрсөн байгууллага нь энэ хуулийн 11.1-д зааснаас гадна боловсролын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр боловсролын байгууллага байгуулах эрхтэй.

32.2. Шашны сургууль нь шашны байгууллага гэсэн бүртгэлтэй байна.

32.3.Бага, суурь боловсрол олгож байгаа шашны боловсролын байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан цөм хөтөлбөрийн дагуу суралцагчдад суурь боловсролыг заавал олгоно.

32.4. Бүрэн дунд боловсрол олгож байгаа шашны боловсролын байгууллага нь ерөнхий боловсролыг суралцагчдад олгож болно.

32.5. Шашны боловсролтой холбоотой бусад харилцааг Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуулиар зохицуулна.

32. 6.Шашны номлол түгээгч нь суралцагчийн хүсэлтээр шашны боловсролыг гэрээр олгож болно. Шашны боловсролыг гэрээр олгохтой холбоотой харилцаанд энэ хуулийн 5, 27 дугаар зүйлийн зохицуулалт нэгэн адил үйлчилнэ.

### **33 дугаар зүйл.Олон улсын хамтын ажиллагаа**

33.1. Шашны байгууллага өөрийн үндсэн зорилгын дагуу олон улсын болон гадаад улсын байгууллага, хувь хүнтэй харилцах, хамтран ажиллах эрхтэй.

33.2. Мөргөлийн аян хийх, цуглаан, бусад арга хэмжээнд оролцох, шашны боловсролын үйл ажиллагаанд оролцох болон эдгээр зорилгоор гадаад улсын шашны байгууллагын төлөөлөгч болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг урих эрхтэй.

33.3. Шашны байгууллагад хөдөлмөр эрхлэх болон энэ хуулийн 33.2-т заасан зорилгоор уригдсан гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн<sup>6</sup> 15.1.9-д заасан ангилалын виз авсан байна.

33.4. Шашны байгууллага нь энэ хуулийн 12.3.3-т заасан үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллага, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцах, хамтран ажиллахыг хориглоно.

### **34 дүгээр зүйл.Шашны байгууллагын өмчлөх эрх**

34.1. Шашны байгууллага нь дүрэмдээ заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор үл хөдлөх хөрөнгө, шашны эд хэрэгсэл, мөнгөн хөрөнгө, болон түүх соёлын дурсгалт зүйлийг хуульд заасны дагуу өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй.

34.2. Шашны байгууллага нь өөрийн орлого, иргэн, байгууллагын хандив, өглөг, төрөөс тухайн шашны байгууллагад шилжүүлж өгсөн болон хуульд заасан бусад аргаар олж авсан, бий болгосон хөрөнгийг өмчлөх эрхтэй.

34.3. Мөргөлийн зориулалтай хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг зээлдүүлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах зорилгоор хураан авахыг хориглоно.

34.4. Энэ хуулийн 34.3-т хамаарах мөргөлийн зориулалттай эд хөрөнгийн жагсаалтыг шашны асуудал эрхэлсэн зөвлөл батлана.

34.5. Татан буугдсан шашны байгууллагын өмчлөлд байгаа мөргөл, тахилын зориулалттай монголын ард түмний түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл болон үл хөдлөх хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчлөлд, эсхүл ижил урсгал, чиглэлийн шашны байгууллагад шүтлэгийн зориулалттай өмчөөр шилжүүлж болно.

34.6. Шашны байгууллагын эзэмшил болон өмчлөлд байгаа түүх, соёлын хөдлөх болон үл хөдлөх дурсгалыг соёлын өвийн бүртгэлд бүртгүүлнэ.

---

<sup>6</sup> Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

### **35 дугаар зүйл.Шашны байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх**

35.1. Хуульд өөрөөр заагаагүй бол шашны байгууллага нь дүрэмдээ заасан зорилгын хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болно.

35.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх нь шашны байгууллагын үндсэн зорилго, гол үйл ажиллагаа байж болохгүй.

35.3. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийг тухайн шашны байгууллагын удирдлага гаргана.

35.4. Шашны байгууллагын аж ахуйн үйл ажиллагааны орлогод дараахь орлого хамаарна:

35.4.1. хандив, хөрөнгө цуглуулах зорилготой хариу төлбөртэй ажил, үйлчилгээний орлого;

35.4.2. дүрмийн зорилготой шууд холбоотой үйлчилгээний төлбөр;

35.4.3. өөрийн хөрөнгөө борлуулсан, түрээсэлсний орлого, хадгаламжийн хүүгийн орлого;

35.4.4.хуульд нийцсэн бусад үйл ажиллагааны орлого.

35.5. Шашны байгууллага нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхэд зориулан зарцуулна.

35.6. Шашны байгууллага нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үүсгэн байгуулагчид, гэрээгээр ажиллагсад болон бусад этгээдэд шууд буюу шууд бүс хэлбэрээр урамшуулал, ашиг болгон хуваарилахыг хориглоно.

### **36 дугаар зүйл.Шашны байгууллагын хөдөлмөрийн харилцаа**

36.1. Шашны байгууллагатай холбоотой хөдөлмөрийн харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

36.2. Шашны байгууллага нь байнгын ажлын байрыг дүрэмдээ тусгаж, тухайн ажлын байранд ажиллах иргэнтэй хөдөлмөрийг гэрээ байгуулна.

36.3. Шашны байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэл төлж байнгын ажлын байранд ажиллаж байгаа шашны номлол түгээгчийг тэтгэвэр, тэтгэмжид хамруулна.

36.4. Шашны байгууллага нь хариу төлбөргүй ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр сайн дурын ажилтанг үйл ажиллагаандаа оролцуулж болно.

36.5. Шашны байгууллагаас сайн дурын ажилтанд үйл ажиллагаа явуулахтай холбоотой болон тухайн хугацаанд ашиглах байр, тээвэр, харилцаа холбоо, хүнс,



зориулалтын хувцас хэрэглэл, хувийн хамгаалалт, эрүүл мэндийн даатгал, үйлчилгээний зардлыг олгож болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШАШНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ БУСАД ЗОХИЦУУЛАЛТ**

### **37 дугаар зүйл. Шашны үйл ажиллагаатай холбоотой бусад зохицуулалт**

37.1. Төрөөс шашны үйл ажиллагаатай холбоотой дараахь зохицуулалтыг хийнэ:

37.1.1. шашны байгууллагад татварын болон бусад хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх эсэх;

37.1.2. шашны байгууллагын өмчлөл, эзэмшилд байгаа түүх, соёлын дурсгалт барилга байгууламж, хөшөө дурсгал, бусад түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах, сэргээн засах үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх;

37.1.3. шашны боловсролын байгууллагад боловсролын хууль тогтоомж, боловсрол олгох нийтлэг стандарт хэрэгжиж байгаа эсэхийг хянах;

37.1.4. шашны үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;

37.1.5. монголын ард түмний эв нэгдэл, соёл, иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэх үүднээс уламжлалт шашны тэргүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс ёсчлох;

37.1.6. төрийн тахилгатай уул, овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолыг шашны байгууллагатай хамтран зохион байгуулах.

37.2. Монгол Улсад хутагт, хувилгаадыг тодруулах үйл ажиллагаа нь монголын уламжлалт шашны тэргүүнийн үйл ажиллагааны хүрээнээс ангид байж болохгүй.

37.3. Энэ хуулийн 37.1.5-д заасан харилцааг зохицуулсан журмыг шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн өргөн мэдүүлсэнээр, энэ хуулийн 37.1.6-д заасан төрийн тахилгатай уул, овооны жагсаалт, тэдгээрийн тэнгэрийг тайх тахилгын ёслол үйлдэх дэг, ёслолыг үйлдэх газар, санхүүжилт, төрийн оролцоо, шашны үйл ажиллагаа, лам хуврагыг оролцуулахтай холбоотой журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тус тус батална.

### **38 дугаар зүйл. Шашны байгууллагын санхүүжилт, тайлагналт**

38.1. Шашны байгууллагын санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

38.1.1. хууль, эсхүл дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй

холбоотой аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

- 38.1.2. хувь хүн, байгууллагын өгсөн хандив, тусламж;
- 38.1.3. шашны байгууллагын гишүүний татвар;
- 38.1.4. хууль тогтоомжийн дагуу олсон бусад эх үүсвэр.

38.2. Шашны байгууллага хуульд заасан журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.

38.3. Шашны байгууллага нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнээс мөнгөн болон бусад хөрөнгө, санхүүжилт авсан бол бодит зарцуулалт, ашиглалтын талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт өөрийн цахим хуудаст тухай бүр байршуулна.

38.4. Энэ хуулийн 38.3-т заасан хөрөнгө, санхүүжилтийн талаарх тайланг дараа жилийн 3 сарын 01-ний дотор багтаан шашны асуудал эрхэлсэн зөвлөлд гаргана.

38.5. Хувь хүн, хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандивыг зориулалтын дагуу хандив өгөгчийн заасан хугацаанд зарцуулах бөгөөд хэрэв хандив өгөгч зарцуулах тодорхой хугацаа заагаагүй бол хандивыг хүлээн авснаас хойш 1 жилийн дотор зориулалтын дагуу зарцуулна.

### **39 дүгээр зүйл.Шашны байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдал**

39.1. Шашны байгууллагын тэргүүн, удирдлага болон байнгын ажлын байр, түүнчлэн бусад гэрээний үндсэн дээр тухайн шашны байгууллагын нэрийн өмнөөс шашны зан үйл, ёслол үйлдэх болон шашны түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэх чиг үүрэг бүхий шашны номлол түгээгч, бусад ажилтны талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана.

39.2. Шашны байгууллага нь үйл ажиллагааны тайлангаа шашны асуудал эрхэлсэн зөвлөлд жилд нэг удаа энэ хуулийн 38.4-т заасан хугацаанд гаргана.

39.3. Шашны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргахтай холбоотой журмыг шашны асуудал эрхэлсэн зөвлөл батална.

39.4. Шашны байгууллага нь энэ хуулийн 38.4, 39.2-т заасан тайлангаа өөрийн цахим хуудсанд нээлттэй байршуулах бөгөөд бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж болно.

### **40 дүгээр зүйл.Шашны асуудал эрхэлсэн зөвлөл**

40.1. Дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд шашны асуудал эрхэлсэн зөвлөл ажиллана.

40.2. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнд прокурорын байгууллага,

гадаад харилцааны болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллага, татвар, Санхүүгийн мэдээллийн алба болон шашны байгууллага, шашин судлаачдын төлөөллийг оролцуулна.

40.3. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өргөн мэдүүлснээр Засгийн газар батална.

40.4. Шашны асуудал эрхэлсэн зөвлөл ажлын албатай байна. Ажлын албаны бүтэц, орон тоог дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

40.5. Шашны асуудал эрхэлсэн зөвлөл нь үйл ажиллагаагаа Засгийн газар болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд жил бүр танилцуулна.

40.6. Шашны асуудал эрхэлсэн зөвлөл нь энэ хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд тогтоол, зөвлөмж, даалгавар гаргана.

40.7. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

#### **41 дүгээр зүйл. Шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн бүрэн эрх**

41.1. Шашны асуудал эрхэлсэн зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

41.1.1. монголын ард түмний эв нэгдэл, соёлыг хадгалан бататгах үүднээс шашин хоорондын харилцааг зохицуулах;

41.1.2. шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй байх эрхийн ханган баталгаажуулах хууль эрх зүйн орчин боловсронгуй болгох санал боловсруулах;

41.1.3. шашны байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг цуцлах;

41.1.4. шашны байгууллагын бүртгэл, үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хүлээн авч хянах, хууль хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөмж, даалгавар өгөх;

41.1.5. шашны эрх, эрх чөлөөний хууль тогтоомжийн хэрэгжилтийн асуудлаар хяналт шалгалт явуулах, судалгаа хийх, санал дүгнэлт боловсруулж Засгийн газарт танилцуулах;

41.1.6. шашны байгууллага, шашны бүлэг болон шашин номлол түгээгчийн бүртгэл, үйл ажиллагааны талаар мэдээллийн сан хөтлөх, холбогдох асуудлаар олон нийтэд мэдээлэх;

41.1.7. энэ хуулийн 9.4-т заасан нэр ашиглах эрх болон шашны байгууллагын нэр, байршил өөрчлөх зөвшөөрөл олгох;

41.1.8. хуулиар эрх олгосны дагуу захиргааны хэм хэмжээний акт баталж, мөрдүүлэх;

41.1.8.хууль заасан бусад.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **42 дугаар зүйл.Шашны байгууллагад үл харьяалагдах шашны номлол түгээгч**

42.1. Монгол Улсын иргэн нь аль нэг шашны байгууллагад харьяалагдахгүйгээр шашны сургаал, үзэл номлол болон тухайн шашны зан үйл, ёслол гүйцэтгэх, шашныг дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулж болно.

42.2. Энэ хуулийн 42.1-д заасан шашны номлол түгээгчид энэ хуулийн 26 дугаар зүйлийн зохицуулалт нэгэн адил хамаарна.

42.3. Шашны номлол түгээгч нь эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдана.

### **43 дугаар зүйл.Шашны номлол түгээгч, шашны бүлэг, шашны байгууллагын талаархи мэдээллийн сан**

43.1. Зөвлөл нь шашны номлол түгээгч, шашны бүлэг, шашны байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаа болон санхүүжилтийн талаархи мэдээллийн сантай байна.

43.2. Энэ хуулийн 43.1-д заасан мэдээллийн санг хөтлөх, түүний мэдээллийг ашиглах, сангаас мэдээлэл өгөх журмыг шашны асуудал эрхэлсэн Зөвлөл батална.

### **44 дүгээр зүйл.Шилжилтийн зохицуулалт**

44. Энэ хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацаанд багтаан шашны байгууллагууд энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу зөвшөөрөл авч, улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлнэ.

44.2. Энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 1 жилийн хугацааны дараа дагаж мөрдөнө.

### **45 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

45.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

45.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

